

**СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ**

<b>САНХҮҮЖҮҮЛСЭН</b>	ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС
<b>ГҮЙЦЭТГЭСЭН</b>	МУИС, НИЙГМИЙН СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН
<b>ТӨСЛИЙН НЭР</b>	СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ
<b>ТӨСЛИЙН УДИРДАГЧ</b>	О.МӨНХБАТ Ph.D. ПРОФ, НСХ-ИЙН ЗАХИРАЛ
<b>БАГИЙН ГИШҮҮД</b>	Ц.БОЛД МА, Г.ТҮМЭННАСТ МА, М.БАТБААТАР МА, ТУСЛАХ АЖИЛТАН Б.КҮМСАЙ, П.ЦЭРЭНБАЗАР МАГИСТРАНТ
<b>ХЭРЭГЖИХ ХЭЛБЭР</b>	НИЙТ 4 ҮНДСЭН ЧИГЛЭЛ БҮХИЙ ТАВАН ҮЕ ШАТТАЙ НИЙГЭМ-УЛС ТӨРИЙН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ
<b>ХАЯГ</b>	ИХ СУРГУУЛИЙН ГУДАМЖ, ХИЧ 2 БАЙР ӨРӨӨ 258, утас 314326, факс 976-11-328890, e-mail address <a href="mailto:mn_soc@yahoo.com">mn_soc@yahoo.com</a> , soc_ins@num.edu.mn

**‘Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал’  
мониторинг судалгааны товч хөтөлбөр**

**Мониторинг судалгааны үндэслэгээ**

Монгол Улсын иргэний хуулиар эдлэх эрх, эрх чөлөөний салшгүй бүрэлдэхүүн хэсэг болох сонгох, сонгогдох эрх нь ‘Засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна’ хэмээн заасан Үндсэн Хуулийн заалтыг хэрэгжүүлэх үндсэн нөхцөл нь болдог.

Чухамхүү эл эрхээ эдэлснээр Монгол улсын иргэд нийтийн засаглах үйл хэрэгт шууд байдлаар буюу эс бөгөөс сонгосон төлөөлөгчөөрөө дамжуулан гар бие оролцох боломжтой болдог байна.

Эдгээр эрхийн хэрэгжилт нь бүх нийтийн, чөлөөтэй, ардчилсан сонгууль явагдаж чадаж буй эсэхээс голлон шалтгаалдаг бөгөөд ардчилсан нийгэм байгуулах явцад эл сонгуулийн зарчмаар Монголчууд бид хууль тогтоох дээд байгууллага УИХ болон бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг хэдэнтээ сонгож эдүгээг хүрчээ.

Үүний зэрэгцээ ардчилсан сонгуулийн эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх, түүнийг ёсчлон мөрддөг, дээдэлдэг нийгэм улс төрийн соёл, менталитет төлөвшүүлэх, сонгуулийн субъектүүдийн үйл ажиллагааны соёлжсон хэв загварыг бий болгох нь манай орны хувьд тулгамдсан асуудал хэвээр байгаа юм.

Сонгуулийн эрүүл саруул ийм орчин бий болгох чиглэлээр хийгдэж буй эрэл хайгуул нь ардчилал хөгжсөн улс орнуудын туршлага судлах, тэдний эрх зүйн актуудыг хөрвүүлэн хэрэглэх төдийгөөр хязгаарлагдах ёсгүй агаад өөрийн орны бодит байдал, хуримталсан туршлага, сургамж, цаашдын төлөв хандлагыг шинжлэн дүгнэх явдал тэргүүлэх ач холбогдолтой билээ.

Тиймээс УИХ ба бүх шатны орон нутгийн сонгуулийн явцад сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн өнөөгийн төлөв байдлыг судлан, сонгуулийн эрх зүйн болоод социаль орчинг боловсронгуй болгох талаар шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт, санал зөвлөмж гаргах нь зайлшгүй шаардлагатай юм.

Чухам үүгээр Монголын Хүний Эрхийн Үндэсний Комиссоос МУИС – ийн Нийгмийн Судалгааны Хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлсэн ‘Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал’ мониторинг судалгааны **тулгамдсан, зайлшгүй шинж** тодорхойлогдож байгаа юм.

**Судалгааны сэдвийн судлагдсан байдал**

Монголын Хүний Эрхийн Үндэсний Комиссоос МУИС –ийн Нийгмийн Судалгааны Хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлсэн ‘Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал’ судалгааны сэдэвтэй шууд ба дам байдлаар холбогдох олон тооны судалгааг нэрлэж болно.

Эдгээрээс МУИС-ийн Социологийн тэнхим ба Нийгмийн Судалгааны Хүрээлэнгээс эрхлэн хэрэгжүүлсэн судалгаануудыг тоймлон толилуулбал дараах байдалтай байна. Үүнд:

МУИС. Нийгмийн Судалгааны Хүрээлэн

1. "Ерөнхийлөгчийн Сонгууль ба ОНСБ" 1997 он,
2. "УИХ-ын 2000 оны Сонгууль" төсөл
3. Авилгалтай тэмцэх Үндэсний Хөтөлбөрийн Хэрэгжилт. Мониторинг судалгаа. 2003-2004
4. "Гэр бүлийн харилцаан дахь уламжлал, шинэчлэл" 2001 он
5. Шилжилт хөдөлгөөн ба Хүүхдийн боловсрол. Суурь судалгаа. 2004 он
6. УИХ –ын 2004 оны Сонгууль. 2003 он
7. Орон нутгийн хөгжлийн цогц асуудал. Суурь судалгаа. 2004 он

### **Мониторинг судалгааны зорилго, зорилт**

Энэхүү мониторинг судалгааны гол зорилго нь Монголчуудын сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийг шинжлэх ухааны орчин үеийн арга зүй, аргачлалын тусламжтай судлан шинжлэх замаар түүний бодит байдлыг тодорхойлж, авч хэрэгжүүлэх зайлшгүй арга хэмжээний талаарх санал зөвлөмж боловсруулахад оршиж байлаа.

Эл зорилгодоо хүрэхийн тулд

- Сонгох, сонгогдох эрхийн эрх зүйн орчинг тодорхойлох үүднээс Олон улсын хууль, гэрээ, хэлэлцээр болон Үндэсний эрх зүйн актуудад контент анализ хийх
- Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтэнд нөлөөлөх хүчин зүйлсийн анализ буюу сонгуулийн хороод байгуулах, сонгогчдыг шаардлагатай мэдээллээр хангах, нэрсийн жагсаалт гаргах, сонгуулийн сурталчилгааны явц, сонгогчид нууцаар, чөлөөтэй саналаа өгөх нөхцөл зэргийг шинжлэх болон
- Иргэдийн сонгох, сонгогдох эрхийг зөрчих, бүрэн утгаараа хэрэгжих явцад учирч буй бэрхшээл, хүндрэлийг тодорхойлох үүднээс иргэд, нэр дэвшигчид, улс төрийн нам эвслээс гаргаж буй өргөдөл, гомдолд шинжилгээ хийх
- Сонгуулийн талаарх олон нийтийн санал бодол, тэдний үнэлэмжийг тодруулах

зэрэг хүчин зүйлсийг чанарын ба тоон судалгааны аргаар судлах зорилт тавин хэрэгжүүллээ.

### **Үндсэн ойлголт, ухагдхууныг тайлбарлах нь**

Нийгмийн судалгаа, шинжилгээний үндсэн хэрэглэгдэхүүн нь хүний өдөр дутмын үг ярианд хэрэглэгддэг үг, нэр томъёо, ойлголт ухагдахуун байдаг тул хүмүүс ганц үгэнд гэхэд л хэдэн янзын утга, санаа, ач холбогдол шингээн ашиглах нь буй.

Иймээс аливаа судалгаанд өргөн хэрэглэгдэж буй ойлголт ухагдахууныг нэгэн утга санаагаар, тайлбарлах нь чухал байдаг агаад бид хуульд буусан утгаар нь авч хэрэглэлээ.

#### **Сонгох, сонгогдох эрх – (МУ-ын Үндсэн Хууль 2 бүлэг 16 зүйл. 9 заалт)**

Шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй.

#### **Сонгууль – (Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн Хууль. 1 бүлэг.**

##### **1 зүйл. 1 заалт)**

1. Монгол улсын үндсэн хуульд заасан ёсоор Улсын Их Хурлын гишүүний Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж сонгоно.

##### **Сонгогч саналаа гаргах (мөн тэнд 7.35. 2)**

2. Сонгогч саналын хуудсыг авч санал бэлтгэх тасалгаанд орж, уг хуудсанд бичигдсэн нэр дэвшигчдийн дотроос өөрийн сонгохыг хүссэн зөвхөн нэг нэр дэвшигчийн овог, нэрийн өмнөх дугаарыг дугуйлан тэмдэглээд саналын хайрцагт хийнэ.

**Сонгуулийн насны иргэн – (мөн тэнд 1.1. 2)**

3. Улсын Их Хурлын сонгууль /энэ хуульд цаашид "сонгууль" гэнэ/ бүх нийтийн байна. Санал авах өдөр эх орондоо байгаа, Монгол Улсын арван найман насанд хүрсэн иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол ялгаваргүйгээр сонгох эрхтэй. Гагцхүү эмнэлгийн дүгнэлт, шүүхийн шийдвэрээр ухаан солиотой нь нотлогдсон, түүнчлэн хорих газар ял эдэлж байгаа хүн сонгуульд оролцохгүй.

Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно.

**Сонгуулийн хороод- ( мөн тэнд 3.1.2)**

1. Сонгуулийг улс, тойрог, хэсгийн хэмжээнд сонгуулийн хороод эрхлэн явуулна.

2. Сонгууль бэлтгэн явуулахад төрийн төв, орон нутгийн байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу оролцоно.

1. Сонгууль бэлтгэн явуулах ажлыг эрхлэн хэрэгжүүлэхийн тулд:

а/ Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн Ерөнхий Хороо

б/ Сонгуулийн тойргийн хороо

в/ Сонгуулийн хэсгийн хороог тус тус байгуулна.

2. Сонгуулийн тойргийн хороо нь сум, шаардлагатай бол нийслэлийн дүүрэгт тойргийн салбар хороог байгуулж ажиллуулна.

**Ажиглагч-(мөн тэнд 7.34.2)**

1. Ажиглагч нь сонгуулийн тойргийн буюу эсхүл салбар хороонд бүртгүүлж үнэмлэх авна. Ажиглагч сонгогчдын санал авах, санал тоолох, дүн гаргах үед уг ажлыг сонгуулийн хууль тогтоомжийн дагуу явуулж байгаа эсэхийг зөвхөн хөндлөнгөөс ажиглан хянах эрхтэй бөгөөд сонгуулийн хороодын үйл ажиллагаанд хутгалдан оролцож болохгүй. Гадаадын ажиглагч оролцуулах асуудлыг Сонгуулийн ерөнхий хороо төрийн гадаад харилцаа эрхэлсэн байгууллагуудтай зөвшилцөн шийдвэрлэнэ.

**Санал өгөх байр-1.5.4**

1. Сонгуулийн хороодын ажиллах, санал авах байрыг улс, орон нутгийн төсөвт болон төрийн өмчит байгууллагууд үнэ хөлсгүй гаргаж өгнө. Сонгуулийн тойрог, тойргийн салбар, хэсгийн хороодыг ажлын байр, тээвэр, холбооны болон бусад шаардлагатай хэрэгслээр хангах асуудлыг тухайн шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга хариуцна.

2. Сонгогчдын саналыг санал авах өдөр 07 цагаас 22 цаг хүртэл хугацаанд санал авах байранд авна. Сонгогчдын санал авах өдөр, цаг, байрыг сонгуулийн хэсгийн хороо уул өдөр хүртэлх 14 хоногийн турш нийтэд зарлан мэдээлнэ.

3. Сонгогчдоос саналаа нууцаар бэлтгэхэд хүрэлцэх тооны тасалгаа, саналын хайрцаг бүхий байрыг тухайн сонгуулийн хэсгийн харьяалагдах сум, дүүргийн Засаг дарга хариуцаж бэлтгүүлнэ.

**Зөөврийн хайрцагар санал авах-7.35.1**

1. Сонгогч санал авах байранд ирж саналаа өөрөө гаргана. Харин биеийн эрүүл мэндийн байдлаас болон хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас санал авах байранд хүрэлцэн ирж чадахгүй сонгогчийн саналыг түүний хүсэлтээр сонгуулийн хэсгийн хорооны хоёроос доошгүй гишүүн очиж битүүмжилсэн хайрцагар авна.

### **Судалгааны шинэлэг тал**

Энэхүү судалгаа нь мониторингийн, ахисан түвшний шинжтэй агаад зөвхөн Орон нутгийн төдийгүй УИХ –ын сонгуулийн үеэрх иргэдийн сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдлыг

1. Сурталчилгаанаас аваад дүнг зарлах хүртэлх сонгуулийн бүх шатыг хамарснаараа цогц шинжтэй,
2. Иргэний сонгох, сонгогдох эрхийг социологийн судалгааны тоон ба чанарын шинжилгээний аргуудыг хослуулан хэрэглэж судалсан,
3. УИХ болоод Орон нутгийн сонгуулийг хамарч байгаагаараа онцлог зэрэг шинжээрээ өмнө хийгдсэн шинжилгээ судалгаанаас өвөрмөц, шинэлэг судалгаа болж байгаа юм.

### **ТӨСЛИЙН СУДАЛГААНЫ АНХДАГЧ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГУУД**

Судалгааны анхдагч мэдээллийг чанарын болон тоон шинжилгээний аргуудыг ашиглан цуглууллаа.

#### **Чанарын судалгаа нь**

1. Бичиг баримт судлах, контент анализ / content analyze /
2. Ярилцлага, Бүлгийн ба Экспертын Ярилцлага / focus group /
3. Жишээ судлал / case study /
4. Ажиглалт гэсэн үндсэн аргуудаас бүрдлээ.

#### **Тоон судалгаа нь**

Анкетийн судалгаа

Стандартчлагдсан асуулга хэлбэрээр хэрэгжлээ

**Тоон судалгааны түүвэр**

Тоон судалгааг Улаанбаатар хотын дөрвөн дүүрэг, Ховд, Дорнод, Өмнөговь аймгийн төвүүд болон Дархан хотын сонгуулийн насанд хүрсэн оршин суугчдын дунд явууллаа.

Судалгааны түүврийн эх олонлог нь 1. буюу Монгол улсын сонгуулийн насанд хүрсэн бүх иргэд.

Түүврийн хэмжээ нь 1045.

Түүврийн нэгж нь аймаг, нийслэл, сум, дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин сууж байгаа, сонгуулийн санал авах өдөр 18 нас хүрсэн, Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн болно.

Санамсаргүй түүврийн хэлбэрээр түүврийн нэгжийг тогтоосон болно.

Хүний Эрхийн Үндэсний Комиссын захиалгаар МУИС-ын Нийгмийн Судалгааны Хүрээлэнгээс эрхлэн явуулсан “Сонгох, сонгогдох эрхийн төлөв байдал” сэдэвт судалгааны хүрээнд хот хөдөөгийн 1000 гаруй сонгогчдын санал бодлыг анкетын аргаар судалсан юм.

Судалгааны түүвийн хэмжээг

$$n=(t_a^2*p*q)/\varepsilon^2$$

томъёогоор тогтоов. Үүнд:

n - түүврийн хэмжээ

1- $\alpha$  - итгэх магадлал

$\varepsilon$  - түүврийн алдаа

$t_a$  - Студентийн тархалтын критик утга

p - орон нутгийн сонгуульд оролцогчдын хувийн жин

q =1-p

**Иргэдийн сонгуульд оролцсон байдал:**

Сонгуулийн төрөл		Он	Нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдын тоо	Санал өгсөн сонгогчдын тоо	Хувь
УИХ-ын сонгууль	1	1992	1085129	1037392	95.6%
	2	1996	1147260	1057189	92.15%
	3	2000	1247033	1027985	82.43%
	4	2004	...	...	...
Ерөнхийлөгчийн сонгууль	1	1993	1106403	1025970	92.73%
	2	1997	1155228	982640	85.06%
	3	2001	1205885	1000110	82.94%
Орон нутгийн сонгууль	1	1996	1028216	739946	71.96%
	2	2000	1066147	647616	<b>60.74%</b>
	3	2004	...	...	...

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. Хүснэгт 1

Дээрх томъёонд итгэх магадлалыг 0.95 буюу  $\alpha=0.05$ , түүврийн алдааг 0.03,  $p=0.61$  гэж сонгон тооцож түүврийн зохимжтой хэмжээг 1015 гэж тогтоосон болно. Түүврийн хэмжээг тогтоох үед Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль хараахан явагдаагүй байсан учраас 2000 оны сонгуулийн оролцооны хувийг сонгуульд оролцогчдын хувийн жин болгож сонгон авсан юм.


Судалгаанд олон шатат түүврийн аргыг ашигласан бөгөөд зүүн аймгуудын төлөөлөл болгон авсан Дорнод аймгаас 112, өмнөд аймгуудын

төлөөлөл Өмнөговь аймгаас 117, баруун талаас Ховд аймгаас 110 анкет, хойд зүгийн Дархан-Уул аймгаас 159 респондентийг санамсаргүй түүврийн аргаар сонгож анкетын судалгаанд хамрууллаа. Харин Улаанбаатарт түүврийн тоог 500-гаар тогтоож, Хан-Уул, Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх дүүрэг тус бүрээс 125 сонгогчийг санамсаргүй түүврийн аргаар сонгож судалгаанд хамруулав.

Судалгаа явуулсан газрууд	Төлөвлөсөн түүврийн тоо	Эрсдлийн нөөц	Судалгааны түүврийн тоо	Зөрүү
1 Сонгино хайрхан	125	5	126	+1
2 Хан уул	125	5	126	+1
3 Баян гол	125	5	125	0
4 Баянзүрх	125	5	125	0
5 Өмнөговь	115	5	117	+2
6 Ховд	115	5	110	-5
7 Дархан	160	5	159	-1
8 Дорнод	115	5	112	-3
Total	1005	40	1000	

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. Хүснэгт 2

Цуглуулсан мэдээллээс 1000 ширхэг анкетийг ялган авч эцсийн боловсруулалтад орууллаа. Судалгаанд хамрагдагсдын 48.1% нь эрэгтэй, 51.9.% эмэгтэй байгаа нь улсын дундажтай таарч байгаа юм.



“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. График 1


Насны бүлгээр авч үзвэл бага зэргийн хэлбэлзэлтэй зүйл бий. Дээрх нас хүйсийн суваргаас үзвэл судалгаанд хамрагдагсдын дунд хамгийн их жин дарж буй бүлэг нь 20-24 насныхан байна.

Бид насыг бүлэглэхдээ статистикийн мэдээллүүдтэй харьцуулахын тулд ихэнхи статистикийн мэдээлэлд ашигладаг 5 урттай тэнцүү интервалыг ашигласан.

Нэгэнт сонгогчдын санал бодлыг судалж байгаа учраас Монгол улсын сонгуулийн насанд хүрсэн /18 насанд хүрсэн/ иргэдийг судалгаанд хамруулсан бөгөөд хамгийн эхний интервалыг 18-19 гэж сонгож авсны улмаас энхүү интервал дахь респондентуудын тоо харьцангуй бага гарчээ.



Насны зарим интервал дахь респондентуудын эзлэх хувь Монгол улсын статистикаас бага зэрэг зөрж байгаа боловч түүврийн бүтцийг ерөнхийдөө шаардлага хангана гэж үзлээ.



“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. График 2

### **Чанарын судалгааны түүвэр**

Чанарын судалгааны түүврийг экспертийн, кэйс судлал, бүлгийн ярилцлага гэсэн судалгааны аргуудтай уялдуулан хийлээ.

### **Анхдагч мэдээллийг боловсруулсан арга**

Мониторинг судалгааны анхдагч мэдээллийг олон улсын стандартад нийцсэн мэдээллийн бааз үүсгэж хадгалав.

Судалгааны мэдээллийг боловсруулахдаа SPSS-11.5 программыг ашигласан бөгөөд мэдээлэлд дан ба харьцуулсан тоололт, бүлэглэлт хийж, дисперс, корреляцийг бодох замаар хамаарал, хүчин зүйлийн шинжилгээг хийж гүйцэтгэв.

## “СОНГОХ, СОНГОГДОХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ” СУДАЛГААНЫ ТАЙЛАН

### Удиртгал

Монгол улсын иргэний эдлэх ёстой аливаа эрх нь тус улсын нэгдэн орсон олон улсын болоод үндэсний хууль, эрхийн актуудаар баталгааждагийн нэгэн адил иргэдийн сонгох, сонгогдох эрх Үндсэн хууль ба бүх шатны сонгуулийн хуулиар баталгаажин бүх ард түмний сонгуулиар дамжин хэрэгждэг.

Иймд эл эрхийн бүрэн дүүрэн, шударга хэрэгжих үндсэн нөхцөл нь сонгууль, түүнийг зохион явуулах үйл ажиллагаатай шууд холбоотой юм.

Сонгууль нийгэм улс төрийн нэгдмэл үйл явц хэдий ч өөрсдийн судалгааны хүрээнд эмпирик байдлаар судлах үүднээс

- Эхэн буюу бэлтгэл
- Дунд буюу санал хураах
- Төгсгөл буюу дүнг тоолох

гэж хуваан, үе шат бүрд сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдлыг дүгнэн шинжиллээ.

Эхэн буюу бэлтгэл үе шатанд сонгуулийн хороод байгуулах, нэр дэвшигчдийг бүртгэх, сонгогчдын нэрсийн жагсаалт гаргах болон нэр дэвшигчид, нам эвслийн сурталчилгааг багтаан үзлээ.

Дунд буюу санал авах шатанд саналын байр, нууцаар санал гаргах, зөөврийн хайрцгаар санал авах нөхцөл, ажиглагчдын үйл ажиллагаа зэргийг хамруулав.

Төгсгөлийн шатанд санал тоолох, сонгууль, санал хураах үйл явцтай холбогдсон санал гомдол зэргийг хамруулан үзэж анализ хийлээ.

## Нэгдүгээр бүлэг: Сонгох, Сонгогдох эрх ба Сонгуулийн бэлтгэл үе шат

### Сонгуулийн тойрог, хэсгийн хороо байгуулах үйл явц

Сонгуулийг шударгаар зохион байгуулах, иргэдийн сонгох, сонгогдох эрхийн шударга хэрэгжилтын үндсэн, суурь нөхцлийн нэг бол сонгуулийн тойрог, хэсгийн хороодыг хуулийн дагуу байгуулах явдал юм.

УИХ-ын болоод орон нутгийн Сонгуулийн хуулинд

УИХ-ын болоод орон нутгийн сонгуулийн үеэр хороодыг байгуулах, нам эвсэл, нас бусчуудын төлөөллийг хангах зэрэг үйл ажиллагаанд хүний сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт ямаршуу байдалтай байгаад дүн шинжилгээ хийлээ.

Нийгмийн Судалгааны Хүрээлэн (НСХ)-гээс хэрэгжүүлсэн судалгааны дүнд үндэслэн эл чиглэлээр гардаг нийтлэг зөрчлийг

- Нам эвсэл, нам бусчуудын төлөөллийн тэнцвэртэй байдал алдагдах, хороодыг хуульд заасан хугацаанаас хоцорч байгуулах
- Нам эвслүүд нам бусчуудын төлөөллийг оруулахад саад тотгор учруулж, хориг саад тавих,
- Сонгуулийн хороонд ажилласан хүмүүс илүү цагаар болон ажлын бус өдрүүдэд ажилласныхаа хөлсийг авч чаддаггүй зэргээр тэдний эдийн засгийн баталгаа алдагдах нөхцөл бүрддэг

зэргээр бүлэглэн ангилж болох юм.

*Ерөөсөө СХХороо байгуулагдах үеэс л хүний сонгох, сонгогдох эрх зөрчигдсөн гэж үзэж болно. Бүрэлдэхүүнд гэхэд дан МАХН-ыхан, нам бусчууд гэсэн нэрийн дор бүгдээрээ энэ намынхан. Манайхаас ердөө гуравхан хүн байгаа. Нийслэлийн ИХТ-ын 1 –р тойрог. Кэйс. Эх орон-Ардчилал Эвслийн ажиглагч.*

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” чанарын судалгаа. НСХ 2004 он

Эхний зөрчил нь голлон нам бус гэдэг нэрийн дор аль нэгэн намд гишүүнчлэлтэй хүн бүртгүүлэх тохиолдлоор илэрдэг аж.

Хэдийгээр энэ тухай нам эвсэл, нэр дэвшигчдээс цөөнгүй санал, гомдол ирдэг ч холбогдох хуульд энэ талаар “..тойрог хэсгийн хороодын дарга, н.б.дарга, гишүүд ..нэр дэвшигч байж болохгүй” гэснээс өөр тодорхой заасан зүйл үгүй тул үүнийг зохицуулах, шийдвэрлэх боломжоор хомс байна.

Харин Монгол улсад хүний эрхийг хангах хөтөлбөрт “ Сонгуулийн.. хороодын бүрэлдэхүүнд .. аль нэг нам эвслийн төлөөлөл давамгайлахыг хязгаарлана” /УИХ-ын 2003 оны 10-р сарын 24 –ний 41 –р тогтоолоор батлагдсан/ гэж заасан нь бий хэдий ч энэ бол хууль биш тул заавал даган биелүүлэх албагүй аж.

*Бидний ажиглалтаар нам бус гэж бүртгүүлсэн 7 хүний тав нь МАХН –ын гишүүн идэвхтэй дэмжигч байсан нь ажиглагдсан. УБ. Баянзүрх. Ажиглалт.*

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” чанарын судалгаа. НСХ 2004 он

Түүнчлэн хуульд зааснаар сонгуулийн бүх шатны хороодын дарга, н.б.дарга, гишүүд нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар сурталчилгаа хийх хориотой авч, нэг гэр бүлийн хүмүүсийн нэг нь нэр дэвшиж, нөгөө нь сонгуулийн хороонд ажиллах тохиолдол цөөнгүй /ялангуяа орон нутагт/ байгаа нь эл заалтыг зөрчих үндсийг бүрдүүлж байна.

**/ Энд болон үүнээс хойшхи ХЭК –ийн төлөөлөгч гэсэн тэмдэглээтэй мэдээлэл нь ХЭҮК –ийн аймгууд болон томоохон хотууд дахь Хүний Эрхийн Итгэмжлэгдсэн Төлөөлөгчдийн авсан чанарын судалгааны дүн болно. /**

*Нөхөр нь тухайн тойрогт нэр дэвшиж байхад, эхнэр нь тэндэхийн сонгуулийн тойргийн хороонд ажиллаж байна.Энэ тохиолдол яаж хуулийн заалт хэрэгжих вэ дээ. Кэйс.Говь сүмбэр. ХЭК-ийн төлөөлөгч*

*Дүү нь нэр дэвшсэн тойргийн хэсгийн хороонд төрсөн эгч нь ажиллаж нэрсийн жагсаалт хянах, саналын хуудас тараах ажилд томилогдсон байсан. Увс. ХЭК-ийн төлөөлөгч*

Үүний зэрэгцээ сонгуулийн хороодыг хууль заасан хугацаанаас хэд хэдэн хоногоор хоцроож байгуулах нь түгээмэл байдаг нь ХЭК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн болоод НСХ –ийн судалгаанаас харагдаж байна.

*Энэ удаагийн орон нутгийн сонгуулийн үйл ажиллагаанаас харахад сонгуулийн хэсгүүд хуульд заасан хугацаанаас даруй 9-13 хоног хэтэрч байгуулагдсан. Дундговь. ХЭК –ийн төлөөлөгч*

Хугацаа бачим орон нутгийн сонгуулийн үед ийн хоцорч хороо байгуулагдах нь гишүүдийн дунд сургалт явуулах, ажил үүрэгтэйгээ танилцах зэрэгт муугаар нөлөөлж улмаар зөрчил гаргах нөхцөл бүрдүүлж байгаа нь анхаарууштай зүйл юм.

Нэгэнт эрх зүйн орчин ийм тодорхой бус тул сонгуулийн хороод аль нэгэн улс төрийн хүчин, нэр дэвшигчийг талархан дэмжигчдээс дагнан бүрдэхгүй гэсэн баталгаа үгүйн зэрэгцээ эл цоорхойг нөлөө бүхий нам, эвслүүд ашиглан хороодын бүрэлдэхүүнийг хоорондоо хуваах, нам бусчуудын харьяаллыг хасах зэргээр хүний сонгох, сонгогдох эрхийг зөрчсөн бас нэгэн зөрчлийг бий болгодог болж байгаа нь энэ удаагийн орон нутгийн сонгуулиар ажиглагдаж байлаа.

*МАХН, Эх орон-Ардчилал Эвслийн тохиролцсон ёсоор сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга хоёр нь энэ хоёр намаас төлөөлөлтэй байгаа. Нам бусчууд болоод өөр бусад нам эвслээс хүн байхгүй. Бүрэлдэхүүний талаар ямар нэг маргаан гараагүй.Кэйс, Сонгуулийн хэсгийн хорооны н.б. дарга. Өмнөговь*

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” чанарын судалгаа. НСХ 2004 он

Хэдийгээр нам эвслийн тохиролцож байгаа нь хууль зөрчөөгүй мэт авч, үнэн хэрэг дээрээ хуйвалдаан мэт агаад намын харьяалалгүй сул иргэн болоод өөр бусад жижиг намын гишүүдийн сонгох, сонгогдох эрхийг зөрчиж буй нэгэн хэлбэр гэж хэлж болно.

*УИХ-ын сонгуулийн үеэр манай аймагт сонгуулийн хороонд ажиллаж байсан МАХН, Эвслийн гишүүн хоёр нөхөр тохиролцоод зөвөрийн хайрцагар санал авах хуудсаа тэнцүү тоогоор хувааж өөрийн намаас нэр дэвшигчдийн нэрийг дугуйлчихсан явдал гарсан. Кэйс.Увс, ХЭК –ийн төлөөлөгч.*

УИХ хийгээд орон нутгийн сонгууль бол нам, эвслийн гишүүдийн сонгууль бус монголын бүх ард түмний хүсэл зоригийн илэрхийлэл тул түүнийг эрхлэн явуулж, төрийг төлөөлөх үүрэг бүхий сонгуулийн хороодыг байгуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгож, иргэдийн эрхийг тэгш, шударгаар хангах асуудал тулгамдсан шинжтэй болж байна.

Сонгуулийн хороодыг байгуулах явцад гардаг өөр нэгэн хүндрэлтэй зүйл бол боловсон хүчний хомсдол, тэнд ажиллах хүмүүсийн сонгуулийн

талаарх мэдлэг боловсрол, эдийн засгийн болоод эрх зүйн баталгааны тухай асуудал аж.

Шударга, иргэний үүрэг хариуцлагаа ухамсарладаг жирийн иргэдийг сонгуулийн хороодын үйл ажиллагаанд татан оролцуулах хөшүүрэг, механизмгүй, магадгүй янз бүрийн түвшний эрх мэдэлтэнгүүд хүсдэггүйгээс энд ажиллах хүнийг зөвхөн нам эвслийн гишүүд, эс бөгөөс төр засаг, төсвийн байгууллагад ажилладаг цөөн бүлэг хүмүүсээс эрж хайдгаас улбаалан эл хүндрэл зонхилон гардаг нь судалгааны явцад ажиглагдаж байлаа.

*...хэсгийн хороонд сонгогдсон хүмүүс элдэв шалтаг заан оролцдоггүй сольж өөрчлөхөд хүрдэг эсвэл орсон нэг нь ажилд их хойрго ханддаг. Архангай. ХЭК-ийн төлөөлөгч*

Ялангуяа орон нутгийн сонгуулийн үед хороод байгуулахад хамгийн бэрхшээлтэй асуудал нь боловсон хүчин буюу чадварлаг, боловсролтой хүмүүс дутагддаг явдал аж.

*Гайгүй гэсэн хэд нь нэр дэвшээд тэгээд л бараг олдсон хүмүүсээ ажиллуулахад хүрдэг. Ялангуяа тойрог хэсгийн хороонд яг газар дээр нь ажиллаж байгаа хүмүүс асуудал шийдэх чадваргүй бүх юмаа дээд шатны хороо руу явуулдагаас ажил алдагдаж хүмүүс чирээддэг. Мөн хийх ажлаа сайн мэддэггүй учраас санамсаргүй алдаа гаргаж хүний эрх зөрчих тохиолдол их гардаг. Экспертийн ярилцлага. Өмнөговь.*

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” чанарын судалгаа. НСХ 2004 он

Түүнчлэн сонгуулийн хороодын үйл ажиллагааны эдийн засгийн баталгааг төр дааж “Сонгуулийн хорооны гишүүний.. цалинг сарын дундаж цалингийн хэмжээгээр тооцож ажлын газар, байгууллагаас нь олгоно. Тэтгэвэрт байгаа хүн... төсвөөс зохих хөлс олгоно” гэж хуульчилсан байна.

Сонгуулийн хороодын гишүүдийн ажлын ачаалал өндөр, өдөр бүр шөнө дөл хүртэл сууж ажилладаг төдийгүй амралтын өдрүүдээр ч ажиллахад хүрдэг. Гэсэн атал илүү цагийн хөлс энэ тэр гэж өгдөггүй агаад тэр бүү хэл тодорхой ажил эрхэлдэггүй бол хуульд заасан хөлсөө ч олж авахад хэцүү аж.

*Алдаг цалингаа л авдаг. Гэтэл өдөр шөнөгүй л ажиллахад хүрдэг. Шөнө орой болтол ажиллаад л шөнийн харанхуйд алхаж л харина шүү дээ. Нохой шувуу барьчих гээд хэцүү. Кэйс. Сонгуулийн хэсгийн хорооны гишүүн.Хөвд*

Сонгуулийн хороодын гишүүдэд санал хураах өдөр л нэг удаа өдрийн хоолны мөнгө өгдөг ба санал хураах байраа засах энэ тэрд танил тал гэх мэт гуйврын замаар л сандал ширээ олоход хүрдэг аж.

*Нэр дэвшигч.. өөрийн эхнэрийн хамт өдөр бүр сонгуулийн хэсгийн хорооны гишүүдэд үнэ төлбөргүй хоол унд зөөж хууль зөрчиж байна. Нэр дэвшигчээс гаргасан өргөдөл. Өмнөговь.*

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” чанарын судалгаа. НСХ 2004 он

Эндээс харахад сонгуулийн хороонд /ялангуяа орон нутагт/ ажиллана гэдэг хувь хүний хувьд зүгээр л шийтгэл мэт агаад ийм хүмүүс нэр дэвшигч, нам эвслийн нөлөө, бэлэг сэлтэд автагдахгүй гэх баталгаагүйн зэрэгцээ сонгуулийн өмнө ба дараа нь эрх мэдэлтэнгүүдийн зүгээс дарамт шахалтанд орох зэргээр хүнд байдалд байдаг нь харагдаж байгаа юм.

*Жижиг газар хэцүү. Нэр дэвшиж байгаа нь дандаа дарга юм уу мөнгөтэй хүмүүс байдаг. Сонгуулийн үед дүргүйг нь хүргэчихвэл дараа нь бөөн дарамтанд орно ямар нутаг сэлгээд явчихна гэх биш. Энд ажиллана гэдэг цул дараа. Сонгуулийн хорооны гишүүнтэй хийсэн ярилцлага. Өмнөговь.*

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” чанарын судалгаа. НСХ 2004 он

*Чи сонгууль, монгууль гэхээр зүгээр л цалингаа аваад явж бай. Цаад ах нар чамайг битгий хэл залгисан улсууд. Амыг чинь барьж орхино шүү. Юун эрх мэрх манатай. Бүлгийн ярилцлага. Дорнод. ХЭК-ийн төлөөлөгч*

Иргэдийн сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтын урьдчилсан нөхцлийг хангах, энэ төрлийн зөрчлийг бууруулах, улмаар гаргуулахгүй байх, монголчуудын ярьдгаар мордохын хазгай болохгүй тулд

- Сонгуулийн аливаа шатны хороодыг байгуулах үйл явцыг ил тод болгож, түүнд байх төлөөллийн асуудлыг зохицуулж чадахуйц эрх зүйн орчин бүрдүүлэх,
- Сонгуулийн хороодын бүрэлдхүүнийг нөлөө бүхий улс төрийн нам эвслүүд хоорондоо тохиролцон хувааж авах шударга бус зарчмыг халах, нам бусчууд, болоод бусад хүчнийхний оролцоо, хяналтыг хангаж чадахуйц механизмыг бүрдүүлэх,
- сонгуулийн хороонд ажиллаж буй хүн шударга, хэн нэгний дарамт шахалтанд орохгүй байх нөхцлийг хангах, тэдний эдийн засгийн болоод бусад баталгааг хуульд маш тодорхой зааж өгөх нь тумгамдсан шинжтэй болж байна.

### **Сонгуулийн хороодын үйл ажиллагаа**

Хүний сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийг үнэлэх манай судалгааны бас нэгэн зорилго бол сонгуулийн хороодын үйл ажиллагааны өнөөгийн байдалд дүгнэлт өгөх явдал байлаа.

Санал асуулгын судалгааны хүрээнд сонгуулийн хэсгийн хорооны хуулинд заасан үүргийн гүйцэтгэлийн тухайд иргэд, олон нийтийн үнэлгээг авсан бөгөөд мөн ажиглалтын судалгаагаар хэсгийн хороодын үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулах ажлыг хийж гүйцэтгэсэн болно.

#### ***Санал хураах цаг, хугацаа, байр, журмыг мэдээлэх***

Сонгуулийн аливаа хэсгийн хорооны давын өмнө гүйцэтгэх үүрэг бол иргэдэд сонгуулийн санал хураалт явагдах байр, цаг хугацаа, журмыг бүгдэд нь хүртээмжтэй зарлан мэдүүлэх явдал юм.

Гэтэл хамгийн наад захын эл үүрэг нь амьдрал дээр төдийлөн сайн хэрэгждэг гэж үзэхэд бэрхшээлтэй болжээ. Янз бүрийн шатны сонгуулийн штаб, хэсгүүдийн зүгээс санал хураалтын цаг хугацаа, байр зэргийг хэрхэн мэдээлж ирсэн талаар иргэдийн үнэлгээг доорх хүснэгтээс харж болно.

#### **Санал хураах цаг хугацаа, байр, журмыг мэдээлэх үйл ажиллагааны талаарх иргэдийн үнэлгээ**

	УИХ-ын сонгууль		Орон нутгийн сонгууль	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Хангалттай	654	65,4	510	51,0
Дунд зэрэг	164	16,4	183	18,3
Хангалтгүй	69	6,9	83	8,3
Мэдэхгүй	113	11,9	224	2,4
Нийт	1000	100,0	1000	100,0

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. Хүснэгт 3

Юутай ч бүх шатны сонгуулийн үед сонгуулийг зохион байгуулагчдын зүгээс дээрх мэдээллийг иргэдэд хангалттай хүргэж чаддаггүй бөгөөд энэ нь иргэд сонгох эрхээ эдлэх боломжийг хумиж байгаа хамгийн наад захын шалтгаан гэж үзэж болно. Сонгуулийн санал хураалт хаана, хэдий хугацаанд

явагдах талаар иргэдийн 50-60 гаруйхан хувь нь хангалттай, эргэлзээгүй мэдээлэлтэй байсан нь анхаарал татах асуудлын нэг мөн.

Түүнчлэн УИХ-ын болоод орон нутгийн сонгуульд иргэдийн 16-18 хувь нь энэ талаар ямар нэг хэмжээгээр мэдээлэлтэй байсан гэж үзсэн бол 6-8 хувь нь мэдээлэл хангалттай авч чадаагүй болох нь харагдсан юм.

Ажиглалт хийгээд ганцаарчилсан ярилцлага судалгааны явцад сонгууль өгөх цаг хугацаа, байр, журмын талаарх мэдээллээр иргэд хэрхэн хангагдсан байдлыг хөндлөө.

Ажиглалт явагдсан орон нутгуудад дээрх үзүүлэлт харилцан адилгүй авч иргэдийн дунд санал өгөх байр, журмын талаар төдийлөн мэдлэггүй байх нь нийтлэг тааралдаж байсан болно.

*Сонгууль хаана өгөх, хэрхэн өгөх тухай хүмүүсийн дунд мэдэхгүй явдал нэлээд байна. Тэд санал өгөх байрыг мэдэхгүй бодвол хуучин өгдөгтөө өгөх л байхдаа гэгцгээж байсан. Энэ нь тус аймагт тоггүй харанхуй, олныг хамарсан сурталчилгаа явагдахгүй байгаатай холбоотой болов уу. Завхан. Ажиглалт. ХЭК-ийн төлөөлөгч*

*Орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гарах нийтлэлүүдэд нэр дэвшигчдийн сурталчилгаа зонхилж байсан боловч, иргэдийн сонгох, сонгогдох эрхийг нь тайлбарлан таниулах, сонгуулийн хуулийн иргэдтэй холбоотой, тэдний зайлшгүй мэдэх ёстой зүйл заалтуудыг сурталчлах талаар ямар ч зүйл яригдахгүй байлаа. Хөвсгөл. Ажиглалт. ХЭК-ийн төлөөлөгч*

Санал хураалт явагдах байр, цаг хугацаа, журмын талаарх мэдээллээр иргэд хэрхэн хангагдсан талаар орон нутгуудын хувьд цаашид нарийвчлан авч үзэх боломжтой. Юуны өмнө УИХ-ын сонгуулийн тухайд үзэхүл эл сонгуулийн үеэр зарим нэг газруудад сонгуулийн хэсгийн хорооны дээрх чиг үүрэг төдийлөн сайн хэрэгжсэн гэж үзэхэд төвөгтэй байгаа юм.

Тухайлбал, Дорнод аймгийн судалгаанд оролцсон сонгогчдын 46 хувь нь УИХ-ын сонгуулийн үеэр хэсгийн хороо санал хураалтын цаг хугацаа, байр, журмыг хангалттай мэдээлсэн гэж үзсэн бол 10 гаруй хувь нь хангалтгүй, цаашилбал дөрвөн сонгогч дутмын нэг нь энэ талаар үнэлж мэдэхгүй байлаа.

Нөгөөтэйгүүр орон нутгийн сонгуулийн хувьд ч дурдсан газарт энэ байдал илүү их бий болсон бөгөөд судалгаанд оролцсон иргэдийн 15 хувь нь санал хураалтын цаг хугацаа, байршлын талаар мэдээлэл тун хангалтгүй гэсэн юм.

Нийслэл хотын хувьд бол захын дүүргүүдэд УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн хэсгийн хороо санал хураалтыг хангалтгүй мэдээлсэн гэж хэлж болохоор байна.

Учир нь Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул зэрэг дүүргээс судалгаанд оролцсон 10 сонгогч дутмын нэг нь санал хураах цаг хугацаа, байр, журмын тухай сонгуулийн хороод сүүлийн сонгуулиудын үеэр хангалттай мэдээлэл өгөөгүй гэж үзсэнээс дээрх асуудал тодорхой байна.

Захын дүүргүүдийн хувьд хүн ам шигүү суурьшсан, төвлөрөл их, шилжилт хөдөлгөөн өндөр, төвөөс зайтай гэдэг утгаар цаашид мэдээлэл тараахад онцгой ач холбогдол өгөхгүй бол хүний сонгох, сонгогдох эрх зөрчигдөхөд хүргэх талтай болжээ.

Судалгааны хүрээнд сонирхол татаж байгаа асуудал бол сонгуулийн хэсгийн хорооны үйл ажиллагаанд янз бүрийн түвшний боловсролтой сонгогчдын бүлгээс хэрхэн хандаж, үнэлж байгааг тодруулах явдал гэж үзсэн юм. Боловсролын түвшнээр сонгогчдын үнэлгээг харвал доорх байдалтай байлаа.

**Санал хураах цаг хугацаа, байр, журмыг мэдээлэх үйл ажиллагааны талаарх иргэдийн үнэлгээ**

/боловсролын бүлгээр/

		Хангалттай	Дунд зэрэг	Хангалтгүй	Мэдэхгүй	Нийт
Дээд	УИХ	68.4	16.7	7.6	7.3	100.0
	Орон нутаг	48.3	20.9	9.3	21.5	100.0
Тусгай дунд	УИХ	67.3	15.6	7.5	9.5	100.0
	Орон нутаг	48.3	23.1	7.5	21.1	100.0
Бүрэн дунд	УИХ	60.9	19.4	5.8	13.9	100.0
	Орон нутаг	50.7	15.8	8.9	24.7	100.0
Б.бус дунд	УИХ	65.9	10.2	8.0	15.9	100.0
	Орон нутаг	58.0	13.6	4.5	23.9	100.0
Бага ба боловсролгүй	УИХ	69.1	6.5	6.7	16.5	100.0
	Орон нутаг	18.0	13.8	6.5	12.7	100.0

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. Хүснэгт 4

Иргэдийн үнэлгээг УИХ-ын болоод орон нутгийн сонгуулийн хувьд тус тусад нь авч үзэхэд боловсролын түвшингээр онцын ялгаатай байдал үүсэхгүй байгаа нь хэсгийн хорооны дээрх үйл ажиллагааг үнэлэх үнэлгээ нь сонгогчдын боловсролын түвшингээс хамаарах нь бага байгааг харуулж байна.

Харин сонгогчдыг боловсролоор нь бүлэглэсэн бүлгүүдийн зүгээс өгсөн үнэлгээнээс үзэхэд УИХ-ын сонгуулийн үеэр цаг хугацаа байр, журмын тухай мэдээллийн хүртээмж нь орон нутгийн сонгуулийн үеийг бодвол харьцангуй илүү байсан гэж хэлж болно.

Хувьд хэсгийн хорооны мэдээлэх үйл ажиллагаанд ямар нэгэн үнэлэлт өгөөгүй сонгогчид нэлээд байгааг тэмдэглэх нь зүйтэй болов уу.

**Сонгогчдын нэрсийн жагсаалт гаргах, олон нийтэд ил тод байлгах нь**

*Саяын сонгууль нээрээ шударга бус болсон. Сонгуулийн урьд орой манай Баатар сонгогчдын нэрсийн жагсаалтаа гэртээ аваашихсан бишиж байгаа юм даа /буриад аялгаар / Бүлгийн ярилцлага. Дорнод. ХЭК-ийн төлөөлөгч*

Аль ч шатны сонгуулийн үед хамгийн их маргаан дэгдээж, нэр дэвшигчдийн нэг нэгнээ буруутган зэмлэх үндэс болдог мапаантай асуудлын нэг бол сонгогчдын нэрсийн жагсаалт гаргах үйл явц юм.

Сонгогчдын нэрсийн жагсаалт, түүнийг бүрдүүлэх хүрээнд олон талын хүндрэл, бэрхшээл үүсч иргэдийн сонгох, сонгогдох эрхийг зөрчиж, хууль ёсыг гажуудуулах явдал байгаа нь судалгаагаар харагдаж байна.

Энэ төрлийн зөрчил нь

- Сум дүүрэг, хороо, багийн засаг дарга нарын,
- Сонгуулийн хэсгийн хороодын,
- Нэр дэвшигчид болон сонгогчдын үйл ажиллагаатай холбогдон

үүсч илрэн гардаг байна.

Сонгогчдын нэрсийн жагсаалтыг хуульд заасан журмын дагуу үйлдэх үүргийг хүлээсэн холбогдох шатны засаг дарга нар өөрсдийн албан үүрэгтээ хайхрамжгүй хандаж, нэрсийн жагсаалттай холбогдон үүсэх зөрчлийн суурийг тавьдаг ба энэ нь голлон

- Нэрсийн жагсаалтыг гаргаж, сонгуулийн хэсгийн хороонд хүргэх хуулийн хугацааг хэтрүүлэх
- Оршин суугчдын нэр овог, хаяг, иргэний үнэмлэх, регистрын дугаарыг буруу бичих, шилжилт хөдөлгөөнийг цаг тухайд нь



бүртгэж байгаагүйн улмаас хий хүнийг жагсаалтанд оруулах, орох ёстой хүнийг орхигдуулах

- Жагсаалтад орох ёсгүй хүнийг зориуд, санаатайгаар бүртгэх зэрэг хууль бус үйлдлээр илэрч гарч байгаа юм.

Нэрсийн жагсаалтыг хугацаа хожимдуулан үйлдэх, олон нийтэд ил тавьж танилцуулах журам, хугацааг зөрчих нь аль ч шатны сонгуулийн үед нийтлэг, ердийн үзэгдэл болж хувирсан нь судалгаанаас илэрхий байна.

*Багийн засаг дарга нар үндсэндээ сонгогчдын нэрсийн жагсаалтыг хуулийн дагуу гаргаж өгөөгүй, тойргуудын нэрсийн жагсаалт сонгууль болохоос хоёрхон хоногийн өмнө л хагас дутуу бэлэн болж байв. Баримт бичгийн судалгаа. Төв аймаг, ХЭК-ийн төлөөлөгч*

Ийм байдал судалгаанд хамрагдсан 21 аймаг, УБ, Дархан, Эрдэнэтийн орон нутгийн сонгуулийн тойрог хэсэг дээр ямар нэг хэлбэрээр давтагдаж байв.

Түүнчлэн бэлэн болсон гэх нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн хүмүүсийн гуч хүртэлх хувьд ямар нэг зөрчил илэрч байсан нь судалгаагаар батлагдаж байгаа бөгөөд нэр овог, иргэний үнэмлэх, регистрын дугаар буруу бүртгэгдэх, орхигдуулах зэрэг нь тун түгээмэл төдийгүй зориудын шинжтэй болжээ.

*Нэрсийн жагсаалтад байсан 24 оюутны нэгнийх нь нэр буруу, бүгдийнх нь регистр, үнэмлэхний дугаар зөрж байсан. Бид зохих ёсоор баримт бичгээ аваачиж, бүгдийг үнэн зөвөөр бүртгүүлсэн. цагаад ингэж буруу болсныг үнэхээр гайхаж байна. Баримт бичгийн судалгаа. Хөвд. ХЭКийн төлөөлөгч.*

Нэрсийн жагсаалтанд орсон иргэдийн нэр хаяг, иргэний үнэмлэхний дугаар өөр хоорондоо зөрүүтэй, эсвэл ямар нэг будлиантай байх, сонгогчид буруу хаягаар бүртгэгдсэн талаарх чанарын судалгааны дүнг хүснэгтээр харуулбал ийм байна.

- 20 гаруй сонгогчдын овог нэр нь байсан боловч регистр зөрсөн /Увс аймаг/
- Иргэний үнэмлэхгүй хөгшдийг манай иргэд мөн гээд авсан /Дархан-Уул аймаг/
- Нэрсийн жагсаалтанд сонгогчдыг регистргүй бичсэн байсан нь асуудал гаргасан /Хөвсгөл аймаг/
- Улаанбаатар хотын харъяат хүн энд бүртгэгдсэн /Завхан аймаг/
- Бүртгэл будлиантай 35 хүний нэрсийг дахин хянан үзсэн /Баян-Өлгий/
- Зарим сонгогчдыг нэрсийн жагсаалтанд хамраагүйгээс цоохор нэрсийн жагсаалтанд оруулсан /Дорнод/
- Сонгогч буруу хаягаар бүртгэгдсэн тул өөрийн тойрогт саналаа өгч чадаагүй, өөр тойрогт өгөхөд хүрсэн /Дундговь/
- 3 жилийн өмнө нас барсан хүнийг жагсаалтаас хасаагүй байсан, мөн түүнийг явуулын хайрцгаар авах сонгогчдын жагсаалтанд оруулсан байв /Дундговь/

ХЭҮК –ийн Итгэмжлэгдсэн Төлөөлөгчдийн авсан чанарын судалгаа. 2004 он

УИХ-ын сонгуультай холбоотойгоор Сонгуулийн Ерөнхий Хороонд ирсэн өргөдөл гомдлын 7 хувь сонгогчдын нэрсийн жагсаалттай холбоотой байгаа бол орон нутгийн сонгуулийн үеэр энэ үзүүлэлт 25,4 хүртлээ өссөн байна. /эх сурвалж: СЕХороонд ирсэн өргөдөл гомдолд хийсэн контент анализ/

Сонгуулийн хэсгийн хороодын хувьд энэ тухайд тун эвлэрэнгүй, төвийг сахисан байр сууринаас ханддаг нь ийм төрлийн зөрчлийг улам өөгшүүлэн,

хүний сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтэнд муугаар нөлөөлөхөд хүргэж байна.

Тоон судалгаанд оролцсон иргэдийн 20 орчим хувь нь УИХ-ын болоод орон нутгийн сонгуульд сонгуулийн хэсгийн хороо нэрсийн жагсаалттай холбоотой үүргээ хангалттай биш ч, тодорхой хэмжээгээр гүйцэтгэсэн гэж үзсэн бол, УИХ-ын сонгуульд 13 хувь нь, орон нутгийн сонгуульд 14 хувь нь тус тус хангалтгүй гүйцэтгэсэн гэж хариулсан байна.

Судалгаанд оролцсон иргэдийн зүгээс сонгуулийн хэсгийн хорооны эл үйл ажиллагаанд өгсөн үнэлэлтээс харахад УИХ-ын болоод орон нутгийн сонгуулийн аль ч шатанд сонгогчдын нэрсийн жагсаалтыг нэгтгэх, олон нийтэд ил тод нээлттэй байлгах ажил хангалттай сайн хэрэгжсэн гэх үндэсгүй юм.

**Сонгогчдын нэрсийн жагсаалтыг нэгтгэн иргэдэд нэгтгэх, олон нийтэд ил тод байлгах үйл ажиллагааны талаарх иргэдийн үнэлгээ**

	УИХ-ын сонгууль		Орон нутгийн сонгууль	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Хангалттай	497	49,7	409	40,9
Дунд зэрэг	206	20,6	190	19,0
Хангалтгүй	136	13,6	143	14,3
Мэдэхгүй	162	16,2	258	25,8
Нийт	1000	100,0	1000	100,0

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. Хүснэгт 5

Сонгуулийн хорооны зүгээс сонгогчдын нэрсийн жагсаалтыг бүрдүүлэх, хянах үүргээ хэр зэрэг гүйцэтгэсэн талаар иргэдийн нэлээд хэсэг нь үнэлж цэгнэх тодорхой мэдлэггүй байгаа нь анхааралгүй орхих асуудал биш юм.

Сонгуулийн хэсгийн хорооноос сонгогчдын нэрсийн жагсаалтыг нэгтгэх, олон нийтэд ил тод байлгах ажлыг орон нутгуудад хэрхэн гүйцэтгэсэн талаар иргэдийн үнэлгээг тандсанаа толилуулья.

Улаанбаатар хотын дүүргүүдийн хувьд сонгогчдын 45-50 гаруй хувь нь хангалттай, хуулийн дагуу гүйцэтгэсэн гэсэн бол үлдсэн 40-50 хувь нь хэсгийн хорооны үйл ажиллагааг хангалттай гэж үзэхгүй байгаа нь хүний эрхийн асуудлыг судлах энэ тохиолдолд илүү анхаарал татлаа.

Үзвээс, Сонгинохайрхан дүүргийн сонгогчдын 15.9 хувь нь, Баянгол дүүргийн 14.4 хувь, Баянзүрх дүүргийн 12.8 хувь нь тус тус өөрийн хэсгийн хорооноос нэрсийн жагсаалт гаргах, ил тод байлгах үйл ажиллагааг хангалтгүй гүйцэтгэсэн гэж үнэлжээ.

Аймгуудыг хооронд нь харьцуулахад сонгуулийн хэсгийн хорооноос дээр дурдсан үйл ажиллагаагаа бүх шатны сонгуулиудын үед харьцангуй сайн гүйцэтгэсэн нь Өмнөговь аймаг гэж хэлж болно.

Тус аймгийн сонгогчдын 70 орчим хувь нь хороо дээрх үүргээ сайн гүйцэтгэсэн гэж үзсэн бол, харин тэдний 3 орчим хувь нь хангалтгүй муу гэжээ.

Дархан-Уул, Дорнод, Ховд зэрэг орон нутагт сонгогчдын нэрсийн жагсаалтыг гаргах, нийтэд нээлттэй байлгах тал дээр учир дутагдалтай байв.

Дээрх газруудаас судалгаанд оролцсон сонгогчдын тал орчим хувь нь эл үйл ажиллагааг хангалттай сайн гэж үзэхгүй байгаа бөгөөд тодруулбал сонгогчдын 20-30 орчим хувь нь хангалттай сайн биш, 15-20 хувь нь огт хангалтгүй гэж тус тус үнэлсэн байна.

Сонгогчдын боловсролын түвшин хийгээд сонгуулийн хэсгийн хорооны үйл ажиллагааг үнэлэх үнэлгээнд хамаарал байгаа эсэх талаар доорх хүснэгтээс харж болно.

**Сонгогчдын нэрсийн жагсаалтыг нэгтгэн, олон нийтэд ил тод байлгах  
үйл ажиллагааны талаарх иргэдийн үнэлгээ**

/боловсролын бүлгээр/

		Хангалттай	Дунд зэрэг	Хангалтгүй	Мэдэхгүй	Нийт
Дээд	УИХ	48.3	19.8	14.4	17.5	100.0
	Орон нутаг	36.7	18.9	18.4	26.0	100.0
Тусгай дунд	УИХ	51.7	23.8	10.2	14.3	100.0
	Орон нутаг	40.1	21.1	13.6	25.2	100.0
Бүрэн дунд	УИХ	47.6	21.3	14.1	16.9	100.0
	Орон нутаг	41.6	19.4	11.6	27.4	100.0
Б.бус дунд	УИХ	50.0	18.2	17.0	14.8	100.0
	Орон нутаг	50.0	13.6	13.6	22.7	100.0
Бага ба боловсролгүй	УИХ	67.2	15.0	6.8	9.1	100.0
	Орон нутаг	54.1	20.2	8.5	17.1	100.0

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. Хүснэгт 6

Нэрсийн жагсаалтад орох ёстой сонгогчдын нэрс байхгүй орхигдох нь түгээмэл байгаа нь ХЭК-ийн төлөөлөгчдын болоод МУИС-ийн Нийгмийн Судалгааны Хүрээлэнгээс явуулсан чанарын судалгаанаас харагдаж байгаа юм.

- |   |
|---|
| <ul style="list-style-type: none"> <li>○ Нэрсийн жагсаалтад хэсэг сонгогчдын нэр байгаагүй /Эрдэнэт, Төв/</li> <li>○ Сонгогчдын нэрсийн жагсаалтанд нэг гэр бүлийн хоёр хүний нэр байгаагүй /Увс/</li> <li>○ Нэрсийн жагсаалтаас орхигдсон сонгогчид саналаа өгч чадаагүй тохиолдлууд гарсан /Баян-Өлгий/</li> <li>○ Сонгогчдын нэрсийн жагсаалт дутуу байснаас нэмэлт бүртгэлээр хүмүүсийг нэмж бүртгэсэн /Дархан-Уул аймаг/</li> <li>○ Нэрсийн жагсаалт дутуу гарснаас иргэний үнэмлэх үндэслэн нэмж бүртгэсэн /Төв аймаг/</li> <li>○ Сонгогчдын нэрсийн жагсаалт санал хураалтын өглөө л нэг дууссан /Сүхбаатар/</li> <li>○ Сонгуулийн хэсгийн хороо санал хураалтын өглөө зөөврийн хайрцгаар санал өгөх сонгогчдын жагсаалтыг гаргаагүй байсан /Төв/</li> <li>○ Албан хаагчын зүгээс гаргасан эмнэлэгт хэвтэгчид болон урьдчилан хорих байранд хоригдогсдын жагсаалтыг дахин нягтлах хэрэгтэй, энэ нь учир дутагдалтай байна /Завхан/</li> <li>○ Сонгуулийн хэсгийн хорооны гишүүд нэрсийн жагсаалтанд байгаагүй гэх шалтгаанаар сонгогчдоос санал аваагүй /Увс/</li> </ul> |
|---|

ХЭҮК –ийн Итгэмжлэгдсэн Төлөөлөгчдийн авсан чанарын судалгаа. 2004 он

Мөн түүнчлэн сонгогчдын нэрсийн жагсаалтыг гаргахад оршин суугчдын хаягийн бүртгэл, түүний журам, бичиг баримтын бүрдэл, засаг захиргаа завсардан амьдрах зэрэг хэд хэдэн асуудал бэрхшээл учруулдаг нь харагдсан юм.

Юуны өмнө хаягийн бүртгэл, түүнийг хийх журам нь өнөөгийн шаардлага хангахгүй байгаа, хууль ёсны оршин суугч боловч хаягийн бүртгэл жигдрээгүйн улмаас сонгогчид санал өгч чадаагүй байдлууд гарчээ.

Мөн иргэд бичиг баримтын бүрдлээс болоод санал өгч чадахгүйд хүрдэг бөгөөд бичиг баримтын бүрдэл хангаагүй байх нь тэр бүр сонгогчдын хариуцлагаас хамаардаггүй гэнэ.

Аль нэг бичиг баримт нь нутгийн захиргаан дээр саатах, иргэдийг бичиг баримтжуулах ажилд хойрго хандах зэргээс сонгогчид сонгуульд оролцож чадахгүйд хүрэх нь байдаг байна.

Засаг захиргаа завсардан амьдрах явдал нь ихэвчлэн шилжин ирэгчид хийгээд оюутнуудын хувьд яригддаг асуудал агаад эл томоохон социаль бүлгийн дунд аль нэг шатны сонгууль завсардан, саналаа өгч чадахгүй байх нь бий ажээ. Ажиглалтын явцад дээрх бүлгийн хүмүүс сонгогчдын нэрсийн жагсаалтад орж чадахгүй байх нь нэлээд хэд хэдэн аймгуудад нийтлэг тааралдсан болно.

- Сонгогчдын нэрсийн жагсаалтад оюутнууд орж чадаагүй, өөр харъяалалтай учраас сонгох эрх нь зөрчигдсөн /Дорнод аймаг/
- Иргэний үнэмлэх, бичиг баримтын бүрдэлгүй 14 хүн байсан нь санал өгч чадаагүй /Баян-Өлгий аймаг/
- Хаягийн шижүүлэг хийлгээгүйн улмаас олон шилжин ирэгч саналаа өгөөгүй /Дорнод/
- Тухайн тойрогт удаан амьдарч байгаа ч шилжүүлэггүй улмаас саналаа өгч чадаагүй /Эрдэнэт/
- Хөдөөд амьдардаг шилжин ирэгчид шилжүүлгээ хийж чадаагүй учраас саналаа өгч чадаагүй /Сүхбаатар/
- Шилжүүлэг хийлгүүлээгүй сонгогчид сонгох эрхээ эдлэж чадаагүй /Дорноговь/
- Оюутнууд тухайн нутаг дэвсгэрт оршин суудаг боловч өөр аймаг, сумын харъяат учраас сонгох эрхээ эдлээгүй, Хаягийн наалт хийлгээгүй гэдгээс саналаа өгч чадаагүй олон хүн байсан /Төв аймаг/
- Тухайн багт оршин суудаг боловч хаягийн хөдөлгөөн хийлгээгүй улмаас санал өгүүлээгүй /Сэлэнгэ/

ХЭҮК –ийн Итгэмжлэгдсэн Төлөөлөгчдийн авсан чанарын судалгаа. 2004 он

Түүнчлэн нэрсийн жагсаалт гаргахтай холбогдсон зөрчлийн нилээдгүй хувь нэр дэвшигчид болоод сонгогчдын өөрсдийн нь улс төрийн ухамсар, хариуцлагагүй үйл ажиллагаатай холбогдон гарч байна.

Нэр дэвшигчид элдэв амлалт өгөх, бэлэн мөнгө архи, эд бараа өгөх зэргээр сонгуулийн насны иргэдийг өөртөө татаж, олноор нь шилжүүлж, өөрийнхөө тойрогт санал өгүүлэх, эл үйлдэлд нь засаг дарга нар, сонгуулийн хороодын гишүүд хамсан оролцох нь ердийн үзэгдэл болжээ.

УИХ-ын 2004 оны сонгуульд нэр дэвшигчид хүмүүс зөөж, өөрийн төлөө санал өгүүлэх явдал тун нийтлэг байсан бол эл өвчин орон нутгийн сонгуульд ч халдварласан нь харагдаж байна.

*Баян өлгий аймгаас ирсэн 130 гаруй казак оюутнуудыг тухайн тойрогт хамрагдах багийн иргэд манайд амьдардаг гэж сонгуулийн хэсгийн хороонд дээр санал өгөх өдөр дагуулан ирж бүртгүүлэн санал өгүүлснээс сонгуулийн дүнг будлиантуулахад хүргэсэн. Ажиглалтын судалгаа. Хөвд, ХЭК-ийн төлөөлөгч*

Орон нутгийн сонгуулийн үеэр шилжих хөдөлгөөн тун идэвхжсэн тухай холбогдох албаны хүмүүс ярьж байсан агаад шалтгааныг нь нэр дэвшигчдээс сонгогчийн санал худалдаж авах, ахуй амьдралыг нь дээшлүүлэхтэй холбогдсон хуурамч амлалт өгч өөрийн тойрогт татах, сонгогч ах дүү

хамаатан саднаа дэмжих зорилгоор шилжих зэрэгтэй холбон тайлбарласан байна.

*Манай аймагт гадаадад ажиллуулахаар хүн бүртгэж байна гэхээр нь утсаар асуусан чинь хаяг асуугаад танай гудамжнаас бол бүртгэхгүй харин Баруун Сайхнаас бол бүртгэнэ, энэ бол МАХН –ын аймгийн ИТХ-д нэр дэвшигчдээс сонгогчдынхоо төлөө хийж байгаа ажил гэсэн. Одоо хаягаа шилжүүлэх бодолтой байна. Кэйс судлал. Өмнөговь*

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” чанарын судалгаа. НСХ 2004 он

*Хэрэв бид аймгийн ИТХ-д ялах юм бол Эх орон-Ардчилал эвслийн хүүхдийн 10.000 төгрөгийг аймгийн хэмжээнд олгож эхэлнэ. Энэ бол манай аймгийн хувьд бүрэн боломжтой зүйл. Баримт бичгийн судалгаа. Эх орон-Ардчилал эвслээс нэр дэвшигчдын сурталчилгааны материал. Өмнөговь*

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” чанарын судалгаа. НСХ 2004 он

Ийм төрлийн амлалт, сурталчилгааны жишээг хэдэн арваар татаж болох бөгөөд тохиол бүр нь сонгуулийн хууль, хүний сонгох сонгогдох эрхийн зөрчлийг агуулж байгаа билээ.

Сонгогчдын нэрсийн жагсаалтай холбогдсон дараах дүгнэлт, зөвлөмжийг хийж болно. Үүнд:

- Сонгогчдын нэрсийн жагсаалт гаргах талаарх хуулийн өнөөгийн заалтууд нь тодорхой бус, дутуу дулимаг боловсруулагдсанаас хүний сонгох, сонгогдох эрхийн зөрчлийг автоматаар төрүүлэх сөрөг механизм болж хувирсан байна.
- Нэрсийн жагсаалт гаргадаг бүх шатны засаг дарга нарын үүрэг хариуцлагын тогтолцоог нарийвчлан тодорхойлж, хуульчлах,
- Сонгуулийн хороодоос сонгогчдын нэрсийн жагсаалтад хяналт тавих үйл ажиллагааны үр дүнтэй, оновчтой, шударга механизмыг бий болгох
- Нэрсийн жагсаалтад тавих олон нийтийн хяналтыг хүчтэй өрнүүлэх, хүний эрхийн болоод сонирхогч төрийн бус байгууллагуудын үр өгөөжтэй оролцоог нэмэгдүүлэхүйц тогтолцоог бүрдүүлэх, энэ тухай хуульчлан заах,
- Хаана оршин суух нь хүний эрх мөн авч сонгуультай холбогдон зохиомлоор үүсдэг шилжилт хөдөлгөөн нь эцсийн дүндээ хүний язгуур эрх түүний дотор хүний сонгох, сонгогдох эрхийг бүдүүлгээр зөрчихөд хүргэж байгаа тул түүнийг зохицуулж чадах эрх зүйн тогтолцоог бий болгох,
- Нам эвсэл, нэр дэвшигчдийн зүгээс сонгогчдыг өөртөө татаж, хаягийн шилжүүлэг хийлгэдэг бохир технологийг хааж, таслан зогсоох чадах өөрчлөлтийг хуульд оруулах, хууль зөрчсөн үйлдлийнхээ төлөө тэдний хүлээх хариуцлагыг чангатгах зэрэг байж болох юм.

### **Нэр дэвшүүлэх, нэр дэвшигчдыг тодруулах үйл явц.**

*Сонгуульд ерөөсөө нууц бүлэглэлийн маягаар нэр дэвшээд сонгогдоод байна. Олон нийтийн байгууллагын саналаар нэр дэвшигчийг гаргамаар байна. Намаар нь сонгууль өгөх буруу. Кэйс судлал. Өмнөговь*

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” чанарын судалгаа. НСХ 2004 он

Монгол Улсын Үндсэн Хуулийн 16-р зүйлд манай иргэд “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох.. сонгох, сонгогдох эрхтэй” хэмээсэн авч бидний эл эрх зөвхөн саналын хуудсан дээрх нэр дэвшигчдийн нэрийг дугуйлахаар хязгаарлагдаж, улам бүр явцуурсаар байна.

Чухамдаа тэр саналын хуудсан дээр хэний нэр байх тухай буюу нэр дэвшүүлэх эрх, сонгогчдоос энэ үйл ажиллагаанд оролцох эрх сүүлийн үед улам бүр мартагдан бүдгэрсээр байгаа юм.

Ардчиллын эхний жилүүдээс бид улс төрийн намуудын дэвшүүлсэн хүний төлөө саналаа өгч тэдний хэн нэгийг сонгосоор өнөөг хүрчээ.

Нам бол иргэдээс улс төрд оролцох үндсэн арга, хэлбэрүүдийн нэг мөн авч, эдүгээ манай нийгмийн хувьд цорын ганц зөв арга зам мэт сэтгэлгээ бий болж үүнийг ч улс төрийн намууд, тэдний лидерүүд улам бүр лавшруулан сурталчилж байна.

Сүүлийн жилүүдийн туршлагаас харахад монголын нөлөө бүхий улс төрийн намуудын дотоод ардчилал үгүй болж, цөөн тооны удирдагчдыг даган хуваагдсан бүлэглэлүүдийн шинжтэй болж байгаа нь нууц биш бөгөөд улмаар улс төрийн оролцооны орон зайг хуваан монопольлох хандлага улам бүр хүчээ авч байгаа юм.

“Манай орны хувьд олон нам хэрэггүй хоёр нам байхад л болно. Чухамдаа гэвэл АН ба МАХН хоёр л яг болж байгаа юм” гэсэн сурталчилгаа сонгуулийн үеэр гаарч байлаа.

Ялангуяа манай төр засгийн өндөр дээд албан тушаалтнуудын амнаас ийм үг яриа олонтоо унах болсон нь хүний сонгох, сонгогдох эрхийг хязгаарлах, ардчилалыг өмчлөх гэсэн оролдлогын илрэл юм.

Манай судалгааны дүн сонгуульд өрсөлдөх нэр дэвшигчдийг тодруулахад иргэд гар бие оролцох эрх мэдэлгүй ба улс төрийн намуудаас иргэдэд нэр дэвшигчийг санал болгон, түүнийг нь л иргэд сонгож байх ёстой мэтээр хүлээн авах сэтгэлгээ хүчтэй байгааг харуулж байгаа юм.


УИХ-ын болоод орон нутгийн ИТХ-ын сонгуульд өрсөлдөх нэр дэвшигчийг тодруулахад гар бие оролцдог эсэх талаар иргэдийн саналыг сонсоход ихэнх нь буюу 40.7 хувь нь ийм боломж байдаггүй гэж хариулсан бол, 1/4 нь мэдэхгүй, харин цөөн тооны иргэд л оролцдог гэжээ.

Оролцдог	174	17.4%
Оролцох боломж гардаг ч өөрөө хүсдэггүй	164	16.4%
Ийм боломж байдаггүй	407	40.7%
Мэдэхгүй	255	25.5%
Нийт	1000	100%

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. Хүснэгт 7


Сонгуульд нэр дэвшигчдийг тодруулах боломж олддоггүй буюу энэ талаар мэдэхгүй гэж хариулсан иргэдийн дийлэнх хэсгийг 18-35 хүртлэх насны залуус эзэлж байна.

Графикаас нэр дэвшигчийг тодруулах иргэдийн улс төрийн оролцоо хүйсийн хувьд адил байгаа бол, тэр бүр боломж байдаггүй гэж хариулсан эмэгтэйчүүдийн хувь эрэгтэйчүүдийнхээс 4 пунктээр илүү байна.



“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. График 3

Боловсролын хувьд авч үзвэл дээд боловсролтой иргэд нэр дэвшигчдийг тодруулахад гар бие оролцох нь их байдаг ба, хэдийгээр гар бие оролцох хүсэл байдаг ч ийм боломж тэр бүр олддоггүй гэж дунд боловсролтой иргэд өөрсдийн саналаа илэрхийлжээ.



“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. График 4


Хүний сонгох, сонгогдох эрхийн үүднээс УИХ, орон нутгийн сонгуульд нэр дэвшигчийг тодруулах үйл явцыг судлан үзсэний эцэст дараах товч дүгнэлтийг хийж болох юм.

- Бүх ард түмний хүсэл зоригийн илэрхийлэл байх ёстой сонгууль маань ганц хоёрхон улс төрийн нам, тэдний лидерүүдийн хүссэн загвараар явагдаж, хүний сонгох, сонгогдох эрхийг бүдүүлгээр зөрчиж байна.
- УИХ-ын болоод орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдийг сонгохдоо цөөн тооны удирдагчдын хүрээнд хувийн үнэнч байдал, хөрөнгө чинээний үзүүлэлт зэрэг тэвчишгүй шинжүүдийг шалгуур болгох явдал даамжирч байна.
- Эрх зүйн зохицуулалт хангалтгүйгээс Монгол улсын иргэн бүр төрийн байгууллагад нэрээ дэвшүүлэх эрхтэй гэсэн хуулийн заалт цаасан дээрх тунхаглалын шинжтэй болж, иргэдийн сонгогдох эрх дан ганц улс төрийн намаас шууд шалтгаалдаг эрүүл бус тогтолцоо бий болж байгаа нь хүний эрхийн хэрэгжилтэнд сөрөг нөлөө үзүүлж байна.
- Орон нутгийн сонгууль чухамдаа нутгийн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлэх үндсэн арга зам авч, түүнийг үзэл сурталжуулан, намын харьяаллаар нь оршин суугчдыг хагаралдуулан зөрчилдүүлэх явдал гаарсан нь хүний сонгох, сонгогдох эрхийг зөрчих зөрчлийн үндсэн хэсэг болж байна.
- Улс төрийн намуудын дотоод ардчилал хангалтгүй, намын сахилга бат, эрх ашгийн нэр дор ард түмний язгуур ашиг сонирхлыг огоорох байдал түгээмэл байгаа нөхцөлд нэр дэвшигчдыг дэвшүүлэх механизмыг боловсронгуй болгох, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх нь тумгамдсан асуудал болон гарч ирж байгаа юм.
- Түүнчлэн саналын хуудсанд нэр дэвшигчдээс гадна бүгдийн эсрэг санал өгөх гэсэн сонголтыг оруулж өгөх нь иргэдийн сонгох эрхэд эерэгээр нөлөөлөх, заавал хэн нэгэн нэр дэвшигчын төлөө санал өгөхийг албадсан одоогийн байдлыг халах, нэр дэвшүүлэх субъектын хариуцлагыг дээшлүүлэх нэгэн хөшүүрэг болох юм.

## Хоёрдугаар бүлэг. УИХ ба Орон нутгийн сонгууль: хүний сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал.

Энэ бүлэгт тоон болоод чанарын судалгааны үр дүнд суурилан УИХ болоод Орон нутгийн сонгуулийн үйл явцын талаарх олон нийтийн үнэлгээ ба сонгогдох эрхийн хэрэгжилтийн өнөөгийн төлөв байдалд дүн шинжилгээ хийлээ.

Судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн 78.8% нь 2004 оны УИХ-ийн болоод Орон нутгийн сонгуульд байнга оршин суудаг хаягаараа, санал өгөх байранд очиж саналаа өгч оролцжээ.



“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. График 1

Харин 5.5 хувь байнгын хаягаараа байгаагүй бөгөөд үүнийхээ шалтгааныг өөр газар суралцдаг оюутан /48.0%/, эмнэлэгт хэвтэж эмчлүүлж байсан /8%/, цэрэгт алба хааж /6.0%/, урьдчилан хорих төвд хоригдож байсан / 4.0%/ хэмээн тус тус тайлбарласан байна.

Хуулинд заасан дагуу эмнэлгийн дүгнэлт, шүүхийн шийдвэрээр ухаан солиотой нь нотлогдсон, түүнчлэн хорих газар хоригдож байгаа хүн сонгуульд оролцохгүй бөгөөд эдгээрээс бусад тохиолдолд байнгын хаягаараа байгаагүй хэдий ч иргэн хүн өөрийн саналаа өгөх эрхтэй тул түүний хэрэгжилтийг шалгах үүднээс харьцуулалт хийж үзлээ.


Байнгын хаягаараа байх боломжгүй тохиолдолд иргэд урьдчилан эсвэл түр хаягаараа санал өгөх зэргээр сонгуульд оролцох боломж бий авч иргэдийн идэвх энэ тал дээр туйлын сул байсан нь ажиглагдаж байлаа.

Үүнийг дараах хэдэн хүчин зүйл буюу тухайлбал:

- Сонгогчдын нэрсийн жагсаалт бэлэн болоогүй учраас сонгуулийн хэсгийн хороод иргэдийн саналыг авахаас татгалзах,
- Иргэдийн идэвх сул, иргэний үүрэг хариуцлагадаа хайхрамжгүй хандах, эс бөгөөс тухайн тойрогт дэвшсэн нэр дэвшигчдийг үл таалсан байдлаа идэвхгүйгээр илэрхийлсэн
- Цагдаа, эмнэлэг зэрэг байгууллагууд түр хоригдож байгаа юм уу, хэвтэж эмчлүүлж байгаа хүмүүсийн жагсаалтыг цаг тухайд нь гаргаж өгөөгүй
- УИХ ба орон нутгийн сонгуулиудтай хилийн боомтуудын нээлт давхацснаас олон иргэд эзгүй байсан зэргийг дурдаж болох юм.

Түүнчлэн сонгуульд оролцож, саналаа өгч чадаагүй шалтгаанаа хүмүүс дараах байдлаар тайлбарлаж байгаа юм.





“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. График 2

Монголчуудын электориал зан үйл харьцангуй өндөр явж ирсэн авч сүүлийн гурван удаагийн сонгуулиас харахад буурах хандлага ажиглагдаж байгаа юм.

Үүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн дунд хувь хүнээс хамааралтай субъектив нөлөөлөл өндөр байна.

Судалгааны дүнгээс харахад хувийн ажил төрөлтэй байсны улмаас гэсэн хариулт давамгайлж байгаа агаад бичиг баримтгүй юм уу зөрчилтэй байсан гэсэн тайлбар удаалж байна

### **Сонгуулийн үйл явцын талаарх иргэдийн үнэлгээ**

Юуны өмнө энэ талаарх олон нийтийн хүлээлтийг санал асуулгын үр дүнгээс харж болно. Ингэж үзэхэд судалгаанд оролцсон иргэдийн олонхи нь орон нутгийн сонгууль хууль ёсны дагуу шударга явагдсан, харин гурван сонгогч тутмын нэг нь буюу 30 гаруй хувь нь түүнийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа юм.

Сонгууль хэр зэрэг шударга явагдсан талаарх иргэдийн үнэлгээг хариулт нэг бүрээр нарийвчлан харвал доорх дүр зураг харагдана.

#### **Орон нутгийн сонгуулийн үйл явцын тухай сонгогчдын үнэлгээ**



“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. График 3

Юуны өмнө сонгогчдын 10 орчим хувь нь энэ удаагийн орон нутгийн сонгуулийг шударга бус булхайтай, хүний эрх зөрчсөн тийм сонгууль болж өнгөрсөн гэж үзэж байна.

Иргэдийн өгсөн дээрх үнэлгээнээс үзэхэд орон нутгийн сонгуулийн үед тодорхой зөрчил булхай үүсч, сонгуулийн хууль зөрчигдөж байгаа нь нилээд түгээмэл болсон зүйл гэж үзэх үндэстэй бөгөөд тэр бүрд хүний улс төрийн тухайлбал сонгох, сонгогдох эрх зөрчигдөж байгаа нь тодорхой юм. Санал асуулга судалгаанаас гадна бүлгийн ярилцлагын явцад уг асуудлын талаарх иргэдийн үнэлгээ тодорхой харагдаж байв.

*Ер нь цаашид сонгууль шударга явагдах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл сонгогч ч бай, нэр дэвшигч ч бай аль аль нь үүргээ ухамсарлаж хуулиа даган үнэн шударга сонгууль явуулмаар байна. Орон нутгийн сонгуулийг шударга зөв явуулмаар байна. Сонгууль ерөөсөө нууц бүлэглэлийн шмнжтэй явагдаад байна. Өмнөговь аймгийн иргэдтэй хийсэн бүлгийн ярилцлагаас*

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” чанарын судалгаа. НСХ 2004 он

Сонгуулийн үйл явцын талаарх эл үнэлгээг сонгогчдын нас, хүйс, оршин суугаа газар зэрэг нийгмийн тодорхой шинжүүдээр авч үзсэн бөгөөд эндээс дараах дүр зургууд харагдаж байна.

Юуны өмнө сонгууль шударга, хууль ёсны дагуу эсвэл шударга бус, хууль ёсыг зөрчиж явагдсан эсэх тухай сонгогчдын үнэлгээ нь сонгогчдын хүйсээс хамаарахгүй байгаа агаад эмэгтэйчүүд хийгээд эрэгтэйчүүдийн

бүлгээс энэ асуудалд хандах байр суурь нь нэгэн адил юм. Тухайлбал энэ удаагийн орон нутгийн сонгууль нь шударга бус, хууль зөрчих замаар явагдсан гэж судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн 9, эрэгтэйчүүдийн 10 орчим хувь нь, харин зарим нэг зөрчил дутагдал, хууль зөрчсөн явдал гарсан хэмээн эмэгтэйчүүдийн 21, эрэгтэйчүүдийн 22 орчим хувь нь тус тус хариулсан юм.

Хүйсээс гадна сонгуулийн үйл явцын талаарх үнэлгээг насны хувьд авч үзэх нь зүйтэй гэж судалгааны багаас үзсэн бөгөөд ингэж үзэхдээ сонгогчдыг насны бүлгийн хувьд залуу, дунд, ахмад хэмээн гурван үндсэн бүлэгт авч үзсэн болно.

### Орон нутгийн сонгуулийн үйл явцын тухай сонгогчдын насны бүлгийн үнэлгээ

Насны бүлэг	Шударга явагдсан	Зарим нэг зөрчил гарсан	Шударга бус сонгууль болсон	Мэдэхгүй	Хариулаагүй	Нийт
Залуу	63.5	22.45	8.8	0.87	4.3	100.0
Дунд	63.1	22.8	9.4	0.25	4.4	100.0
Ахмад	71.5	14.6	11.9	0	2.0	100.0

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. Хүснэгт 1

Дээрхээс үзэхэд сонгууль хууль ёсны дагуу явагдсан эсэх тухай үнэлгээнд насны бүлгийн хувьд хүйсийн нэгэн адилаар онцын ялгаатай байдлыг бий болгохгүй байна. Тэр дундаа залуу үе дунд үеийнхний үнэлгээнүүд нь хоорондоо нилээд ойролцоо хувьтай байгаа юм. Харин ахмад насныхны хувьд сонгууль ерөнхийдөө шударга ба зөрчилтэй явагдсан гэж үзэх нь дээрх хоёр бүлгээ бодвол тус тус харьцангуй өндөр хувьтай гарсан нь сонирхол татаж байна.

Цаашид санал асуулгын судалгаа явагдсан орон нутгуудын хувьд дээрх үнэлгээг сонирхон үзвэл өөр хоорондоо ялгаатай байдлууд ажиглагдсан болохыг тэмдэглэх хэрэгтэй. Үүнийг Улаанбаатар хотын 4 дүүрэг, зарим аймгуудын хувьд харж болно. Юуны өмнө сонгууль хууль зөрчсөн буюу шударга бус явагдсан байдлаар хамгийн өндөр хувьтай орон нутгуудаас Дархан-Уул, Дорнод, Ховд аймаг, дүүргүүдээс Баянзүрх, Сонгинохайрхан зэргийг дурьдаж болох байна. Дархан-Уул аймгийн судалгаанд оролцсон сонгогчдоос 44 хувь, харин Ховд, Дорнод аймгуудын хувьд 38 гаран хувь нь энэ удаагийн орон нутгийн сонгуульд зарим зөрчил гарсан болон сонгууль ерөөс шударга бус явагдсан гэж тус тус хариулжээ.

Харин дүүргүүдээс Баянзүрхийн сонгогчдын хувьд дээрх хариултыг өгсөн нь бусад дүүргийг бодвол нилээд зөрүүтэй их хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл энэ дүүргээс судалгаанд орсон сонгогчдын бараг 40 хүртэлх хувь нь сонгууль ямар нэг байдлаар хууль ёсны дагуу явагдаж чадаагүй гэж үзэж байна. Түүнчлэн Сонгинохайрхан дүүргийн хувьд эл үзүүлэлтээр удаах байрыг эзэлсэн юм.

Сонгуулийн үйл явцын талаарх иргэдийн эерэг болон сөрөг үнэлгээг орон нутгаар нарийвчлан харвал доорх байдалтай байна.

**Сонгуулийн үйл явцын талаарх иргэдийн үнэлгээ /орон нутгаар/**

Дүүрэг	Шударга явагдсан	Зарим зөрчлүүд гарсан	Шударга бус сонгууль	Бусад	Нийт
Баянгол	74.4	12.0	6.4	7.2	100.0
Хан-Уул	73.0	15.9	7.9	3.2	100.0
Сонгинохайрхан	70.6	23.0	4.8	1.6	100.0
Баянзүрх	56.8	27.2	12.8	3.2	100.0
Аймаг	Шударга явагдсан	Зарим зөрчлүүд гарсан	Шударга бус сонгууль	Бусад	Нийт
Өмнөговь	81.2	12.8	3.4	2.6	100.0
Ховд	60.9	30.9	7.3	0.9	100.0
Дорнод	52.7	32.1	6.3	8.9	100.0
Дархан-Уул	49.1	18.9	25.2	6.9	100.0

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. Хүснэгт 2

Дээрхээс үзэхүл юуны өмнө орон нутгийн хүн амын харьцангуй төвлөрөлтэй буюу төвлөрөл ихтэй, хотожсон байдал нь сонгууль хууль ёсны дагуу явагдаж чадахгүй байхад хийгээд сонгуулийн зөрчил маргаан гарахад нөлөөлж байгаа харагдаж байна. Тухайлбал Дархан-Уул аймаг нь улсын хэмжээний дагуул хот байхад Дорнод нь бусад аймгаа бодвол хүн амын төвлөрөл их, зүүн бүсийн томоохон төв юм.

Улаанбаатар хотын хувьд авч үзвэл хоёр захын дүүргийн иргэдийн сонгуулийн үйл явцын талаарх сөрөг хүлээлт, төсөөлөл нь өндөр хувьтай байгааг ч энэ шалтгаанаар тайлбарлаж болох юм. Дурдсан хоёр дүүрэг нь хүн амын төвлөрөл ихтэй, шилжин ирэлт өндөртэй тэр хэрээр сонгуулийн маргааны талбар болдог бизээ.

Санал асуулгын үр дүнгээс цааш үзвэл энэ удаагийн сонгууль шударга, хууль ёсны дагуу явж өнгөрсөн гэх эерэг үнэлгээ хамгийн өндөртэй орон нутагт Өмнөговь аймаг болон нийслэлийн Баянгол дүүрэг орж байна.

**Хүний сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт болон түүний зөрчлийн талаарх иргэдийн хүлээлт, төсөөлөл**


Дээрхээс гадна санал асуулга судалгааны хүрээнд хүний сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн талаарх иргэдийн үнэлгээг сонирхон судалсан юм. Ингэж үзэхэд хүний сонгох, сонгогдох эрх хэрхэн хэрэгжиж байгаа талаарх асуултанд иргэдийн өгсөн хариултын байдал нь сонгууль шударга бус, хууль зөрчсөн байдлаар явагдаж байгааг басхүү батлан харуулахуйц үр дүн гарчээ.

Тухайлбал, таван сонгогч дутмын нэг нь сонгуулийн үед орон нутагт зарим нэг зөрчил, булхай гардаг гэсэн бол мөн тийм тооны сонгогчид сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт орон нутагт хангалтгүй гэж хариулсан байна.

Харин судалгаанд оролцогчдын тэн хагас орчим хувь нь орон нутагт хүний сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт хангалттай хэрэгждэг гэсэн үнэлгээ өгчээ.

Хэдийгээр дээрх эрхийн хэрэгжилтийн талаар сонгогчдын нилээд хэсэг нь ийнхүү эерэг үнэлгээ өгсөн ч, сонгогчдын 20 орчим хувь нь эл эрхийн хэрэгжилтийн талаар хангалтгүй, түүнчлэн 40-өөд хувь нь үнэлж дүгнэх мэдлэггүй явж байгаа нь сонирхол татаж байна.

Энэ бүхэн нь хүний сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийг учир дутагдалтай гэж үзэх үндэстэй бөгөөд тэр хэмжээгээр эл эрхийн зөрчлийн бодит тохиолдлууд нуугдаж байгаа нь тодорхой юм.



“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. График 4

Ер нь сонгуулийн гэж тодотгохгүйгээр хүний бүхий л эрхүүд зөрчигдөж байгаа нэг үндсэн шалтгааныг хуулийн хэрэгжилт муу байгаатай иргэдийн зүгээс холбон үзэх нь нийтлэг байсан болно. Хууль эрх зүйн хэм хэмжээ хөдөлшгүй хэрэгжих нь хүний эрх, эрх чөлөө сайн хангагдаж, биелэлээ олох үндэс гэж иргэд үзсэн ч амьдрал дээрх эл талын үзүүлэлт нэн учир дутагдалтай гэдгийг онцолж байв.

Тухайлбал: иргэдтэй хийсэн ярилцлагын явцад олон нийтийн эл хандлага ажиглагдсан юм.

*Хүний сонгох, сонгогдох эрх хэрэгжихгүй байна. Хууль дүрмийн хэрэгжилт байхгүй шүү дээ, энэ нь хэн нэгэн эрхээ эдлэхэд саад болж байна. Тухайлбал сонгуулийн сурталчилгааны үед хуулиар хориглосон зүйлсүүд амьдрал дээр бүгд л явж байгаа шүү дээ. Жишээ нь эд мөнгө, бэлэг сэлт өгөх, тэмцээн уралдаан, сонгуульд хамаарахгүй ажлууд зорилго нь тодорхой. Хуулийн байгууллага нь өөрсдөө хуулиа зөрчөөд байхлаар хууль нь хэрэгжихгүй байгаа. Хариуцлагын тогтолцоо алга, мөнгөтэй хүмүүст хууль үйлчлэхгүй байна, хуулийн хэрэгжилтэндээ анхаарах хэрэгтэй*  
 Дархан-Уул. Бүлгийн ярилцлага.

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” чанарын судалгаа. НСХ 2004 он

*Юуны түрүүнд сонгуульд нэр дэвшигчид харилцан бие биенээ хүндэтгэж сонгуульд шударгаар өрсөлдөх хэрэгтэй. Сонгуулийн компани ажлын хүрээнд аливаа зүйлийг хууль зөрчихгүйгээр явуулах хэрэгтэй гэж бодож байна. Түүнчлэн сонгуулийн хуулийг зөрчсөн тохиолдолд буруутай этгээдэд зохих хариуцлага оногдуулдаг байх нь зүйтэй. Хөвсгөл аймгийн ИТХ-ын төлөөлөгчийг сонгох сонгуулийн 18-р тойрогт нэр дэвшигч Б.Доржготов*

ХЭҮК –ийн Итгэмжлэгдсэн Төлөөлөгчдийн авсан чанарын судалгаа. 2004 он

Бүлгийн ярилцлагын явцад гарсан дээрх хандлага хийгээд санал асуулгаар иргэдийн 40 орчим хувь нь сонгох, сонгогдох эрх сайн хэрэгжихгүй байгаа гэж үзсэн зэргээс харахад хэд хэдэн зүйлийг дүгнэж болохоор байна.

- хууль эрх зүйн хэм хэмжээний хэрэгжилт хангалтгүй,
- хэрэгжих баталгаа, механизм үгүй,
- түүнчлэн хуулийн боловсронгуй бус байдал
- сайн хууль тогтоомж байсан ч түүнийг нийгмийн зүгээс үл хүндэтгэх, зөрчсөн байдал гаргах, түүнийгээ жишиг мэт үзэх болсон ба энэ нь сонгуулийн үед газар авсан

зэрэг нь иргэд сонгох, сонгогдох эрхээ эдлэхэд саад тотгор учруулж байгаа ажээ.

Судалгааны үр дүнгээс тэмдэглэх хэрэгтэй бас нэг зүйл бол иргэдийн нилээд хэсэг нь сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн талаар үнэлж дүгнэж чадахгүй байгаа явдал юм.

Төр засгийн эрх мэдэл ард түмний өөрсдийн гарт байх, цаашилбал иргэд өөрсдийн төр засгаа байгуулах амин чухал эрхийн талаар өнөөдөр иргэдийн нэлээдгүй хэсэг мэдлэг туршлага хангалтгүй явж байгаа нь анхаарал татсан асуудлын нэг мөн.

Үүний сацуу иргэд, олон нийтийн зүгээс хүний эрхийн хэрэгжилтийн талаар үнэлэх нь тийм амар зүйл биш, тэр дундаа хүний сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн талаар үнэлэх нь бэрхшээлтэй болох нь ч харагдаж байна. Судалгаанд оролцсон иргэдийн 36 хувь нь сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн талаар үнэлж мэдэхгүй байлаа.

Энэ нь цаашилбал иргэд олон нийтийн улс төрийн идэвхи, оролцоо сул байдлаас ч хамаарч байгаа нь дамжиггүй боловч иргэдэд хүний эрхийн боловсрол олгох, сонгох, сонгогдох эрхийн талаар сурталчлан таниулан мэдүүлэх ажил төдийлөн сайн явдаггүйтэй холбоотой.

Ажиглалтын судалгаагаар орон нутгуудад сонгуулийн үеэр иргэдийн сонгох, сонгогдох эрхийн талаар сурталчлах ажил нийтлэгээр хангалтгүй байсан нь харагдсан.

*Орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гарах нийтлэлүүдэд нэр дэвшигчдийн сурталчилгаа зонхилж байсан боловч, иргэдийн сонгох, сонгогдох эрхийг нь тайлбарлан таниулах, сонгуулийн хуулийн иргэдтэй холбоотой, тэдний зайлшгүй мэдэх ёстой зүйл заалтуудыг сурталчлах, сонгогчдын эрх хэрхэн зөрчигддөг, үүнээс хэрхэн хамгаалах талаар ямар ч зүйл яригдахгүй байлаа  
Хөвсгөл аймаг. Ажиглалт ХЭК-ийн төлөөлөгч.*

Хүний сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн талаарх иргэдийн дээрх үнэлгээг орон нутгийн харъяалал, нас, боловсролын түвшин зэрэг нийгмийн шинжүүдтэй нь харьцуулан үзэх нь судалгааны нэгэн зорилт болж байсан юм. Эхлээд насны бүлгүүдийн зүгээс хүний сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн байдлыг үнэлснийг сонирхоё.

Судалгаанд оролцсон залуу үеийнхний 40 орчим хувь нь хүний дээрх эрх хангалттай хэрэгжиж байгаа гэж хариулсан бол тэдний 16 хувь нь хангалтгүй, харин 44.3 хувь нь хэлж мэдэхгүй байна гэжээ. Тэгвэл дунд үеийнхний 46 орчим хувь нь хангалттай хэрэгжиж байгаа, 21.4 хувь нь хангалтгүй гэсэн бол 32 хувь нь энэ талаар үнэлж чадаагүй болно.

Энэ үнэлгээг цаашид ахмад үеийнхний хувьд авч үзвэл энэ бүлгийнхний 65 хувь нь хүний сонгох, сонгогдох эрх хангалттай хэрэгжиж байгаа гэж хариулсан бол 14 хувь нь эл эрхийн хэрэгжилт хангалтгүй гэжээ.

Ахмадуудын дунд энэ талаар үнэлж мэдэхгүй байх нь дээрх хоёр бүлгийнхнийг бодвол харьцангуй бага хувьтай байна. Насны бүлэг дээшлэх тусам хүний сонгох, сонгогдох эрх хангалттай хэрэгждэг гэж үзэх нь ихэсч, энэ талаар үнэлж мэдэхгүй иргэдийн тоо буурч байна.

Эндээс хоёр зүйлийг тэмдэглэж болох бөгөөд нэг талаас залуучуудын хувьд улс төрийн идэвхи, оролцоо нь бусдыг бодвол бага байгаа нь харагдаж байна. Залуучуудын сонгуулийн оролцооноос энэ нь тодорхой харагдахын сацуу судалгааны явцад залуучууд сонгуульд идэвхгүй ханддагаас сонгох эрхээ эдэлж чаддаггүй гэсэн хандлага гарч байсныг тэмдэглэх хэрэгтэй. Тиймээс тэдний дунд сонгох эрхийн хэрэгжилтийн талаар үнэлж чадахгүй хувь хэмжээ харьцангуй өндөр байна.

Нөгөө талаас ахмадууд нийгэм орчиндоо шүүмжлэлтэйгээр хандах нь залуу үеийнхнийг бодвол харьцангуй бага байдгаас сонгох эрхийн хэрэгжилт хангалттай гэсэн үнэлгээ тэдний дунд илүү ажиглагдсан бол сонгох эрх хангалтгүй хэрэгжиж байгаа талаар залуучуудын төсөөлөл өндөр байгаа юм.

Санал асуулга, судалгаа явагдсан орон нутгуудын иргэдийн зүгээс сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн талаар ямар төсөөлөл, хүлээлттэй байгааг басхүү харж болох юм.

Иргэдийн үнэлгээ хийгээд тэдний орон нутгийн харъяаллын харьцуулсан үр дүнгээс үзэхэд хүний сонгох эрхийн хэрэгжилт харьцангуй сайн үзүүлэлттэй нь дүүргүүдээс Хан-Уул, харин аймгуудаас Өмнөговь болж байв. Тэгвэл дээрх эрхийн хэрэгжилт муу сул байгаа газруудад Дархан-уул аймаг болон хотын Баянзүрх дүүрэг зэргийг хэлж болохоор үр дүн гарчээ.

Дээр дурдсанчлан сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн талаарх иргэдийн санал бодлыг тэдний боловсролын түвшинтэй харьцуулан үзлээ. Боловсролын бүлгүүдийн зүгээс энэ асуудалд хэрхэн хандаж буйг доорх хүснэгтээс нарийвчлан харж чадна.

### **Хүний сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн талаарх иргэдийн хүлээлт, төсөөлөл**

/боловсролын түвшингээр/

	Хангалттай	Хангалтгүй	Хэлж мэдэхгүй	Нийт
Дээд	42.9	26.0	31.1	100.0
Тусгай дунд	48.3	16.3	35.4	100.0
Бүрэн дунд	39.6	16.6	43.8	100.0
Бүрэн бус дунд	52.3	11.4	36.4	100.0
Бага	71.0	3.2	25.8	100.0
Боловсролгүй	73.7	.0	26.3	100.0

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” тоон судалгаа НСХ 2004 он. Хүснэгт 3

Иргэдийн санал бодол хийгээд тэдний боловсролын түвшинтэй холбоотой ажиглагдаж буй эхний зүйл бол дурдан буй эрхийн хэрэгжилтийн талаарх эерэг болон сөрөг үнэлгээний өөрчлөлт юм. Тодруулбал боловсролын түвшин ахих тусам сөрөг үнэлгээ ихэсч, эерэг үнэлгээ буурч байна.

Харьцангуй боловсрол багатай иргэдийн олонхи нь сонгох, сонгогдох эрх амьдрал дээр хэрэгжиж байгаа гэж үздэг бол боловсролын түвшин өндөрсөх тусам ингэж үзэх нь багасчээ. Харьцангуй боловсрол өндөртэй хоёр иргэн дутмын нэг нь ийнхүү үнэлсэн ба хүний эрхийн хэрэгжилтэд шүүмжлэлтэй хандах нь илүү хувьтай байна.

Тухайлбал дээд боловсролтой дөрвөн иргэн дутмын нэг нь хүний сонгох, сонгогдох эрх хэрэгжихгүй байгаа гэж үзсэн юм. Харин эрхийн хэрэгжилтийн талаар үнэлж мэдэхгүй байх явдал нь иргэдийн боловсролын түвшингөөс төдийлөн хамаарахгүй байгаа ба иргэдийн энэ асуудлыг сонирхох байдал нь боловсрол ихтэй юмуу багатай байхаас шалтгаалдаггүй гэж хэлж болно.

### **Хүний сонгох, сонгогдох эрх зөрчигдөж буй нийтлэг хэлбэрүүд**

Сонгох, сонгогдох эрх бүрэн дүүрэн хэрэгжихгүйд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар санал асуулга болон ажиглалтын судалгааны үр дүнд тулгуурлан авч үзлээ.

Юуны өмнө санал асуулга судалгааны үед иргэдээс асуусан нээлттэй асуултанд өгсөн хариултуудаас хамгийн нийтлэг тааралдах тохиолдлуудыг авч үзье. Дурдсан асуулт нь орон нутагт хүний сонгох, сонгогдох эрх хэрхэн зөрчигдөж байгааг илрүүлэх, зөрчигдөх тодорхой нөхцлүүдийг илрүүлэх зорилготой байлаа.

“Хүний сонгох, сонгогдох эрх хэрэгжиж чадахгүй байгаа нь юутай холбоотой вэ” гэсэн нээлттэй асуултанд иргэдийн зүгээс янз бүрийн хариултууд ирсэн бөгөөд тэдгээрээс бүлэглэн, нэлээд нийтлэг тааралдахаас нь багцлан авч үзэхэд орон нутагт хүний сонгох, сонгогдох эрх зөрчигдөхөд хүргэж байгаа болон эл эрх хэрэгжихгүй байгаа дараах нийтлэг тохиолдлууд байна.

**Хүний сонгох, сонгогдох эрх зөрчигдөж байгаа хэлбэрүүд**

- Нэр дэвшигчээс худал амлалт өгөх
- Иргэдийн идэвхи, оролцоо сул
- Мөнгө эд зүйл тараах, санал худалдан авах
- Нэр дэвшигчид бие биеэ гүтгэн доромжлох
- Иргэдийн улс төрийн болон сонгуулийн мэдлэг, боловсрол хангалтгүй
- Бичиг баримт, хаягийн бүртгэлийн журмын будлиантай байдал
- Сонгуулийн хэсгийн хорооны ажил муу
- Орон нутгийн захиргаанаас сонгогчдод үзүүлдэг нөлөөлөл, шахалт
- Сонгуулийн хууль амьдралд нийцэхгүй
- Нэрсийн жагсаалтгүй байхгүй юм уу байх ёсгүй сонгогчдоор санал өгүүлэх
- Нэг нам илт давамгайлдаг

Иргэдээс хүний сонгох, сонгогдох эрх хангалтгүй хэрэгжиж байгаа шалтгаануудыг нэрлэснээс нийтлэг тааралдаж байгаагаас нь эхлэн ийн жагсаан үзвэл юуны өмнө сонгуулийн сурталчилгааны үеэр ид хүчээ авдаг нэр дэвшигчдийн амлалт хамгийн олон тааралдаж байлаа.

УИХ –ын сонгуулиас эхээ авсан нам эвсэл, нэр дэвшигчдын зүгээс иргэд, олон нийтэд янз бүрийн биелэгдэшгүй амлалт өгөх, энэхүү хоосон амлалтуудаараа өөр хоорондоо өрсөлдөх, уралдах хандлага орон нутгийн сонгуульд тэр хэвээрээ хуулбарлагдан буух болсон нь сүүлийн үед сонгуулиас ажиглагдаж байв.

*Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг шуурхай хэрэгжүүлж, итгэлийн 10.000 төгрөгийг олгох ажлыг орон нутагт зохион байгуулна. Зүүн тэнхлэгийн автозамыг байгуулж дуусган, Монгол улс, БНХАУ-ыг автозамаар холбоно. Бичиг баримтын судалгаа. Дорноговь. Эх Орон –Ардчилал эвслийн сурталчилгаа материал.*

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” чанарын судалгаа. НСХ 2004 он

*Зуун мянган метр квадрат талбайтай тохилог орон сууц барина. Бичиг баримтын судалгаа. Хэнтий. Эх Орон –Ардчилал эвслийн сурталчилгаа материал*

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” чанарын судалгаа. НСХ 2004 он

Эдгээр амлалтууд нь аймаг, сум, багийн ИТХ –д нэр дэвшигчдээс өгсөн амлалт бөгөөд нэг аймгийн төсвийн хүрээнд бүү хэл улс орон маань ч нийлээд энэ дөрвөн жилд хийж амжимгүй ийм төрлийн амлалт, сурталчилгаа нь хүний сонгох, сонгогдох эрх зөрчигдөх нийтлэг шалтгаан хэмээн иргэд үзэж байна.

Нэр дэвшигчид хэдийгээр өөрсдийн талаар мэдээлэх, сурталчлах тухайлбал төрийн байгууллагад сонгогдсон тохиолдолд хэрэгжүүлэх хувиасаа болон намаасаа дэвшүүлж буй хөтөлбөрөө танилцуулах хууль ёсны эрх хэмжээтэй хэдий ч энэ бүхэн нь зөвхөн санал авахад баримжаалсан хоосон амлалт болж хувирах нь түгээмэл байна.

Түүнчлэн хүний сонгох, сонгогдох эрх хангалттай хэрэгжиж чадахгүй байгаа нэг нийтлэг шалтгаан нь иргэд, олон нийтийн улс төрийн идэвхи,



оролцоо тухайлбал аль нэг шатны сонгуульд оролцох, санал өгөх түвшин бага байгаагаас үүдэлтэй гэжээ.

Нийгмийн бүлгүүдийн зүгээс сонгуульд оролцох идэвхи харилцан адилгүй байгаа талаар судалгаанд оролцогчид авч үзсэн бөгөөд нэн ялангуяа залуучуудын идэвхи сул байгаа нь сонгох, сонгогдох эрхээ тэд эдэлж чадахгүйд хүргэж байна.

Үүний зэрэгцээ залуучуудын дунд төдийгүй бусад бүлгүүдийн дунд ч “сонгуульд оролцож саналаа өгсөн ч, өгөөгүй ч юм өөрчлөгдөхгүй” гэсэн улс төрөөс хөндийрөн хүнийсэх хандлага нэмэгдэж буй нь судалгааны дүнгээс харагдаж байна. Учир нь сонгогчид хэдийгээр сонгуульд оролцох эсэх нь заавал биелүүлэх үүрэг биш ч олон сонгогч саналаа өгөхгүй байгаа нь сонгох эрх хангалттай хэрэгжихгүй байгаа хэрэг гээд, нэн ялангуяа залуучуудын дунд ийм хандлага бий болсныг иргэд онцолж байлаа.

Судалгаанд оролцогчдын зүгээс хүний сонгох, сонгогдох эрх хэрэгжиж чадахгүй байгааг сонгуулийн үеэр сезон нь ордог нэр дэвшигчдээс сонгогчдод хүргэх бэлэг сэлтүүдтэй холбон тайлбарлаж байв.

*Нэр дэвшигчид дайллага зохион байгуулж, хөгшчүүлд будаа гурил цай тараасан. Өмнөговь. ХЭК-ийн төлөөлөгч. Ажиглалт.*

*Зарим айлд тусламжийн хувцас будаа сахар өгсөн. Орхон. ХЭК-ийн төлөөлөгч. Ажиглалт.*

Нэр дэвшигчдээс сонгогчдын саналыг худалдан авах, ингэхийн тулд мөнгө эд зүйл олон нийтийн дунд тараах, үүнийгээ сонгуулийн кампанит ажлынхаа салшгүй нэг хэсэг болгох нь сүүлийн сонгуулиудад нэлээд өргөн дэлгэрсэн зүйл гэдгийг судалгаанд оролцогчдоос хүлээн зөвшөөрчээ.

Сонгуулийн кампанит ажлын үеэр нэр дэвшигчдийн сурталчилгааны үндсэн зорилго нь өөрийгөө олон нийтэд нээн харуулах, тэдэнд зорилго үйл ажиллагаа, давуу талаа таниулахад чиглэгдэх ёстой атал өрсөлдөгч рүүгээ дайрч довтлохыг гол баримжааллаа болгодог нь нийтлэг аж.

Энэ мэт байдал нь сонгуулийн кампанит ажлын үеэр нэр дэвшигчдийн дунд бие биеэ гүтгэн доромжлох, нэр дэвшигч өрсөлдөгч рүүгээ чиглэсэн олон нийтийн сөрөг ажиллагаа / сөрөг PR / гаар хөөцөлдөхөд хүргэж байна.

Үүнийгээ байдаг зүйл мэт өрсөлдөгч талууд хүлээн зөвшөөрөх хандлага нь хүний сонгогдох хийгээд сонгох эрхийн аль аль нь зөрчигдөхөд хүргэж байгаа юм.

Нэр дэвшигч нарын хувьд ул үндэсгүй гүтгүүлэх, өөрсдийн талаар худал хуурмаг мэдээлэл хүргүүлэх зэргээр сонгогдох эрхээ эдлэж чадахгүйд хүрч байхад, иргэдийн хувьд нэр дэвшигчдийн талаар үнэн зөв мэдээллээр хангагдаж чадахгүйд хүрч сонгох эрхээ эдэлж чадахгүйд хүрдэг гэжээ. Энэ байдлыг дараагийн хэсэгт дурдагдах нэр дэвшигчдийн талаарх мэдээллийн агуулгийн талаарх иргэдийн үнэлгээнээс харж болно.

Судалгааны хүрээнд ажиглагдсан нэг зүйл бол иргэдэд улс төрийн болон сонгуулийн талаарх мэдлэг, мэдээлэл хомс байгаа нь тэдний зүгээс сонгох эрхээ эдлэж чадахгүйд хүргэдэг байна.

Олон нийтийн асуулга судалгааны үед нээлттэй асуултанд хариулсан байдлаас үзэхэд сонгуулийн хэсгийн хорооны үйл ажиллагааны учир дутагдалтай байдлаас болж аль нэг орон нутагт хүний сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь харагдсан юм.

Сонгуулийн явцад орон нутгийн захиргааны ямар нэг албаны хүмүүсээс сонгогчдод нөлөөлөх, тодорхой шахалт үзүүлэх оролдлого гаргадаг нь

судалгааны явцад ажиглагдсан бөгөөд энэ нь хүний сонгох, сонгогдох эрхийн зөрчилтэй холбоотой анхаарал татсан асуудлын нэг мөн.


Сонгуулийн хууль, тогтоомжийн боловсронгуй бус байдлаас энэ салбар дахь хүний эрх зөрчигдөж байгаа тухай ч мөн асуулга судалгааны үед тавигдсан нээлттэй асуултанд иргэд хариулж байсныг тэмдэглэх хэрэгтэй.

### **Сонгуульд нэр дэвшигчдийн талаарх мэдээллээр иргэд хангагдсан байдал**

Хүний сонгох, сонгогдох эрхийг хангах, эл эрх хэрэгжих нэг үндэс нь сонгогчид бүхэлдээ сонгуулийн талаар мэдээллээр хангагдах явдал юм. Сонгогчдын зүгээс зайлшгүй авах ёстой дээрх мэдээллийн нэг чухал хэсэг нь нэр дэвшигчдийн тухай юм.

Судалгааны хүрээнд сонгогчид нэр дэвшигчдийн талаарх мэдээллээр хэрхэн хангагддаг тухай хөндөж, бүх шатны сонгуульд нэр дэвшигчийн талаарх мэдээллийн тархац, түвшинг сонирхсон юм.

### **УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн талаарх мэдээллийн хүртээмж**



“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. График 5

Юуны өмнө сонгогчид УИХ-д нэр дэвшигчийн тухай мэдээллийг бусад шатны нэр дэвшигчдээс илүү ихээр хүлээн авдаг болох нь харагдаж байна.

УИХ-д нэр дэвшигчдийн талаарх мэдээлэл тархалт, түгэлтийнхээ байдлаар бусдаасаа харьцангуй өндөр байлаа. Иргэдийн олонхи нь буюу 63.4 хувь нь тус шатны сонгуульд нэр дэвшигчдийн талаарх мэдээлэл хангалттай авдаг гэсэн байхад дөнгөж 6 хан хувь нь энэ талын мэдээлэл хангалтгүй гэж үзсэн юм.

Харин сонгогчдын 23,6 хувь нь буюу таван сонгогч тутмын нэг нь УИХ-д нэр дэвшигчдийн талаарх мэдээллийн хүртээмжийг дунд зэрэг гэж хариулжээ.

Мэдээж хэрэг УИХ-ыг сонгох нь төрийн дээд эрх мэдэл бүхий байгууллагыг байгуулах утгаараа улс орны хэмжээнд илүү их анхаарлын төвд байж, нийгэм бүхэлдээ улс төрийн уур амьсгалд байдагтай холбоотойгоор энэ үйл явцад бүлгүүд илүү ихээр татагдан ордог нь дамжиггүй.

Тиймээс энэ шатны сонгуулийн мэдээлэл ч сонгогчдын анхаарлыг илүү ихээр татаж чаддаг болох нь харагдаж байна.

Харин энэ шатны сонгуульд нэр дэвшигчдийн талаарх мэдээллээр хангагдсан түвшинг иргэдийн орон нутгаар нь үзвэл арай илүү тодорхой үр дүнг харж болох юм.

**УИХ-д нэр дэвшигчдийн талаарх мэдээллээр хангагдсан байдал**

/хувиар/

Дүүргүүд	Хангалттай	Дунд зэрэг	Хангалтгүй	Өөрөө сонирхоогүй	Нийт
Сонгинохайрхан	77.0	15.9	4.8	2.4	100.0
Хан-Уул	55.6	24.6	7.9	11.9	100.0
Баянгол	70.4	24.8	1.6	3.2	100.0
Баянзүрх	54.4	27.2	12.8	5.6	100.0
<b>Аймгууд</b>					
Өмнөговь	69.2	22.2	4.3	4.3	100.0
Ховд	68.2	20.0	6.4	5.5	100.0
Дархан-Уул	60.4	27.0	6.9	5.7	100.0
Дорнод	52.7	25.9	5.4	16.1	100.0

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. Хүснэгт 4

Нарийвчлан харваас дээд шатны сонгуульд нэр дэвшигчдийн талаарх мэдээллээр дүүргүүд болон аймгуудийн иргэдийн хувьд харилцан адилгүй хангагддаг гэж болно.

Нийслэл хотын хувьд Сонгинохайрхан энэ талын үзүүлэлтээр бусдаасаа харьцангуй дээгүүр байгаа бөгөөд иргэд нэр дэвшигчдийн талаар илүү мэдээлэлтэй байсан нь харагдаж байна. Харин Баянзүрх болон Хан-Уул дүүргүүдийн хувьд доогуур хувьтай байгаа юм.

Баянзүрх болон Хан-Уул дүүргийн хувьд хотын захын, төвөөс зайдуухан, хүн амын төвлөрөл, шилжин ирэгсэд өндөртэй зэрэг байдал нь сонгуулийн тэр дундаа сонгуульд нэр дэвшигчдийн талаарх мэдээлэл иргэдэд түгэх хэмжээ харьцангуй багасахад нөлөөлж байж болох юм.

Аймгуудын хувьд нэр дэвшигчдийн талаарх мэдээллийг хангалтгүй хэмээн үнэлсэн хувь хэмжээнд онцын зөрүүтэй байдал байхгүй байгаа ч, харин эл мэдээллийг хангалттай хүлээн авах түвшин нь харилцан адилгүй байна.

Дорнодын хувьд дээрх төрлийн мэдээллийн хүртээмж бусдаасаа нэлээд бага байгаа бол Өмнөговь, Ховдын иргэд нэр дэвшигчдийн талаарх мэдээллээр илүү хангадаг чадсан гэжээ.

УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн тухай мэдээллийн хүртээмжийг насны бүлгүүдийн авч үзвэл эл мэдээллийг хамгийн ихээр авч чадаж байгаа нь ахмадууд бөгөөд тэдний 77 орчим хувь нь хангалттай гэж хариулсан байна.

Харин насны бүлэг залуужих тутмаа энэ мэдээллийн хүртээмж багасчээ. Тухайлбал дунд үеийнхэн нэр дэвшигчдийн талаарх мэдээллийг хангалттай хүлээн авах нь ахмадаас 10 гаруй нэгжээр буурч 63 хувьтай байгаа бол, залуучууд 20 нэгжээр буурч тэдний 57 хувь нь л хангалттай мэдээлэлтэй байдаг гэж хариулсан юм.

Харин залуу болон дунд үеийнхний 25 орчим хувь нь тус тус хангалттай биш ч тодорхой хэмжээний мэдээллийг хүлээн авдаг байна. Залуу үеийнхний дунд мэдээлэл ийнхүү бага хүрэх нь сонгогчдын нэлээд хэсгийг тэд бүрдүүлдэг, нөгөө талаас энэ бүлгийн улс төрийн идэвхи харьцангуй сул байдагтай холбоотой.

Цаашид орон нутгийн сонгуульд тухайлбал аймаг нийслэлийн болон сум дүүргийн сонгуульд нэр дэвшигчдийн талаарх мэдээллийн хүртээмжийн талаар судалгааны дүнд тулгуурлан авч үзэх болно.

2004 оны орон нутгийн сонгуулийн явцыг өмнөх үеийнхтэй харьцуулахад хэд хэдэн онцлог шинжүүдийг нэрлэж болох авч, нэр дэвшигчдийн

сурталчилгаа тун өргөн, хүчтэй, олныг хамарсан нь хамгийн гол онцлог болсон гэж үзэж болно.

Иргэд орон нутгийн удирдах байгууллагыг сонгох сонгуульд нэр дэвшигчдийн тухай мэдээллээр хэрхэн хангагдсан байдлыг сонирхвол доорх дүр зураг ажиглагдана. Юуны өмнө энэ талын мэдээллээр иргэд хангагдах түвшин нь УИХ-ын сонгуулийн тохиолдолтой харьцуулахад 17 орчим нэгжээр буурчээ.

Сонгогчдын тэн хагас хүрэхгүй хувь буюу 46,6 хувь нь энэ шатны сонгуульд нэр дэвшигчдийн талаарх мэдээллийг хангалттай авдаг байна. Харин сонгогчдын 13 орчим хувь нь дээрх мэдээлэл хангалтгүй гэж хариулсан бол тэдний 30 гаруй хувь нь хангалттай биш ч тодорхой хэмжээгээр хүлээн авдаг гэжээ.

Судалгааны хүрээнд аймаг нийслэлийн сонгуульд нэр дэвшигчдийн тухай мэдээллийн хүртээмжийн байдлыг тодруулах зорилт тавьсан бөгөөд үр дүнгийн тухайд доорх графикаас харж болно.

### Аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн талаарх мэдээллийн хүртээмж



“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. График 6

Сонгогчдын тал хүрэхгүй хувь нь аймаг, нийслэлийн сонгуульд нэр дэвшигчдийн талаар хангалттай мэдээлэлтэй байдаг гэж үзсэн нь тийм ч өндөр үзүүлэлт биш бөгөөд энэ шатанд сонгогчид мэдээллийг төдийлөн сонирхон хүлээн авахгүй байх явдал нь дээд шатны сонгуультай харьцуулахад 3 нэгжээр илүү байна.

Судалгаанаас 10 сонгогч тутмын нэг нь эл шатны сонгуульд нэр дэвшигчдийн тухай мэдээллийг сонирхон хүлээдэггүй байхад харин түүнээс арай илүү хувь нь сонирхсон ч энэ талаар хангалттай мэдээлэл авч чаддаггүй гэжээ.

Энэ шатны сонгуульд нэр дэвшигчдийн талаарх мэдээллийг насны бүлгүүд хүлээн авах байдал нь харилцан адилгүй бөгөөд залуучуудын дөнгөж 36 хувь нь хангалттай хүлээн авдаг байхад 15 хувь нь мэдээлэл огт хангалтгүй гэж хариулсан юм. Харин ахмад хийгээд дунд үеийнхний 10 орчим хувь нь аймаг нийслэлийн сонгуульд нэр дэвшигчдийн тухай мэдээллийг хангалтгүй хүлээн авдаг байна.

Ахмад насныхан дээрх мэдээллийг бусад бүлгүүдээ бодвол хамгийн их хүлээн авч чаддаг болох нь харагдсан юм. Судалгаанд оролцсон ахмадуудын 70 гаруй хувь нь аймаг нийслэлийн сонгуулийн үеэр нэр

дэвшигчдийн талаар хангалттай мэдээлэл авч чаддаг гэж хариулсан нь залуучуудыг бодвол нэг дахин их байна.

**Аймаг нийслэлийн ИТХ-д нэр дэвшигчдийн талаарх мэдээллээр хангагдсан байдал**

/ орон нутаг хувиар/

Дүүргүүд	Хангалттай	Дунд зэрэг	Хангалтгүй	Өөрөө сонирхоогүй	Нийт
Сонгинохайрхан	57.9	21.4	13.5	7.1	100.0
Хан-Уул	42.1	27.8	15.9	14.3	100.0
Баянгол	58.4	28.8	7.2	5.6	100.0
Баянзүрх	32.8	39.2	16.0	12.0	100.0
<b>Аймгууд</b>					
Өмнөговь	59.8	27.4	7.7	5.1	100.0
Ховд	42.7	40.0	12.7	4.5	100.0
Дархан-Уул	45.9	30.8	17.0	6.3	100.0
Дорнод	32.1	34.8	14.3	18.8	100.0

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. Хүснэгт 5

Юуны өмнө тэмдэглэхэд аймаг нийслэлийн сонгуулийн нэр дэвшигчдийн талаарх мэдээлэл нь дээд шатныхтай харьцуулахад иргэдэд хүрэх хэмжээний хувьд ч, иргэдийн зүгээс сонирхох хандлага ч харьцангуй бага байна.

Дүүргүүдийн хувьд авч үзвэл дээд тал нь сонгогчдын 60 аад хувь нь нэр дэвшигчдийн талаар хангалттай мэдээлэл авдаг байхад зарим газарт бүр гурван сонгогч тутмын нэг нь дөнгөж авсан мэдээллээ хангалттай тооцсон юм.

Аймгуудын сонгогчдын хувьд дээд тал нь зарим газарт 60 орчим хувь нь нэр дэвшигчийн тухай мэдээллээр хангагдсан байхад зарим газар тухайлбал: Дорнодод тун доогуур үзүүлэлттэй, нэр дэвшигчийн талаарх мэдээлэл иргэдэд хангалтгүй, иргэд энэ талын мэдээллийг хүлээн авч чадахгүй байх нь нэлээд өндөр хувьтай гэж хэлж болно. Санал асуулгын үр дүнгээс харахад дүүргүүдэд сонгогчдын 13-16 хүртэл хувь нь нэр дэвшигчдийн талаар огт хангалтгүй мэдээлэлтэй байсан нь харагдаж байв.

Мөн түүнчлэн иргэдээс энэ шатны сонгуульд ач холбогдол өгөх, анхаарлаа хандуулах нь багасч ирдэг нь тодорхой байна. Энэ шатны сонгуульд нэр дэвшигчийн талаарх мэдээллийг сонирхоогүйн улмаас мэдээлэл тэр бүр аваагүй сонгогчдын эзлэх хувь УИХ-ын сонгуультай харьцуулвал мэдэгдэхүйц өсчээ. Сонгуулийн шат доошлох тутам түүнд иргэдийн оролцох оролцоо буурдагаас иргэд өөрсдийн орон нутгийн удирдлагаа сонгох эрхээ тэр бүр эдлэж чадахгүйд хүргэж байгаа юм.

Цаашид сум дүүргийн сонгуулийн шатанд энэ байдал улам тодорхой болж ирдэгийг харж чадна. Өөрөөр хэлбэл аймаг нийслэлийн шатны сонгуульд нэр дэвшигчдийн талаарх мэдээллийн байдлыг сум дүүргийн сонгуулийн шаттай харьцуулан үзэж болох юм.


Нэр дэвшигчийн талаарх мэдээллийг сонирхоогүй гэсэн хариултын хувь хэмжээ сум, дүүргийн шатны сонгуулийн хувьд өмнөх өмнөхөөсөө харьцангуй их байна. Эндээс анхан шатны сонгуульд оролцох сонгогчдын оролцоо улам багасч ба энэ шатны сонгуулийн нэр дэвшигчдийн талаарх мэдээллийг иргэдийн сонирхох байдал маш бага гэж болно.

Харин сонгогчид нэр дэвшигчдийн талаарх мэдээллийг хангалттай хүлээн авдаг байдал нь аймаг нийслэлийн болоод сум дүүргийн шатны сонгуулийн хувьд ойролцоо байхад, харин дээрх мэдээллийг хүлээн авч

чаддаггүй, хангалтгүй гэж хариулсан хувь нь сум, дүүргийн сонгуулийн шатанд аймаг, нийслэлийнхээс хоёр дахин их гарчээ.

Сум дүүргийн шатны сонгуульд нэр дэвшигчдийн талаар сонгогчид хангалттай мэдээлэл авч чадахгүй байгаа бөгөөд энэ нь тэд өөрсдийн төлөөллөө сонгоход бэрхшээл учруулдаг байна.

### Сум дүүргийн ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн талаарх мэдээллийн



“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. График 7

Анхан шатны сонгуульд нэр дэвшигчийн талаарх мэдээллийн хүртээмжийн байдлыг сонгогчдын насны бүлгүүдийн хувьд авч үзвэл хэд хэдэн зүйл ажиглагдсан юм. Юуны өмнө залуучууд энэ шатанд сонгуулийн болон нэр дэвшигчдийн талаарх мэдээллийг хүлээн авах түвшин эрс багасч, харин түүнийг үл сонирхох, анхаарахгүй байх нь эрс ихэсч ирдэг байна.

Судалгаанд оролцсон залуучуудын 30 хувь нь буюу гурван залуу сонгогч тутмын нэг нь анхан шатны сонгуульд нэр дэвшигчдийн талаарх мэдээллийг хүлээн авч чадаагүй гэсэн бол тэдний 20 гаруй хувь нь тэрхүү мэдээллийг өөрөө сонирхоогүй гэжээ. Залуу үеийнхний ийм хандлага нь эргээд энэ бүлэг сонгох эрхээ хангалттай эдлэж чадахгүйд хүргэж байгаа нь дамжиггүй.

Тэгвэл ахмад үеийнхний олонхи нь болох 73 орчим хувь нь сонгуулийн анхан шатанд ч мэдээлэл хангалттай авч чаддаг бөгөөд тэдний дөнгөж 6 орчим хувь нь л энэ талын мэдээллийг сонирхоогүй гэсэн нь залуучуудтай харьцуулахад нэлээд бага хэмжээ юм. Харин судалгаанд хамаргдсан дунд үеийнхнээс тал орчим нь сум дүүргийн сонгуульд нэр дэвшигчдийн талаар хангалттай мэдээлэл авсан гэж үзсэн ба 15 орчим хувь нь хангалтгүй гэсэн байна. Сонгуулийн энд дурдан буй шатан дах нэр дэвшигчдийн талаарх мэдээллийн хүртээмжийг сонгогчдын орон нутгийн харъяаллаар авч үзсэн юм.

**Сум, дүүргийн ИТХ-д нэр дэвшигчдийн талаарх мэдээллээр хангагдсан байдал**

Дүүргүүд	Хангалттай	Дунд зэрэг	Хангалтгүй	Өөрөө сонирхоогүй	Нийт
Сонгинохайрхан	51.6	18.3	19.8	10.3	100.0
Хан-Уул	45.2	23.8	12.7	18.3	100.0
Баянгол	56.0	26.4	5.6	12.0	100.0
Баянзүрх	23.2	31.2	24.8	20.8	100.0
<b>Аймгууд</b>					
Өмнөговь	52.1	22.2	18.8	6.8	100.0
Ховд	34.5	30.9	18.2	16.4	100.0
Дархан-Уул	46.5	24.5	18.2	10.7	100.0
Дорнод	25.0	25.0	21.4	28.6	100.0

"Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал" судалгаа НСХ 2004 он, Хүснэгт 6

Ерөнхийд нь авч үзвэл хот, хөдөө орон нутгаас үл хамааран нэр дэвшигчдийн талаарх мэдээллийн хүртээмж төдийлөн хангалттай байж чаддаггүй гэж болно. Зарим газарт энэ байдал бүр мэдэгдэхүйц хэмжээнд байгааг харж болох бөгөөд Баянзүрх дүүрэг, Дорнод аймгийн хувьд дөрвөн сонгогч тутмын нэг нь дээрх шатны сонгуульд нэр дэвшигчдийн талаар огт хангалтгүй мэдээлэлтэй байжээ.

Түүнчлэн анхан шатны сонгуульд иргэдийн зүгээс ач холбогдол өгөхгүй, сонирхолгүй хандах нь нэлээд өндөр байдаг байна.

**Сонгуульд нэр дэвшигчдийн талаарх мэдээллийн агуулга**

Судалгааны хүрээнд бүх шатны сонгуульд нэр дэвшигчдийн талаарх мэдээллийн хүртээмжийн байдлаас гадна энэ төрлийн мэдээллийн агуулгыг сонирхон судалсан юм. Ингэхдээ өнгөрсөн сонгуулиудад нэр дэвшигчдийн талаарх мэдээлэл нь агуулгын хувьд ямар шинж чанартай байсан тухай олон нийтийн үнэлгээг тодруулахыг зорьсон болно.

Судалгаанд оролцогчдын харьцангуй олонхи тал орчим хувь нь сонгуулийн үеэр нэр дэвшигчдийн талаарх мэдээллүүд нь тэдгээрийг танилцуулах шинжтэй байсан гэж үзсэн бол удаах буюу 18 хувь нь дээрх мэдээлэл хэт өрөөсгөл, нэг нам хүчнийг дэмжиж байсан гэж хариулсан байна. Харин 12,3 хувь нь сонирхолтой олон талыг хамарсан, 10 гаруй хувь нь нэр дэвшигчийн тухай хов жив хөөсөн, гүтгэсэн шинжтэй мэдээллүүд байсан гэж тус тус үзжээ.

Мөн түүнчлэн судалгаанд оролцогчдын хамгийн бага хувь болох 3 орчим хувь нь ихэвчлэн гутаан доромжилсон шинжтэй мэдээлэл байсан гэж хариулжээ.

Нэр дэвшигчийн тухай мэдээллийн шинж чанарын талаарх иргэд олон нийтийн үнэлгээг нарийвчлан харвал доорх байдалтай байна.

**Нэр дэвшигчийн тухай мэдээллийн агуулгын талаарх иргэдийн үнэлгээ**

Мэдээллийн агуулга	Хариултын тоо	Хувь
Нэр дэвшигчийг танилцуулах мэдээлэл байсан	522	52.2
Хов жив гүтгэлгийн шинжтэй зүйл байсан	102	10.2
Ихэвчлэн гутаан доромжлох зүйл байсан	29	2.9
Хэт өрөөсгөл, нэг нам хүчнийг дэмжсэн мэдээлэл	186	18.6

байсан		
Сонирхолтой олон талыг хамарсан мэдээлэл байсан	123	12.3
Өөр	38	3.8
Нийт	1000	100.0

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. Хүснэгт 7

Дээрхээс үзэхүл сонгуульд нэр дэвшигчдийн сурталчилгааны үед түгээгдсэн мэдээллийн агуулга нь хүний сонгох хийгээд сонгогдох эрхэд халдсан, сонгуулийн хуулийн хүрээнд байж чадаагүй буюу түүнийг зөрчсөн тохиолдлууд нэлээд байсан гэх үндэстэй юм.

Учир нь судалгаанд оролцогчдын 30 гаруй хувь нь сурталчилгааны үе дэх нэр дэвшигчдийн тухай мэдээлэл нь ямар нэг байдлаар хууль ёсны дагуу байж чадаагүй гэжээ. Тухайлбал: сонгогчдод ирсэн мэдээлэл хэт өрөөсгөл, нэг нам, хүчнийг дэмжсэн, эсвэл нэр дэвшигчид өрсөлдөгчдөө гүтгэсэн, түүний талаар үндэсгүй яриа, хов живээр хөөцөлдсөн, цаашилбал гутаан доромжилсон, нэр төрд нь халдсан зэргээс харагдаж байна.

*Бид хөдөө амьдардаг хүмүүс, хоёр намын сурталчилгаа адилхан бие биеэ муулсан байдлаар явагдсан. Ер нь сонгуулийн сурталчилгаа хийдэг хүмүүсийг тодорхой шалгуур хангасан байдлаар сонгон ажиллуулж баймаар юм. Ядаж л өөрийн нэр дэвшигчээ үнэн зөв зүйтэй танилцуулчихдаг, бусад намаа муулж хэл амаа билүүддэггүй тийм хүмүүсээр тавимаар байна. Шууд орж ирээд манай намд санал өгнө шүү гээд янз бүрийн юм ярьж ухуулж эхэлдэг. Өмнөговь аймаг. Бүлгийн ярилцлага*

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” чанарын судалгаа. НСХ 2004 он

Сонгуулийн үеэр аль нэг улс төрийн нам хүчин эрх мэдлийн байдлаа ашиглан хэвлэл мэдээллийн хэрэгслийг давуу байдлаар эзэмших, засаг захиргааны бүтцийг ашиглах зэргээс үүдэн нэг нам, хүчний нэр дэвшигчийн тухай мэдээлэл сонгогчдод зонхилон хүрч, хэт өрөөсгөл байдал бүрдсэн гэжээ.

Энэ байдал нь юуны өмнө өнгөрсөн сонгуулиудын үеэр хүний сонгох хийгээд сонгогдох эрхийн аль аль нь хангалттай хэрэгжсэн гэж үзэхэд эргэлзээ төрүүлж байна.

Мөн дээр дурдсанчлан улс төрийн нам, хүчнүүд болон нэр дэвшигчид сурталчилгааны ажилдаа олон нийттэй харилцах хар ажиллагаа болох хов жив, гүтгэлэг, гутаах зэрэг үйлдлээр хөөцөлдөх болсон нь сонгогчид үнэн худлыг тогтоох боломжгүй олон янзын мэдээллийн дунд сонголтоо хийхэд хүрдэг болох нь харагдсан юм. Харин нөгөө талаас нэр дэвшигчдийн зүгээс сонгогдох эрх нь эл бүгд үйлдлүүдийн улмаас хохирч байгаа нь тодорхой байна.

Нэр дэвшигчийн талаарх мэдээллийн агуулгад иргэдийн зүгээс өгсөн үнэлгээг тэдний орон нутгийн харъяаллаар харвал доорх байдалтай байна.



**Сонгуулийн үеэр нэр дэвшигчдийн талаарх мэдээллийн агуулга**

Дүүргүүд	Танилцуулах	Хов жив гүтгэлгэ	Гутаан доромжлох	Хэт өрөөсгөл нэг нам хүчний талд	Сонирхолтой олон талыг хамарсан	Бусад	Нийт
Сонгинохайрхан	59.5	11.1	1.6	19.0	7.9	0.8	100.0
Хан-Уул	54.0	9.5	2.4	17.5	11.9	4.8	100.0
Баянгол	56.8	7.2	4.8	11.2	15.2	4.8	100.0
Баянзүрх	53.6	12.0	3.2	16.8	12.8	1.6	100.0
<b>Аймгууд</b>							
Өмнөговь	65.8	2.6	.0	11.1	13.7	6.8	100.0
Ховд	41.8	9.1	1.8	33.6	13.6	.0	100.0
Дархан-Уул	42.8	13.8	3.8	20.8	14.5	4.4	100.0
Дорнод	44.6	15.2	5.4	19.6	8.0	7.1	100.0

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. Хүснэгт 8

Янз бүрийн орон нутгуудад сонгуулийн үеэр иргэдэд хүрсэн нэр дэвшигчийн талаарх мэдээллийн 50-80 орчим хувь нь харьцангуй эрүүл саруул, тэнцвэртэй шинжтэй байсан гэж үзэж болохоор байна. Орон нутгууд дахь улс төржих үйл явц, өрсөлдөөн зэргээс хамаарч хов жив, гүтгэлгийн чанартай мэдээлэл нэлээд өндөр хувьтай байна. Нийт мэдээллийн 10 гаруй хувь зарим нэг газарт 20 орчим хувь нь тийм шинж чанартай байснаас үзэхүл тэнд хүний сонгох, тэр дундаа сонгогдох эрх баттай хэрэгжсэн гэж үзэх үндэсгүй аж.

Мөн түүнчлэн орон нутгууд дахь улс төрийн нам хүчнүүдийн хүчний харьцаа, тэнцвэргүй байдал, засаглалд эзэлж байсан байр сууриас хамаараад нэр дэвшигчийн талаарх мэдээлэл нь хэт өрөөсгөл, нэг талыг барьсан шинжтэй байж, иргэд ийм өрөөсгөл мэдээлэлд тулгуурлан саналаа өгөхөд хүрсэн гэжээ. Тухайлбал нийслэлийн дүүргүүдээс Сонгинохайрхан, Хан-Уул, Баянзүрх, аймгуудаас Ховд, Дархан-Уул, Дорнод зэрэг газруудад эл нөхцөл байдал тодорхой харагдаж байна.

Дурдсан газруудад нэр дэвшигчдийн талаар хэт өрөөсгөл, нэг талыг барьсан мэдээлэлтэй байсан гэж иргэдийн 16-аас 30 хүртэл хувь нь хариулсан юм.

Нэр дэвшигчдийн талаарх мэдээллийн агуулгад өгсөн сонгогчдын үнэлгээг тэдний боловсролын түвшингээр харвал дараах хандлага ажиглагдсан болно. Дээд боловсролтой бүлгийн 10.7 хувь нь сонирхож буй мэдээлэл хов жив, гүтгэлгийн шинжтэй байсан гэсэн бол мөн 4 хувь нь гутаан доромжилсон өнгө аястай, 18.6 хувь нь хэт өрөөсгөл, нэг талыг барьсан шинжтэй мэдээлэл байсан гэжээ.

Боловсролын ялгаатай бүлгүүдээр цаашид сонирхвол тусгай дундчууд болон дээд боловсролтой бүлгүүдийн мэдээллийн агуулгыг үнэлсэн байдалд онцын ялгаатай зүйл үгүй байна. Бүрэн дунд боловсролтой бүлгийн 10 орчим хувь нь мэдээлэл хов жив, гүтгэсэн байдалтай гэж хариулсан бол 20 гаруй хувь нь мэдээлэл хэт өрөөсгөл нэг талыг барьсан гэж үзсэн юм. Харин бага болон боловсролгүй сонгогчдын 20 орчим хувь нь хэт нэг талыг барьсан, өрөөсгөл мэдээлэл байсныг хүлээн зөвшөөрчээ.

Харин нэр дэвшигчийн талаарх мэдээллийн агуулгад сонгогчдын зүгээс өгсөн үнэлгээнд боловсролын бүлэг тус бүрээс эерэг үнэлгээ давамгайлж байсныг тэмдэглэх хэрэгтэй. Тухайлбал дээрх боловсролын ялгаатай бүлэг тус бүрийн сонгогчдын 60 – 80 орчим хувь нь эл мэдээллийн

агуулга хууль ёсны, шударга байсан гээд ердийн танилцуулсан, мэдээлсэн, сонирхолтой олон талыг хамарсан байсан хэмээн үнэлсэн юм.

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр сонгуулийн үед цацагдсан нийтлэлийн агуулгад хийсэн судалгааны дүнгээс харахад дээрх байдлууд нэлээд тодорхой харагдсан юм. Орон нутгийн сонгуулийн үеэр нийслэлийн телевизүүдээр гарсан сонгуулийн сурталчилгааны төрлүүдэд шинжилгээ хийснээс 66.7 хувь нь энгийн сурталчилгаа, 8.4 хувь нь нэр дэвшигчтэй хийсэн ярилцлага, 11.1 хувь нь мэдээ, мэдээлэл, 12.0 хувь нь нам хүчний захиалгат нэвтрүүлэг, 0.5 хувь нь мэдэгдэл байсан байна.

Тэдгээр нийтлэлийн төрлүүдээс агуулгын хувьд сонирхвол нэр дэвшигч нам хүчин, бие хүмүүсээс өөрсдийн талаар танилцуулах, мэдээлэх шинжтэй нь олонхи болж байгаа ч гүтгэх, гутаан доромжлох, нэр төрд нь халдах зорилгыг агуулсан тохиодлууд цөөнгүй тааралдсан юм.

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлийн нийтлэлийн агуулгад хийсэн шинжилгээний үр дүнг харвал дараах байдалтай байна.

### ТВ-ийн нэвтрүүлгээр орон нутгийн сонгуулийн үед цацагдсан мэдээллийн агуулга

Нийтлэлийн агуулга	Давтамж	Хувь
Нэр дэвшигч нам хүчнээс танилцуулах	1045	65.1
Нэр дэвшигч нам хүчнээс мэдээлэх	271	16.8
Өрсөлдөгчөө гүтгэх, нэр төрд нь халдах	13	0.8
Өрсөлдөгчөө гутаан доромжлох	43	2.6
Сонгогчдыг уриалах	201	12.5
Өрсөлдөгчөө шүүмжлэх	24	1.4
Хэлэлцүүлэг явуулах	8	0.4
Нийт	1605	100.0

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. Хүснэгт 9

### Санал хураах байрны нууцаар санал өгөх боломжын талаарх иргэдийн үнэлгээ

	УИХ-ын сонгууль		Орон нутгийн сонгууль	
	447	44,7	321	32,1
Хангалттай	447	44,7	321	32,1
Дунд зэрэг	181	18,1	167	16,7
Хангалтгүй	100	10,0	97	9,7
Мэдэхгүй	272	27,2	415	41,5
Нийт	1000	100,0	1000	100,0

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. Хүснэгт 10

Сонгогчдын санал өгөх нууцлал хангагдсан эсэх тухай асуултанд хариулсан байдлаас үзэхэд анхаарвал зохих үр дүн гарчээ. УИХ-ын сонгуулийн үед нууцаар санал өгөх боломж хангалттай бий болсон гэж сонгогчдын дөнгөж 44 хувь нь, харин орон нутгийн сонгуулийн үед энэ үзүүлэлт багасч 32 хувьтай болжээ.

Судалгаанд оролцсон 10 сонгогч тутмын нэг нь УИХ болон орон нутгийн сонгуулийн үед нууцаар өгөх боломж хангагдаагүй гэж үзсэн нь анхаарал татах хэмжээ мөн билээ.

Мөн түүнчлэн дунд нууцаар санал өгөх зарчмын тухай, түүнийг хэрхэн биелүүлсэн, хангасан талаар үнэлэх боломжгүй байх нь иргэдийг нэлээд хэсгийг хамарч байгаа нь бодож үзэх асуудлын нэг юм.

Энэ нь иргэд сонгуульд санал өгөх журам, сонгуулийг явуулахдаа төрөөс баримтлах зарчмуудын талаар ойлголт муутай, товчхондоо сонгогчын боловсролын нимгэн байгаагаас хамаарч байна. Санал хураах байрны нууцлалыг хангасан байдал нь орон нутгуудын хувьд янз бүрийн үнэлгээтэй

бөгөөд зарим нэг газар сондгойдуу байдал ажиглагдсаныг тэмдэглэх хэрэгтэй.

Хотын Баянзүрх дүүргийн хувьд сонгогчдын дөнгөж 8 хан хувь нь сонгуулын байр санал хураалтын нууцлалыг хангалттай хэмжээнд хангаж чадсан гэж үзсэн билээ. Харин тус дүүргийн сонгогчдын 20 хувь нь нууцлалыг тодорхой хэмжээгээр хангасан, 12 хувь нь нууцлалыг огт хангаж чадаагүй хэмээн үнэлж байлаа.

Бусад дүүргүүдийн хувьд сонгогчдын 30-50 орчим хувь нь санал хураалтын нууцлалыг хангалттай бүрдүүлсэн гэж үзэж байгаа бол 8-10 хувь нь нууцаар санал өгөх боломж бүрдээгүй гэсэн байна. Бүх дүүргүүдийн хувьд нийтлэг ажиглагдсан нэг зүйл бол санал хураалтын нууцлалыг бүрдүүлсэн талаар иргэдийн нэлээд хэсэг нь үнэлгээ өгч мэдэхгүй байгаад оршино. Энэ нь нууцаар санал өгөх зарчим, түүнийг хэрхэн ойлгох, хэрхэн бүрдүүлж ажиллах талаар иргэдийн мэдлэг хандлага төдийлөн төлөвшөөгүй байгаагаас хамаарч байж болох юм.

### Санал хураах байрны нууцаар санал өгөх боломжын талаарх иргэдийн үнэлгээ

/боловсролын бүлгээр/

		Хангалттай	Дунд зэрэг	Хангалтгүй	Мэдэхгүй	Нийт
Дээд	УИХ	39.5	18.9	13.6	28.0	100.0
	Орон нутаг	26.0	19.5	11.6	42.9	
Тусгай дунд	УИХ	48.3	15.6	12.2	23.8	100.0
	Орон нутаг	30.6	14.3	10.2	44.9	
Бүрэн дунд	УИХ	44.0	18.8	6.6	30.5	100.0
	Орон нутаг	35.7	15.2	8.3	40.7	100.0
Б.бус дунд	УИХ	48.9	17.0	8.0	26.1	100.0
	Орон нутаг	37.5	18.2	6.8	37.5	
Бага ба боловсролгүй	УИХ	72.1	15.0	7.5	10.6	100.0
	Орон нутаг	44.6	11.6	11.2	32.5	100.0

"Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал" судалгаа НСХ 2004 он. Хүснэгт 11

Санал хураалтын нууцаар өгөх зарчмыг хангах үйл ажиллагаа нэн учир дутагдалтай байсан талаар дээд боловсролтой сонгогчдын зүгээс тодорхой үнэлэлт өгчээ. Энэ байдал нь орон нутгийн сонгуулийн үеэр бүр ч илүү харагдаж байна. Харин тэдний 19 орчим хувь нь нууцлалыг тодорхой хэмжээгээр хангаж ажилласан, 13.6 хувь нь хангалтгүй гэжээ.

Харин сонгогчдын боловсрол өсөх тусам хэсгийн хорооны байрны нууцаар санал өгөх боломжын талаарх эерэг үнэлгээ өсч байна.

Сонгогчид саналаа нууцаар өгөх сонгуулийн зарчим хэсгийн хорооны байранд төдийгүй зөөврийн хайрцагар санал авах үед алдагдах нь байдаг талаар ажиглалт судалгааны үр дүн өгүүлж байна.

- Ажиглагч нэгийг л дугуйл гээд ойрхон байсан /Ажиглалт.Төв/
- Хэн нь ч сонгогдсон хамаагүй, гээд хажуу хүнээсээ асуух, хэлэх /Ховд/
- Зөөврийн хайрцагны санал хураалтаар нууцлал хангагдаагүй /Дархан-Уул/
- Таны сонголт мэргэн байг гээд хэсгийн хорооны гишүүн хараад байсан /Орхон/
- Санал өгөх кабины нүүр хэсэг байгаагүй, сайн харвал хэнийг дугуйлж

байгаа нь харагдахуйц байсан /Өмнөговь/

- Нэг гэр бүлийн хүмүүс кабинд хамт орж санал өгсөн тохиолдол байсан /Баянзүрх/
- Саналыг нууц байдалд явуулах орчин нөхцөл тодорхой хэмжээгээр алдагдсан байна. Бүхээгт битүүмжлэгдсэн байдал хангалтгүй. Г хэлбэрийн намхан хаалт тавьсан. Ямар хүний нэр дугуйлж байгааг харах бололцоотой байсан /Увс аймаг/

ХЭҮК –ийн Итгэмжлэгдсэн Төлөөлөгчдийн авсан чанарын судалгаа. 2004 он

Гэрт амьдардаг олонхи хүмүүсийн хувьд зөөврийн хайрцагар санал авах үеэр саналаа нууцаар гаргах боломж тун хязгаартай байгаа юм.

*Дөрөв юм уу таван ханатай гэрт сонгуулийн хэсгийн хорооны ажилтангууд болоод ажиглагч нарын 4-5 хүн ба гэрийн хүмүүс нийлээд бараг л өвдөг өвдөгөө түшиж суухад хүрч байв. Ийм үед ямар нэгэн нууцлалын асуудал байх аргагүй тул зөөхөд тохирсон жижиг кабин мэт зүйл байх нь зохистой санагдаж байлаа.. Өмнөговь Ажиглалт*

"Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал" чанарын судалгаа. НСХ 2004 он

Судалгааны дүнгээс харахад сонгогчдын саналаа өгөх нууцлалд сонгуулийн хэсгийн хорооны ажилтан, ажиглагч нарын зүгээс халдах тохиолдлууд байхад бас сонгогчдын өөрийн зүгээс шалтгаалах нь байгаа юм. Дээр дурдсан хүмүүсээс өөрсдийн ажил үүргээ гүйцэтгэх явцдаа хууль зөрчиж, сонгох эрхэнд халдах явдал нэлээд бий болжээ.

Сонгогчдын өөрсдийн зүгээс сонгуульд идэвхигүй, хайхрамжгүй хандах, улмаар бусдын зааварчилгаа, нөлөөнд автах, өөрийн саналын нууцлалаа алдах зэрэг үзэгдэл байгааг энд тэмдэглэх хэрэгтэй.

### **Сонгуулийн үеэр гарах өргөдөл, гомдлыг шийдвэрлэх**

Сонгох эрхийн хэрэгжилтийн байдлыг судлах явцад анхаарал татсан нэг асуудал бол сонгуулийн үеэр гарсан зөрчилтэй холбоотой иргэдээс тавьсан өргөдөл гомдлыг шийдвэрлэх явдал юм.

Ажиглалт судалгааны дүнгээс үзэхэд сонгуулийн өмнөх шатанд нэр дэвшигчдийн сурталчилгаатай, нэр дэвшигчдээс явуулж буй олон нийттэй харьцах ажиллагаатай, санал хураалтын явцад сонгогчдын нэрсийн жагсаалт, бичиг баримтын бүрдэлтэй, сонгогчдод нөлөөлөх оролдлоготой санал хураалтын дараах үе шатанд тооллоготой тус тус холбоотой маргаан, санал гомдол ихэвчлэн гардаг байна.

Санал асуулгын үр дүнгээс сонгогчдын санал гомдол, өргөдлийг шийдвэрлэх нь сонгуулийн хэсгийн хорооноос явуулах бусад үйл ажиллагаатай харьцуулах аваас хэрэгжилт харьцангуй бага гэж үнэлэгдсэн юм.

Өөрөөр хэлбэл сонгогчдын 15 хувь нь сонгуулийн бүх шатанд дээрх үйл ажиллагааг хангалтгүй гүйцэтгэсэн гэж үзсэн нь дээр дурдсан тохиолдлуудаас харьцангуй олон сонгогч болж байна.

Доорх хүснэгтнээс сонгуулийн үеэр гарах зөрчил, маргааныг хэрхэн шийдвэрлэсэн тухай иргэдийн үнэлгээг нарийвчлан харж болно.

**Сонгуулийн үеэр гарсан өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн талаарх иргэдийн үнэлгээ**

	УИХ-ын сонгууль		Орон нутгийн сонгууль	
	Хангалттай	Дунд зэрэг	Хангалтгүй	Мэдэхгүй
Хангалттай	290	29,0	190	19,0
Дунд зэрэг	181	18,1	132	13,2
Хангалтгүй	156	15,6	150	15,0
Мэдэхгүй	373	37,3	528	52,8
Нийт	1000	100,0	1000	100,0

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. Хүснэгт 12

Сонгуулийн хэсгийн хорооноос дээрх үйл ажиллагааг хэрхэн гүйцэтгэсэн тухай сонгогчдын нэлээд хэсэг нь үнэлж цэгнэх боломжгүй байна. Тухайлбал, УИХ-ын сонгуулийн үеэр гарсан өргөдөл гомдол шийдвэрлэсэн талаар сонгогчдын 37 хувь нь, орон нутгийн сонгуулийн хувьд тэдний 50 гаруй хувь нь тус тус үнэлж мэдэхгүй гэжээ.

Энэ нь хэд хэдэн учир шалтгаанаар тайлбарлагдаж болно. Юуны өмнө сонгуулийн үедэх санал гомдол нь цөөн сонгогчдын хүрээнд бий болдог хийгээд тэрээр хэрхэн шийдвэрлэгдсэн тухайд олон нийтийн хүрээнд тэр бүр түгэж чаддаггүйтэй холбоотой.

**Сонгуулийн үеэр гарсан өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн талаарх иргэдийн үнэлгээ**

/боловсролын түвшингээр/

		Хангалттай	Дунд зэрэг	Хангалтгүй	Мэдэхгүй	Нийт
		Дээд	УИХ	27.7	18.1	17.5
	Орон нутаг	15.0	14.4	16.1	54.5	100.0
Тусгай дунд	УИХ	30.6	18.4	13.6	37.4	100.0
	Орон нутаг	17.7	14.3	11.6	56.5	100.0
Бүрэн дунд	УИХ	25.2	19.4	14.1	41.3	100.0
	Орон нутаг	20.5	11.9	14.7	52.9	100.0
Б.бус дунд	УИХ	36.4	14.8	18.2	30.7	100.0
	Орон нутаг	25.0	12.5	17.0	45.5	100.0
Бага ба боловсролгүй	УИХ	48.5	15.3	14.2	22.4	100.0
	Орон нутаг	30.3	12.7	15.6	41.6	100.0

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. Хүснэгт 13

Сонгуулийн үеэр гарсан өргөдөл гомдлын тухайд ажиглалт, болон бичиг баримтын судалгааны үр дүнд тулгуурлан авч үзвэл ийм байлаа.

- Нэрсийн жагсаалтанд сонгогчын нэрсийг орхигдуулсан /Баян-Өлгий, Дархан-Уул, Баянзүрх/
- Нэрсийн жагсаалтанд бүртгэхдээ сонгогчын иргэний үнэмлэх, регистрийн дугаарыг бичилгүй орхисон /Хөвсгөл, Дундговь, Ховд/
- Сонгуулийн хэсгийн хороог нэг талыг баримтлан бүрдүүлсэн /Баянзүрх дүүрэг/
- Нэр дэвшигчдээс бэлэг сэлт тараасан /Өмнөговь/
- Нам хүчнээс газар өмчлөлийн гэрчилгээ тараасан //
- Сонгогчдыг хувийн унаагаар зөөсөн /Дархан-Уул, /

ХЭҮК –ийн Итгэмжлэгдсэн Төлөөлөгчдийн авсан чанарын судалгаа. 2004 он

Хоёрдугаар бүлгийн эцэст дараах товч дүгнэлтийг хийж болно. Үүнд:

- Олон нийтийн дунд сонгууль тэр бүрчлэн хууль ёсны дагуу, шударгаар явагдаж өнгөрдөг гэсэн итгэл үнэмшил бага байна. Иргэдийн 30 гаруй хувь нь ерөнхийдөө сонгууль ямар нэг зөрчил будлиантай явагддаг гэсэн хүлээлттэй байхад, арван сонгогч тутмын нэг нь хууль ёсоор явагдаж огт чаддаггүй гэсэн бодлыг тээж явдаг байна.
- Иргэд сонгуулийн хуулийн хэрэгжилтийн талаар харьцангуй гутранги үзэл хандлагатай аж. Судалгаанд оролцсон иргэдийн 20 хувь нь тус хууль амьдралд мөрдөгдөж, биелэлээ олж чаддаггүй гэж үздэг нь анхаарвал зохих асуудал мөн.
- Сонгуульд нам эвсэл, нэр дэвшигчын зүгээс янз бүрийн биелэгдэшгүй амлалт өгөх, энэхүү хоосон амлалтуудаараа өөр хоорондоо өрсөлдөх, уралдах хандлага сүүлийн үед нэлээд газар авсан нь хүний сонгох, сонгогдох эрх зөрчигдөх үндсэн шалтгааны нэг хэмээн иргэд үздэг аж.
- Нэр дэвшигчдээс сонгогчдын саналыг худалдан авах, ингэхийн тулд мөнгө эд зүйл тараах, үүнийгээ сонгуулийн компанит ажлынхаа салшгүй нэг хэсэг болгож буй нь хүний сонгох, сонгогдох эрхийн нэгэн нийтлэг зөрчил мөн
- Сонгуулийн компанит ажлын үеэр нэр дэвшигчдийн зүгээс өрсөлдөгч рүүгээ дайрч довтлон гүтгэхийг гол баримжааллаа болгохын хамт өөрийн тухай худал магтсан хуурмаг мэдээлэл тархаах нь жирийн зүйл болсон нь иргэний сонгох, сонгогдох эрхэд ноцтой харшилж байна.
- Иргэдэд сонгуульд оролцох, саналаа өгөхийн ач холбогдол, тэдний иргэний үүрэг хариуцлагыг ухуулан таниулах ажил хангалтгүйгээс худал амлалтанд хууртах, саналаа худалдах, сонгуульд оролцохгүй байх зэрэг сөрөг хандлага даамжирч байна.
- Иргэд хаяг тодорхойгүй, баримт бичгийн зөрчилтэйгээс үүдэн сонгох эрхээ эдэлж чадахгүй байх тохиолдол урьдын адил элбэг байна.
- Янз бүрийн шатны эрх мэдэлтэнгүүд сонгогчдод нөлөөлөх, тодорхой шахалт үзүүлэх оролдлого гаргадаг нь судалгааны явцад ажиглагдсан бөгөөд энэ нь хүний сонгох, сонгогдох эрхийн зөрчилтэй холбоотой анхаарал татсан асуудлын нэг мөн.
- Сонгуулийн явцад ялангуяа зөөврийн хайрцгаар санал авах үед нууцаар саналаа гаргах зарчим алдагдах нь нийтлэг шинжтэй байна.

## Гуравдугаар бүлэг: Сонгуулийн сурталчилгааны явцад түгээмэл тохиолддог сонгох сонгогдох эрхийн зөрчлийг авч үзэх нь

Энэ бүлэгт хөндөгдөж буй асуудал маань өмнөх бүлгүүдэд ямар нэг хэмжээгэр тусгагдсан нь бий авч бид сонгуулийн үеэрх иргэдийн сонгох, сонгогдох эрхийн нийтлэг зөрчлүүдийг илүү судлан шинжлэхийг эрмэлзсэн юм.

Ингэхдээ эдгээр зөрчлүүдийг бүлэглэн, тэдгээрийн шалтгаан, илрэн гарч буй хэлбэр, сөрөг үр дагаврыг нь шинжиллээ.

### Нэр дэвшигчид нэг нэгнээ гүтгэн доромжлох нь


Улс төрийн олон ургальч үзэл, ардчилал нь сонгогчийг олон нэр дэвшигчээс өөрийн ашиг сонирхлыг хамгаалж чадах хүнээ сонгох боломжийг олгодог ороо онцлог.

Хэнийг сонгох гэдгээ бид голлон сонгуулийн сурталчилгааны үед шийддэг агаад шударга, үнэн зөв, бодитой мэдээлэл нь зөв сонголт хийх нөхцлийг бүрдүүлдэгээрээ хүний сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтэнд шууд нөлөөлдөг билээ.

Харин манай сонгуулиудын үеэр нэр дэвшигчид өрсөлдөхдөө сонгуулийн хууль бус үйл ажиллагаа, бие биенээ үндэслэлгүйгээр гүтгэх, доромжлох нь ердийн үзэгдэл болон хувирч байгаа нь харамсалтай төдийгүй хүний эрхэд шууд халдсан үйлдэл болж байгаа юм.

Сонгуулийн сурталчилгааны үед өрсөлдөгчид нэг нэгнээ гүтгэн доромжлох явдал их хэмжээгээр гардаг болсныг судалгааны дүн харуулж байна.

### Сонгуулийн сурталчилгааны үед нэг нэгнээ гүтгэн доромжлох байдал



“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. График 1

Графикаас харахад нэг нэгнээ гүтгэн доромжилдог үйлдэл буюу нэр дэвшигчдийн сонгогдох эрхийн зөрчлүүд УИХ-ын сонгуулийн үед ихээхэн гардаг (44.5%) аж.

Харин орон нутгийн сонгуулийн хувьд энэ байдал нэлээд бага хувьтай (18.7%) байгааг харж болно. Нийгэмд нэг нэгнээ гүтгэх, доромжлох улс төрийн уур амьсгал бий болсноор сонгогчдыг улс төрийн сонголт хийхэд нь саад болох, улмаар сонгуулийн оролцоог багасгах нэгэн хүчин зүйл болж байгааг үгүйсгэх аргагүй.

Улс төрийн хүрээнд шударга бусаар тэмцэлдсэн, харилцан бие биенээ үгүйсгэх хийгээд гүтгэн доромжилсон үйлдлүүд нь /хар PR ч гэж ярьдаг/ иргэдийн дунд улс төрд үл итгэх байдал, засаглалын нэр хүндийг унагаах, зөв сонголт хийх боломжгүй болгох зэрэг сөрөг үр дагаврыг дагуулж байна.

Энэ нь ч сонгогч иргэдийн улс төрийн оролцоог сүүлийн жилүүдэд ихээхэн бууруулжээ.

...Сонгуулийн үеэр гүтгэлэг ихээхэн явагдсан. Ялангуяа нэр дэвшигчийг гүтгэж мөрийн хөтөлбөрийг биелэгдэшгүй мэтээр ярьж хар PR явуулж байсан. Иймээс ч хүмүүсийн улс төрд итгэх итгэл буурсан гэж боддог.

*Дархан-Уул. Кейс ярилцлага*

"Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал" чанарын судалгаа. НСХ 2004 он

Сонгуулийн хууль заалтыг зөрчин нэр дэвшигчдийг гүтгэх явдал ихээхэн газар авсныг дараах баримтаас харж болно.

...Улс төрийн намаас зохион байгуулалттайгаар өрсөлдөгчөө гүтгэн гүжирдэх явдал гарч байв. Тухайлбал Эх орон ардчилал эвслээс сонгогч нарт илгээсэн ил захидлын хавсралтанд ...МАХН аас нэр дэвшигчид улсын болон ард түмний хөрөнгөөр баяжсан 100 мянга гаруй хүмүүсийг ажилгүй болгосон хувь хөрөнгөгүй үлдээсэн сонгогчдыг хоосон үгээр хордуулсан жишээ нь 15 нэр бүхий дэвшигчдийг эрхэлж буй ажил төрөлтэй нь хувийн компанийн үйл ажиллагаатай холбогдуулан нэр хүндийг нь гутааж сонгуулийн хууль заалтыг зөрчсөн.

... мөн МАХН-ын зүгээс ч тухайн тойргуудад нэр дэвшигч тус бүрээр гүтгэлгийн материалуудыг багш сурагчдыг дайчлан айл өрхүүдээр тарааж байсан байна.

*Баян өлгий аймаг, Итгэмжлэгдсэн төлөөлөгч*

ХЭҮК –ийн Итгэмжлэгдсэн Төлөөлөгчдийн авсан чанарын судалгаа. 2004 он

Дээрх сонгогдох эрхийн зөрчил нь сонгогчдод ил захидал хэлбэрээр илгээсэн нь ихээхэн ноцтой үйлдэл, бөгөөд баримтжуулсаны үндсэнд хуулийн хариуцлага хүлээлгэж болохоор байгаа юм. Үүнээс гадна сонгуулийн аман хэлбэрийн сурталчилгааны үед нэр дэвшигчид харилцан нэг нэгнээ гүтгэх явдал ихээхэн гардаг ч үүнийг шийдвэрлэсэн тохиолдол таарч байгаагүй нь хачирхалтай юм.

...Би хөдөө амьдардаг хоёр намын сурталчилгаа адилхан л бие биеэ муулсан явж байсан. /Ер нь сонгуулийн сурталчилгаа хийж байгаа хүмүүсийг тодорхой шалгуурт тэнцсэн хүмүүсээр хийлгэж баймаар байна!!! Ядаж л өөрийн нэр дэвшигчээ үнэн зөв, зөв зүйтэй танилцуулчихдаг бусад намаа муулаж хэл амаа билүүддэггүй тийм л хүмүүс баймаар байна. Одоо бол гэр оронд шууд орж ирээд л за манай намд санал өгнө шүү гээд элдэв юм ярьж ухуулга хийдэг.

*Өмнөговь. Фокус ярилцлага*

"Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал" чанарын судалгаа. НСХ 2004 он

Улс төрийн намуудын хувьд харилцан бие биенээ гүтгэх, доромжлох явдал хааяагүй гарсаар байгааг дээрх баримтууд нотолж байгаа боловч нэр дэвшигчийн эрхийг зөрчсөн, үндэслэлгүйгээр гүтгэн доромжилсон үйлдлүүдэд хариуцлага хүлээлгэдэггүйн улмаас энэ зөрчил цаашид улам даамжрах төлөвтэй байна.

Улс төрийн хэд хэдэн сонгуульд ажиглагчаар орсон, асуудлыг сайн мэдэх хүмүүсийн хувьд нэр дэвшигчийг элдэв гүтгэлгээр гүтгэх сонгуулийн бохир технологийн цаад учрыг ухаж ойлгодог бол, харин жирийн иргэдийн хувьд нэр дэвшигчийн талаар таагүй төсөөлөлтэй болгох, улмаар сонголтод нь нөлөөлөх явдал ч байсаар байна.




**Сонгогчдын саналыг авахын тулд хуурамч амлалт өгөх нь.**

*Амлалт нь улс төрийн зорилготойгоор засгийн эрхийг ямар нэг аргаар авахыг тэмүүлж байгаагийн нэг илрэл юм. Өмнөговь. Фокус ярилцлага.*

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” чанарын судалгаа. НСХ 2004 он

Өнөөдөр ард иргэдийн хувьд үнэн мэдээлэл олж авах, түүн дээрээ тулгуурлан улс төрийн сонгуульд нэр дэвшигчдэд үнэлгээ өгч, өөрийн үзэл бодлын үүднээс сонголт хийх эрх нь ямар түвшинд байгааг дараах асуултад хэрхэн хариулсан байдлаас үзэж болно.

Иргэдийн санал бодлоор сонгогчдын саналыг худалдан авахын тулд худал ойлголт амлалт өгөх нь УИХ-ын сонгуулийн үеэр нэлээд их гардаг(34.3%) гэж иргэдийн нэлээдгүй хувь нь дүгнэжээ. Харин орон нутгийн сонгуулийн хувьд иргэдийн саналыг худалдан авахын тулд худал ойлголт амлалт өгөх явдал УИХ-ын сонгуультай харьцуулахад харьцангуй бага гардаг боловч бага биш хэмжээгээр(18.9%) байсаар байгааг судалгааны дүн баталж байна.

**Сонгогчдын саналыг авахын тулд худал ойлголт амлалт өгөх.**

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. График 2

Харьцуулсан графикаас харахад иргэдийн саналыг авахын тулд УИХ -ын сонгуулийн үед худал ойлголт амлалт өгөх явдал ихээхэн гардаг бол, орон нутгийн сонгуулийн үед төдийлөн гардаггүй гэж үзэгсэд ихээхэн хувийг эзэлж байна.

Монгол улсын Сонгуулийн ерөнхий хороонд 2004 онд ирсэн УИХ-ын сонгуулийн зөрчил гомдлын талаарх 600 орчим баримт, материалд хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд сонгуулийн өмнөх, ухуулга, сурталчилгааны үеийн зөрчил буюу хуулийн 21-р зүйл нилээд их (**23** бүртгэгдсэн) байгаа нь анхаарал татсан асуудал юм.

Иргэдийн зүгээс улс төрийн сонгуульд нэр дэвшигчдийн худал амлалтанд таатай бус ханддаг.

*...Эцсийн эцэст худлаа амлалт өгнө гэдэг нь өөрсдийнхөө нэр төрийг асар их унагаж байна гэсэн үг юм . Чадахгүй зүйлээ амлана гэдэг нь их шившигтэй зүйл. Амласан бол биелүүлэх хэрэгтэй.*

*Дархан Уул. Фокус ярилцлага.*

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” чанарын судалгаа. НСХ 2004 он

Улс төрийн сонгуульд нэр дэвшигчид бодитой амлаж, цаашид амлалтаа хэрэгжүүлэх нь улс төрийн соёл төлөвших нэгэн чухал хүчин зүйл болно.

Орон нутгийн сонгуулийн үеэр хүний эрхийн орон нутгийн төлөөлөгчид иргэдийн саналыг худалдан авахын тулд худал ойлголт амлалт өгөх явдал хааяагүй гарч байсныг тэмдэглэсэн байна.

*...Хорооллын автозамыг сайжруулах засах зардлыг жил бүрийн төсөв төлөвлөгөөнд тусган шийдвэрлүүлэх талаар мөрийн хөтөлбөртөө тусгана гэсэн зарим амлалтууд нь НИТХ-ын төлөөлөгчийн бүрэн эрх чиг үүрэгт төдийлөн шууд хамаарахгүй харин төрийн үйлчилгээ аж ахуйн чиглэлийн байгууллагуудын хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө гэх мэт зүйлийг хөндөж байна. Бичиг баримтын судалгаа. Улаанбаатар хот БЗД.*

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” чанарын судалгаа. НСХ 2004 он

Хэдийгээр сонгуулийн амлалтад иргэд төдийлөн хууртахаа больсон авч амьжиргааны түвшин дорой, өрхийн гишүүд нь ажил хөдөлмөргүй ба боловсролгүй учраас мэдээлэл тааруу өрх, айлууд худал ойлголт, амлалтад хууртан саналаа өгдөг нь цөөнгүй байна.

*Сонгуулийн сурталчилгааны явцад нэр дэвшигчид ятгах ухуулах гүтгэх ажил төрөл бүтээж өгнө гэж амлах буцалтгүй тусламж олгох зэрэг арга хэлбэрүүдийг ашиглаж байна. Тойрогт нь амьжиргааны түвшин тааруу өрхүүд тохиолдож байгаа бол хүнсний зүйл мөнгө тараах гэр хорооллын айлуудын өрхийн хогийг ачих оюутан хүүхдийнх нь сургалтын төлбөрийг хөнгөлөх ажилгүй залуучуудыг мэргэжил курс дамжаанд хөнгөлөлттэй сургах зэрэг зүйлийг хийж байв. Ажиглалтын судалгаа, Орхон ХЭК ийн төлөөлөгч.*

*Аймгийн засаг даргаас эхлээд бүх шатны төрийн албан хаагчид бөөнөөр албаны унаа машин бензин шатахууныг ашиглан сонгуулийн сурталчилгаанд оролцож байсан төдийгүй албан тушаалаа ашиглан элдэв амлалт авах мөн зарим хүмүүст албан тушаал амлаж өөртөө татахыг оролдож байсан. Ажиглалтын судалгаа, Говь Алтай. ХЭК ийн төлөөлөгч*

*Тус аймагт иргэдэд худал мэдээлэл өгөх явдал гарч байсан. Тухайлбал Хөдөөгийн ядуурлыг бууруулж өсөлтийг дэмжих зээлийг нэр дэвшигч өгч байгаа мэтээр харуулах ярих явдал гарч байлаа.  
Булган аймаг*

*МАХН-аас нэр дэвшигч Д.Дамдинбазар/Дорнод аймгийн газрын албаны дарга/ Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай шийдвэр гэсэн тамга тэмдэг гарын үсэг бүхий хэн ч харсан итгэл төрөхөөр албан бичгийг хүмүүст тараасан байна.  
Дорнод аймаг*

*ИТХ-д МАХН-аас нэр дэвшсэн С.Үржин Дэлхийн зөнгөөс барьсан худгийг өөрөө хийсэн мэтээр иргэдэд ойлгуулж байсан.  
Дундговь аймаг*

ХЭҮК –ийн Итгэмжлэгдсэн Төлөөлөгчдийн авсан чанарын судалгаа. 2004 он

Нэр дэвшигч сонгуульд ялахын тулд иргэдэд худал, ойлголт амлалт өгөх нь нэг талаар иргэдийн чөлөөтэй сонголт хийх эрх ашгийг хөндөж, нөгөө талаас хүний сонгогдох эрхэд халдаж буй явдал юм.

### **Сонгогчдын саналыг худалдан авахыг оролдох нь.**

*Нэр дэвшсэн хүмүүс ихэнх нь бизнесмен хүмүүс байдаг. Тэд дандаа мөнгө төгрөгөөр цохиж ядарсан ард түмний саналыг худалдаж авч байна.  
Дархан Уул аймгийн фокус бүлгийн хэлэлцүүлгээс*

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” чанарын судалгаа. НСХ 2004 он

Сонгогчдын саналыг худалдан авахыг оролдох байдлыг иргэдийн зүгээс хэрхэн хариулсныг хүснэгт хэлбэрээр дараах байдлаар үзүүлж болох юм.

	УИХ		Орон нутгийн сонгууль	
Нэлээд их гардаг	315	31.5	149	14.9
Ер нь гардаг	278	27.8	227	22.7
Хааяа нэг гардаг	149	14.9	203	20.3
Гардаггүй	255	25.5	411	41.1
Хариулаагүй	3	0.3	10	1

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. Хүснэгт 1

Хүснэгтээс харахад иргэдийн саналыг худалдан авахыг оролдох нь ихээхэн түгээмэл байдаг гэж 3 сонгогч тутмын нэг нь өгүүлжээ. Бодит амьдрал дээр иргэдийн саналыг худалдан авах явдал өөрт нь буюу сайн мэдэх хүнээр, эсвэл танил талаар нь дамжуулан мөнгө төгрөг өгөх, бэлэг сэлт, ойр зуурын хэрэгсэл дурсгах, хүнс хувцас тараах, тусламжийн бараагаар саналыг барьцаалах явдал түгээмэл болжээ.

Орон нутгийн сонгуулийн хуулийн **6.23.6-д** “*нэр дэвшигч, түүний шадар туслагч, ухуулагч, нам эвсэл, талархан дэмжигч этгээд санал худалдаж авах, сонгогчдыг татах зорилгоор тэдэнд төлбөртэй болон үнэ төлбөргүйгээр бараа тараах, шагнал урамшуулал, тусламж олгох, дайллага хийх, урлаг спорт, ахуйн болон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, сонгуульд үл хамаарах ажил үйлчилгээ явуулахыг хориглоно*” гэж заасан байдаг ч Хүний эрхийн ажиглагчдын тайлан, материалд хийсэн баримт бичгийн шинжилгээнээс үзэхэд нийт зөрчлийн 16 хувь нь дээрх заалтыг биелүүлээгүйн улмаас гарчээ.

Нөгөө талаар иргэдийн амьжиргааны түвшин дорой, буурай байгаа өнөөгийн нөхцөлд хүн амьдралын хэрэгцээ шаардлага, хувийн гачигдлаас шалтгаалан хуулиар олгогдсон наад захын иргэний болон улс төрийн эрхээ эдэлж чадахгүйд хүрч байгаа нь амьдралд олонтаа таарч байна.

Гэтэл үүнийг зохицуулах ёстой сонгуулийн хууль тогтоомжид хүний сонгох эрхийг зөрчсөн (худалдан авах гэх мэтээр) тохиолдолд ямар шийтгэл хүлээлгэх нь тодорхойгүй, зарим заалтууд нь бүрхэг буюу хэт хөнгөн байгаа юм.

Тухайлбал: Сонгуулийн эрхийг хангах хууль зүйн баталгааны талаар өгүүлсэн сонгуулийн хуулийн 6-р зүйлийн 2-рт “сонгуулийн хууль тогтоомжийг зөрчсөн нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй бол гэм буруутай этгээдэд эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэсэн нь тун бүрхэг заалт юм.

Мөн зүйлийн 5-д “энэ хуулийн 30-дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг зөрчсөнд/сонгогчдыг татах зорилгоор төлбөртэй болон төлбөргүй бараа тараах/ эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал гэмт буруутай этгээдэд 40-50 мянган төгрөгийн торгууль шүүх ногдуулна.” гэсэн нь улс төрийн сонгуульд зөвхөн нэр дэвшихийн тулд 10 сая төгрөг өгч байгаатай харьцуулахад харьцангуй хөнгөн шийтгэл болно.

УИХ ба орон нутгийн сонгуулийн үеэр нэр дэвшигчдийн зүгээс санаатайгаар явуулсан хууль бус үйл ажиллагаа хувь хүн, тэдгээрийн гэр бүлд хэр зэрэг тохиолдож байсан талаар иргэдийн үнэлгээг сонирхвол дараах дүр зураг харагдана.

Сонгуулийн сурталчилгааны үед таны саналыг худалдан авахын тулд нэр дэвшигчдийн зүгээс явуулсан үйл ажиллагаа Танд болон танай гэр бүлд тохиолдож байсан уу гэсэн асуултад иргэдийн зүгээс дараах хариултыг өгчээ.

	Надад тохиолдсон		Манай бүлд тохиолдсон		Үгүй		Нийт
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	
<b>Бэлэн мөнгө өгөх</b>	68	6.8%	69	6.9%	863	86.3%	1000
<b>Бэлэг сэлт гардуулах</b>	72	7.2%	130	13.0%	798	79.8%	1000
<b>Албан тушаал амлах</b>	36	3.6%	52	5.2%	912	91.2%	1000
<b>Найр наадам цайллагад урих</b>	90	9.0%	73	7.3%	837	83.7%	1000

"Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал" судалгаа НСХ 2004 он. Хүснэгт 2

Судалгааны дүнгээс харахад нэр дэвшигчийн зүгээс сонгогчдын саналд нөлөөлөх буюу худалдан авах зорилгоор хувь хүнийг найр наадам, дайллага, цайллагад урих нь ихээхэн түгээмэл байгаа ба бэлэг сэлт гардуулах (7.2%), бэлэн мөнгө өгөх (6.8%), албан тушаал амлах (3.6%) зэрэг хууль бус үйлдлүүд ч гарсаар байгаа юм. Эдгээр нь сонгуулийн санал худалдаж авах төрөл хэлбэрүүд болно.

Гэр бүлийн хүрээнд бэлэг сэлт гардуулах явдал ихээхэн тохиолддог (13.0%) бөгөөд найр наадам цайллагад урих (7.3%), бэлэн мөнгө өгөх (6.8%), албан тушаал амлах (5.2%) зэрэг нь харьцангуй бага хувьтай боловч иргэдийн амьдралд тохиолдсоор байгаа сөрөг үзэгдлүүд юм.

Гэсэн хэдий иргэдэд өгч байгаа бэлэг сэлт нь тэдгээрийн амьдралыг өөрчлөхүйц хөрөнгө оруулалт болж чаддаггүйг судалгааны явцад олон иргэд өгүүлж байсныг дурдахгүй өнгөрөх аргагүй.

*...Улаанбаатараас хүмүүс ирээд миний төлөө саналаа өгөөрэй гээд өнөө маргаашийг аргацаасан гарын бэлгийг өгдөг. Миний төлөө саналаа өгвөл ажлын байраар хангана, одоо тулгамдаж байгаа асуудлуудыг шийднэ гээд амлаж байдаг ч энэ хэзээ ч бүтэхгүй юм шиг санагддаг. Өнгөрсөн 2000 оны сонгуулиар ингэж л байсан энэ жилийн сонгуулиар ч бас мөн тэгэж л байсан. Өмнөговь. Фокус ярилцлага.*

"Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал" чанарын судалгаа. НСХ 2004 он

2004 оны УИХ-ын сонгуулиар дээрх зөрчлүүд ихээхэн түгээмэл байсан бөгөөд хууль тогтоомжид үүнийг шийдвэрлэх зүйл заалт байсаар атал нэг ч аймаг хотод хуулийн дээрх заалтыг биелүүлээгүй бөгөөд Баян-өлгий аймагт хуулийн хариуцлага хүлээлгэсэн цорын ганц тохиолдол гарсан байна.

Ер нь УИХ ба орон нутгийн сонгууль нь явагдаж байгаа хугацаа, нэр дэвшигчийн үйлдэл, сонгогчийн нөхцөл байдал зэрэг хэд хэдэн зүйлээр онцлог ялгаатай.

УИХ-ын сонгуулийн үед нэр дэвшигч нь тэр бүр орон нутгийн ард иргэдэд танигдаагүй байдаг тул сонгогчдын саналыг худалдан авах явдал ихээхэн тохиолддог. Учир нь нэр дэвшигчийн зүгээс олон нийтэд өөрийгөө таниулах, сонгогдож байвал хууль дүрмээс гадуур бүх үйлдлийг хийж болно гэсэн итгэл үнэмшилтэйгээр өөрийн сонгуулийн кампанит ажлыг зохион байгуулдаг нь дээрх үйлдэлд хүргэдэг байна. Нөгөө талаар энэ нь сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө чинээ, бэл бэнчин, эрхэлж байгаа албан тушаалаас хамаарч ихээхэн гардаг ажээ.

...Сонгуулиар хүний эрх зөрчигдөх явдал өдий төдий гарсан цэнгэлдэх хүрээлэнд сонгуулийн урьд шөнө хүн зөөж авч ирээд санал өгүүлж байсан. Эх орон Ардчилсан ээслээс нэр дэвшигч Бат-эрдэнэ(Ажнай компанийн захирал) сонгуулийн өмнө цэргийн ангийн бүх цэргүүдэд тамхи, бугуйн цаг өгсөн. Баруун голд айл бүрд архи өгч байсан мөн тэнд гэр барьчихаад хүмүүст архи өгч байсан. Ер нь дуртай нь ороод л уудаг байсан. Орон нутгийн сонгуулийн хувьд үнэн шударга гарч ирсэн гэж ойлгож байна. Ер нь цаашид сонгуулийг үнэн зөв шударга байдлаар явуулмаар байна. Өөрөөр хэлбэл сонгогч ч бай сонгогдогч бай аль аль нь үүрэгээ ухамсарлаж хуулиа даган үнэн шударга сонгууль явуулмаар байна.  
Өмнөговь Фокус ярилцлага.

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” чанарын судалгаа. НСХ 2004 он

УИХ-ын сонгуультай харьцуулахад орон нутгийн сонгуулийн үеэр(орон нутгийн сонгууль нь иргэдийн сайн мэдэх, өөрсдийн төлөөлөлийг сонгож байгаа гэдэг утгаараа) сонгох сонгогдох эрхийн зөрчил харьцангуй бага гарах учиртай юм. Гэсэн хэдий ч цаг хугацаа, иргэдийн төлөөлөл байх утга зэргээс үл хамааран сонгох, сонгогдох эрх зөрчигдөх нь УИХ-ын олон тооны зөрчлөөс улбаалан өссөөр байна.

Иргэдийн саналыг худалдан авах гм хууль бус ухуулга сурталчилгааг хориглосон зүйл заалтыг зөрчсөн үйлдэл орон нутгийн сонгуулиар нийт 12 гарсан орон нутгийн сонгуулийн үеэр гарсан зөрчлийн 24 хувь болох юм.

Зөвхөн орон нутгийн сонгуулийн 14 хоногт л гэхэд сонгуулийн хуулийг зөрчсөн асар олон тооны зөрчлүүд гарсан бөгөөд, эдгээрээс сонгогчдын саналыг худалдан авахыг оролдсон баримтуудыг ХЭҮК-ын ажиглагчдын тайланд түшиглэн зарим аймаг, хотууд дээр жишээ болгон авч үзвэл,

...МАХН-аас нэр дэвшигч Ж.Жанцан Дарь эхийн гэр хорооллын айлуудад будаа гурил тарааж бүх гэр хорооллын худагт МАХН-аас үнэгүй ус өгч байгаа тухай мэдээлэл тарсан байсан. Үүнийг газар дээр нь очиж үзэхэд үнэгүй ус тарааж байгаа нь бодит байдал дээр үнэн байв. Улаанбаатар хот БЗД-ийн 4 -р хороо

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” чанарын судалгаа. НСХ 2004 он

...МАХН-аас 1-р хэсэгт нэр дэвшсэн Б.Нацагням сурталчилгаагаа ахмадын өдөр эхэлж хүн тус бүрт 5000 төгрөг хадагтай өгсөн бөгөөд сонгогчидтой уулзахдаа ихэвчлэн дулааны доголдол өр ширтэй айлуудын өрийг шийдвэрлэж өгөх амлалт авч, зарим айлуудыг хэрэгсэхгүй болгосон нь сонгуулийн хуулийн 23.6-г зөрчиж байна.  
Төв аймаг

...МАХН-аас нэр дэвшигчид өөрийн удирдаж буй байгууллагын ойг тохиолдуулан сонгогчдод бэлэг сэлт тараасан ба сонгуулийн дараа будаа гурил өгөх өргөдлүүдийг иргэдээс авсан. Тус аймгийн ИТХ-ын дарга С. Үржингийн төрсөн хүү болон түүний нөхөд нь үдшийн бүрийг далимдуулан машинаар сонгогчдыг зөөсөн.  
Дундговь аймаг

...Р.Риян цай байхуу алчуур тараасан Д.Мурат бэлэг сэлт тараасан тул сонгуулийн хуулийн 36.5-д зааснаар 40000 төгрөгөөр торгосон байна.

...Сонгогчдыг урьдаас нь тосон авч уулзах машинаар зөөвөрлөх явдал хаа сайгүй гарч байсан.

... харж байхад хүмүүс шахалтаар ирж санал өгч байгаа нь харагдаж байна. Нэр дэвшигч болгон машинаар зөөх боломжгүй тул зохион байгуулалттайгаар машинаар зөөвөрлөх нь сонгогчдыг сайн дураараа ирж саналаа өгөх санаачлагыг үгүй болгож санал хэрэгтэй бол өөрсдөөс ирж авна биз гэсэн нөхцөл байдалд оруулахын зэрэгцээ мөнгөтэй хүн сонгогдох боломжтой харин мөнгөгүй хүн ийм эрх боломжгүй болоход хүргэж байна.  
Баян-Өлгий

...Увсын Зүүнхангай суманд УИХ-ын гишүүн Ч.Авдай орон нутгийн сонгуулийн сурталчилгааны үеэр очиж өөрийнхөө алдрыг тэмдэглэн тус сумын албан байгууллага найз нөхөд хамаатан садангаа цуглуулан их хэмжээний цайллага дайллага хийж сонгуулийн сурталчилгаа давхар явуулсан.  
Увс аймаг

...Таксины жолооч бүрт 5000 төгрөг өгч цуваанд оруулан хотын төвийг нэг удаа тойрсон нь ийм рейс хийгээд 500-1000 төгрөг олдог жолооч нарыг татаж байна гэж үзэх үндэстэй  
Орхон аймаг

...Сонгогчдын саналыг шууд бусаар худалдан авах нэг оролдлого бол тухайн тойргийн иргэдийн дунд өндөр шагнальтай тааврын уралдаан зохиож байгаа явдал билээ. Түүнчлэн иргэдийг сонгуулийн кампанит ажлын хүрээнд 'Аминчхан яриа' нэртэй зоогт урьсан нь сонгуулийн хууль зөрчсөн үйлдэл болсон.  
Дорнод аймаг

...Сонгуулийн 2-р хэсэгт МАХН-аас нэр дэвшигчид өөрсдийн зардлаар газар өмчлөлийн гэрчилгээгээ авч амжаагүй байсан айлуудад 'газар өмчлөх гэрчилгээ'/1500 төгрөгийн үнэтэй/ тарааж өгсөн мөн бүх хашааг будаж шинээр хаягжуулсан нь багагүй хэл ам болж байсан ч олонх иргэд сэтгэлд нийцсэн ажил болсон гэж ярьж байжээ.  
АН-аас нэр дэвшигчид Зүүнсайдны 7-р гудамжинд сонгогчидтой уулзалт хийж байхдаа гурил будаа цай тараасан. Мөн эвслээс нэр дэвшигч мөнгө тараасан.  
Өмнөговь аймаг

"Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал" чанарын судалгаа. НСХ 2004 он

...5-р тойрогт МАХН-аас нэр дэвшигчээс орон нутгийн сонгуулийн хуулийн 23.6 дахь хэсгийг зөрчин сонгогчдод архи тамхи чихэр алим гурил будаа зэрэг барааг АН аас нэр дэвшигч тараасан тул гомдол гаргасан байна

18-р тойрогт нэр дэвшигч эмнэлгийн салбарын эрхлэгч Д.Оюундалай эмнэлгийн машин унаж явсан хойгуур яаралтай мэс засалд орох шаардлагатай өвчтөнг хамаатан садан нь аймгийн эмнэлэгт хүргэж өгсөн ба сонгуулийн байр руу санал өгөхөөр явж байгаа хүмүүсийг эмнэлгээр оруулан чихэр жимсээр дайлан саналаа өгөхийг уриалж байсан байна. Галуут сумын 21-р тойрогт нэр дэвшигч Ш.Чимгээ сургуулийн 44 сурагчийг тээвэрлэн санал өгүүлэхийг завдсан байна.  
Баянхонгор аймаг

*...Сонгогчдын саналыг өөртөө татах зорилгоор бэлэг сэлт тараах явдал ихээхэн гарсан байна. Цай хадаг хичээлийн хэрэгсэл гэх мэт.  
Хөвсгөл аймаг*

ХЭҮК –ийн Итгэмжлэгдсэн Төлөөлөгчдийн авсан чанарын судалгаа. 2004 он

зэрэг баримтуудыг өмнөх сонгуулиудын дүнгээс хэдэн зууг бичиж болно. Энд намын харъяалалыг онцолж ярихгүйгээр чухам ямар шалтгаанаар, хүмүүсийг хэрхэн сонгож бэлэг сэлт өгч байгааг нь сонирхоход ихэвчлэн анх удаа сонгуульд оролцож байгаа хүмүүст, тэдгээрийн саналыг худалдан авах зорилгоор өгдөг байна.

Иймээс ч зарим хүмүүс сонгуулийн үеэр нэр дэвшигчдийн тараасан бэлэг сэлтийг хууль зөрчсөн үйлдэл гэхээсээ илүүтэй, аль ч нам, улс төрийн хүчний хийж байдаг хэвийн зүйл гэж үзэхэд хүргэсэн байна.

*...Сонгох сонгогдох эрх гэдэг бол ерөөсөө өөрийн бодлоороо л саналаа өгөөсэй гэсэн үг. Сая орон нутгийн сонгууль зөв явж өнгөрлөө. Төрийн эрхэнд гарсан 10 хүний 3 нь л улсаас хөгжүүлэх бодолтой байгаа, бусад нь хувиа бодсон хүмүүс байдаг. УИХ-ын сонгуулиар 2 тал яг адилхан хөгшин хүмүүст хадаг, цай өгөөд л, залууст нь архи өгөөд явж байсан. Би тэр жижиг зүйлийг хахууль гэж үзэхгүй.  
Өмнөговь аймгийн фокус бүлгийн хэлэлцүүлгээс*

"Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал" чанарын судалгаа. НСХ 2004 он

Хүний эрхийн төлөөлөгчдийн ажиглалт, баримтуудаас дүгнэхэд сонгуулийн санал худалдан авах явдал өмнө нь будаа гурил өгөх хэлбэрээс хэтэрдэггүй байсан бол улам нарийн төвөгтэй болж, албан тушаалын наймаа, албан тушаалаа ашиглах авилгалын шинж төрхийг хэдийнээ олжээ.

Аймгуудад гарсан сонгогчдын саналыг худалдан авахыг зорьсон хууль бус үйлдлүүд нь ихэвчлэн албан тушаалаа ашиглах явдлаас үүдэлтэй байгаа нь өнөөгийн төрийн албан хаагчид ёс суртахууны хувьд ихээхэн доогуур, албан тушаалаа авч үлдэж байвал ямар ч хуулийг зөрчихөд бэлэн байгааг илтгэн харуулна.

Удаа дараагийн сонгуульд ажиглагч, хэсгийн хорооны гишүүнээр ажиллаж байсан туршлагатай хүмүүс дээрх нөхцөл байдлыг дүгнэхдээ ихэвчлэн энэ асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэдэггүй, түүнчлэн бэлэг сэлт ба авилгалын зааг ялгааг нарийвчлан гаргаагүйгээс үүсэж байна гэж үзсэн.

*...Гарсан зөрчлүүдийг хуулиар шийдвэрлэж чадаагүй гэж би бодож байна. Тухайлбал сонгуулийн хуулиндаа мөнгө, бэлэг сэлт өгөхийг хориглоно гээд тов тодорхой заагаад өгчихсөн байдаг гэтэл ийм зүйл сонгууль болгонд гардаг, үүнийг хуулийн дагуу шийдвэрлэсэн нь байхгүй. Тэр үедээ сонин хэвлэлүүдээр шуугиж байгаад л өнгөрдөг. Энэ мэт явдлуудыг дор дор нь хуулийн дагуу шийдвэрлэдэг, хатуу хариуцлага тооцдог бол ийм явдал гарахгүй байх боломжтой. Тэгэхээр би юу гэж хэлэх гээд байна гэхээр хуулиа шинэчилж болно. Ийм шаардлага ч зүй ёсоор байгаа гэхдээ хамгийн гол нь гарсан хуулиа биелэлтэнд нь маш их анхаарах хэрэгтэй.*

*...Сонгуулийн нарийн бичгийн дарга, тойрог, хэсгийн хорооны дарга нарт маш сайн хяналт тавьж байх шаардлагатай. Мөн бэлэг, авилгал хоёрын зааг ялгааг хуулиндаа нарийн зааглаж өгөх хэрэгтэй. Ингээгүйгээс хариуцлага тооцоход хүндрэл урирч байна. Аймаг, сумын сонгуулийн хороод хэсэгтээ үүрэг, даалгавар өгсөн хэрнээ яаж ажил төрлөө явуулж байгааг нь хянадаггүй.  
Дархан Уул. Эксперт ярилцлага*

"Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал" чанарын судалгаа. НСХ 2004 он

УИХ, орон нутгийн Сонгуулийн хуулийн зүйл заалтуудыг өөрчлөн шинэчлэх нь ихээхэн чухал бөгөөд шинэчлэснээр бүх асуудал шийдвэрлэгдэхгүй, хуулийн биелэлтэнд анхаарах нь чухал байна.

**Сонгогчдыг айлган сүрдүүлэх, дарамтлах нь**

Иргэдийн сонгох, сонгогдох улс төрийн эрхийг ноцтой зөрчсөн сонгогчдыг айлган сүрдүүлэх дарамтлах явдал амьдрал дээр тийм их дэлгэрсэн зүйл биш атлаа, бас багагүй тохиолддог зүйл болохыг иргэдийн хариултаас харж болно.

**Сонгогчдыг айлган сүрдүүлэх, дарамтлах.**

	УИХ		Орон нутгийн сонгууль	
Нэлээд их гардаг	136	13.6%	76	7.6%
Ер нь гардаг	182	18.2%	141	14.1%
Хааяа нэг гардаг	15	15.5%	167	16.7%
Гардаггүй	512	51.2%	596	59.6%
Хариулаагүй	15	1.5%	20	2%

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” тоон судалгаа НСХ 2004 он. Хүснэгт 3

Ялангуяа УИХ-ын сонгуулийн үеэр айлгах, дарамтлах зүйл ямар нэг хэмжээгээр гардаг гэж иргэдийн 30 гаруй хувь өгүүлсэн нь ихээхэн түгшүүртэй зүйл болно. Сүүлийн үед улс төрийн сонгуульд нэр дэвшигчид зохион байгуулалттайгаар, хүмүүсийг хүчээр санал өгүүлэх явдлууд гарсаар байгаа нь үүнтэй холбоотой.

Иргэдийг айлган сүрдүүлэх байдлаар санал өгүүлэх явдал ихэвчлэн төрийн алба эрхэлж буй шийдвэр гаргагчдын зүгээс доод тушаалын хүмүүстээ нөлөөлөх хэлбэрээр илэрч байна.

Түүнчлэн эрүүгийн элементүүдийг зориудаар цуглуулж, өөрийн өрсөлдөгчийг сэтгэл санаа болон бие махбодийн хувьд дарамтлах явдлууд ч мэр сэр гарч байв. Ялангуяа Улаанбаатар хотын БЗД, Налайх, СХД-үүдэд ийм төрлийн сүрдүүлэг”рекет ч гэж ярьдаг” гарч байсан нь баримтаар батлагддаг боловч, сонгуулийн зөрчил гомдлын хэлбэрээр бүртгэгдээгүй болно.

Тухайлбал Баянзүрх дүүрэгт 2004 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшин өрсөлдсөн С.Отгонбаяр, Ж.Гүррагчаа нарын дахин санал хураах ажлын үеэр эрүүгийн элементүүдийг/“Мэйрэн ЖАГАА” гм/ МАХН-аас нэр дэвшигч Ж.Гүррагчаагийн сонгуулийн штаб өөрийн сонгуулийн хэсэгт мөнгө амлан татаж, залуучуудыг зохион байгуулж хүчээр санал өгүүлэх, шаардлагатай гэж үзвэл айлган сүрдүүлэх зорилгоор ажиллуулж байсан баримт бий.

Ийм тохиолдол хааяагүй гардаг аж. Харин саяхан болж өнгөрсөн орон нутгийн сонгуулийн үеэр Өмнөговь аймагт сонгогчийг дарамтлан санал өгүүлэх явдал гарсан байна.

*Нэр дэвшигч Амаржаргал 16-17-ны өдөр амраагүйгээр барахгүй цэргийн ангийн байранд байнга байж бүх цэргүүдийг жагсааж командлан санал өгүүлсэн. Нэр дэвшсэн цагдаагийн хэлтсийн дарга нь санал авах байрны гадаа машинтайгаа ирж зогсож байсан сонгогчдод дарамт үзүүлэх нэг оролдлого юм. Энэ хүний нэр дэвшсэн тойргийн санал авах байрнуудад 5-7 цагдаа байнга байсан ба бүр дотор нь ороод суучихсан байлаа. Өмнөговь. Ажиглалт.*

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” чанарын судалгаа. НСХ 2004 он

Албан тушаалаа ашиглаж, бусдыг сүрдүүлэх, дарамтлах байдлаар хүний чөлөөтэй сонгох эрхэд халдаж байгаа ийм төрлийн үйлдлийг хуулийн хүрээнд шийдэж чадахгүй, хуулинд ч хэрхэн шийтгэх талаар дурдаагүй энэ нөхцөлд тухайн үзэгдэл улам бүр хүрээ хязгаарын хувьд тэлсээр байх болно.



**Нэр дэвшигчдийн сурталчилгаанд төрийн өмч хөрөнгө, төсвийн мөнгийг хууль бусаар зарцуулах нь**

Төрийн аль ч түвшний удирдах албан тушаалтнууд өнөөдөр хууль сахиулахын чухлыг байнга сануулдаг атлаа, сонгууль ойртох тутам, улс төржих, албан тушаалаа ашиглах, ялангуяа сонгуулийн хууль тогтоомжийг ихээхэн зөрчих болсон нь иргэдийн амьдралд алхам тутам тааралдаж байна.

**Нэр дэвшигчдийн сурталчилгаанд төрийн өмч хөрөнгө, төсвийн мөнгийг хууль бусаар зарцуулах тухай**

	УИХ		Орон нутгийн сонгууль	
Нэлээд их гардаг	248	24.8%	177	17.7%
Ер нь гардаг	240	24%	231	23.1%
Хааяа нэг гардаг	182	18.2%	203	20.3%
Гардаггүй	323	32.3%	371	37.1%
Хариулаагүй	7	0.7%	18	1.8%

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” тоон судалгаа НСХ 2004 он. Хүснэгт 4

Иргэдийн хариултыг үзүүлсэн хүснэгтээс дүгнэхэд төрийн өмч хөрөнгө, төсвийн мөнгийг сонгуулийн сурталчилгаанд хууль бусаар ашиглах явдал УИХ-ын сонгуулийн үед ер нь гардаг гэж иргэдийн бараг тал хувь(48.8%) нь үзжээ.

Энэ хувь хэмжээ орон нутгийн сонгуулийн үеэр ч мөн адилаар(40.8%) байгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Дээрх мэдээлэл нь сонгуульд төрийн бүх шатны албан тушаалтнууд төрийн өмч болох машин тэрэг, утас, байр зэргийг сурталчилгаандаа ашигладаг, зарим тохиолдолд төсвөөс мөнгө төгрөг завшин өөрийн сонгуулийн сурталчилгаандаа ашигладаг болохыг баталж буй хэрэг юм.

*Төрийн өмч хөрөнгө төсвийн мөнгийг сурталчилгаандаа зарцуулсан талаар орон нутгийн сонгуулиас жишээ дурдахад Баянхонгор аймгийн 29-р тойрогт нэр дэвшсэн Д.Алагаа эмч нарын үзлэг зохион байгуулж сонгуулийн өдөр эмнэлэг дээр үзлэг хийн саналаа өгөхийг уриалсан явдал. Эмч сонгуулийн сурталчилгаандаа эмнэлгийн машиныг ашиглан үзлэг зохион байгуулж эм тариа тараах өвчтөнүүдийг олноор нь эмнэлэгт хэвтүүлэн санал худалдаж авах зөрчлүүд гаргаж байв.*

ХЭҮК –ийн Итгэмжлэгдсэн Төлөөлөгчдийн авсан чанарын судалгаа. 2004 он

УИХ ба орон нутгийн сонгуулийн хуулийн аль алинд нь энэ заалт байдаг боловч амьдрал дээр хамгийн их зөрчигддөг. Хууль тогтоомж хэрэгжихгүй, мөн энэхүү сөрөг үзэгдэлтэй тэмцэх байгууллага тэр бүр байхгүй байгаа нь нөхцөл байдлыг улам даамжруулахад хүргэж байна.

**Нэр дэвшигчдийн сурталчилгаанд төрийн байгууллагын ажилчдыг дайчлан ажиллуулах**

Өнгөрсөн сонгуулийн туршлага, зарим сургамжаас харахад нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгаандаа өөрийн байр суурь, нэр хүндийг ашиглан төрийн байгууллагын ажилчдыг дайчлан ажиллуулах явдал ихээхэн гарч байв.

**Нэр дэвшигчдийн сурталчилгаанд төрийн байгууллагын ажилчдыг  
дайчлан ажиллуулах**

	УИХ		Орон нутгийн сонгууль	
Нэлээд их гардаг	237	23.7%	200	20.0%
Ер нь гардаг	240	24%	217	21.7%
Хааяа нэг гардаг	178	17.8%	231	23.1%
Гардаггүй	331	33.1%	343	34.3%
Хариулаагүй	14	1.4%	9	0.9%

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. Хүснэгт 5

Төрийн байгууллагын ажилчдыг дайчлуулан ажиллуулах явдал УИХ болон орон нутгийн сонгуулийн аль алинд нь гардаг гэж иргэд үзсэн. Төрийн байгууллагын ажилчид нэр дэвшигчдийн сурталчилгаанд ажиллах хэлбэр нь янз бүр байна.

Зарим нь өөрийн албан тушаал, эрх мэдлийн хүрээнд зайлшгүй үзүүлэх ёстой төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхдээ дэмжиж буй нэр дэвшигч дээрхийг хийсэн мэтээр олон нийтэд ойлгуулан сурталчилгаандаа ашиглах тохиолдол байдаг.(төсвийн мөнгөөр зам тавих, цалин тэтгэврийг олгох, ОУ-ын тусламж дэмжлэгийг өөрийн биеэр сонгогчдод тараах гм.)

Гэтэл нэг хэсэг нь ойр дотны хүмүүс буюу нутгийн иргэдтэйгээ танилцуулах замаар ажил хэргийг нь бүтээж өгөх зэрэг зуучлалын үүрэг гүйцэтгэж, сонголтод нь нөлөөлөх замаар асуудлыг шийдвэрлэхийг оролддог байхад, зарим нь өөрийн мэргэжлийн дагуух сонгуулийн штабын тодорхой албыг хариуцан ажилладаг.

Түүнчлэн сүүлийн үед гарч буй сонгуулийн үе дэх нэгэн булхайт үйлдэл бол өөрийн мэдэлд ажилладаг төрийн бүхий л албан тушаалтнуудыг нэр дэвшиж буй тойрогтоо ажиллуулах нэрийдлээр санал өгүүлэх явдал юм. Энэ асуудал өмнөх УИХ-ын сонгуулиар нэлээдгүй тохиолдож байсныг СЕХ-нд ирсэн зөрчил, гомдлын баримтууд нотолдог.

Энэ талаар Увс аймагт МАХН-аас нэр дэвшигч хэрхэн зөрчсөнийг харвал,

*МАХН-аас нэр дэвшигч Д.Туяа нь төрийн албан тушаалыг ашиглан албан хаагч сургуулийн багш нар, ЕБС-ийн насанд хүрээгүй хүүхдүүд түүний эцэг эхээр нь дамжуулан сонгуулийн сурталчилгаа хийсэн... баримтыг дурдаж болно.*

Ардчилсан нийгэмд зүй нь аливаа нэг албан тушаалтан суудлаа хэвээр хадгалахын тулд нэр дэвшигчийн сонгуульд төрийн байгууллагын үйлчилгээг хүргэх нэрийдлээр барьцаа хэлбэрээр ажиллах бус харин өөрийн сайн дурын үндсэн дээр дэмжин оролцож болох билээ.

Ялангуяа хөдөө орон нутагт дээрх зөрчил ихээхэн даамжирсан байдгийг дараах жишээнээс харж болно.

*...МАХН-аас нэр дэвшигчдийн бараг 100% төрийн болон төсвийн, ААН байгууллагуудын дарга, удирдах ажилтнууд байсан учраас сонгуулийн сурталчилгаанд албан тушаалаа дээд зэргээр ашиглаж, 10-р сарын 1-нээс эхлэн аймгийн ба Зуунмод сумын ЗДТГ нь дежур, үйлчлэгчдээс өөр ажилтангүй, бүгд 27 суманд хуваагдан сонгуулийн сурталчилгаанд ажилласан байна.*

*Өөр багаас тухайн багт шилжиж ирээд олон жил болсон, албан ёсоор бүртгүүлсэн, нөгөө багаасаа хасуулсан боловч иргэний үнэмлэх дээр хаягийн наалт хийлгээгүй шалтгаанаар олон хүн сонгох эрхээ эдэлж чадаагүй.*

*Төв аймаг*

ХЭҮК –ийн Итгэмжлэгдсэн Төлөөлөгчдийн авсан чанарын судалгаа. 2004 он

Төрийн байгууллагын ажилчдыг дайчлан ажиллуулах явдал төрийн албан хаагчдын хувьд ихэнхид нь тохиолдож байгаа зүйл юм. Нэг талаас энэ нь нэр дэвшигчийн амлалтад үндэслэдэг бол нөгөө талаас өөр албан тушаал

горилох буюу суудлаа хамгаалж үлдэх гэсэн хүлээлтээс бий болдгоороо ялгаатай юм.

**Сонгуулийн сурталчилгааны үеэрх нэр дэвшигчдийн хууль бус үйл ажиллагааны талаарх иргэдийн кэйс**

Өмнөх сонгуулиудын туршлагаас харахад сонгуулийн сурталчилгаа хийхдээ нэр дэвшигчдийн зүгээс зохион байгуулалттайгаар хууль бус үйл ажиллагаа явуулах нь ихээхэн тохиолдож байлаа.

Амьдрал дээр нэр дэвшигч бус нэр дэвшигчийн удирдлаган доор ажиллаж байгаа сонгуулийн баг сонгогчийн эрхийг ихээхэн зөрчиж байгаа нь харагддаг.

Юуны өмнө нэр дэвшигчид нь сонгогчдын өмнө тулгарч буй асуудлыг шийдвэрлэх, шийдвэрлэхээр амлах, архи, тамхи, будаа, гурил тараах, хуульд заасан хугацааг зөрчин ухуулга сурталчилгаа хийх зэрэг нь санал худалдаж авах гэсэн олонтаа тохиолдож буй хууль бус хэлбэрүүд мөн. УИХ-ын болоод орон нутгийн сонгуульд өрсөлдсөн гол хоёр нам, эвслийг жишээ болгон авч үзье.

*...Сонгуулийн санал авах өдрийн өмнөх шөнө нь ухуулга сурталчилгаа явуулж байсан. Мөн хуулинд таавар бооцооны тухай дурдаагүйн улмаас тэд сурталчилгаа нэрээр Эх орон-Ардчилал эвслээс нэр дэвшигч Ч.Эрдэнэбаяр хэдэн хүний санал авахыг таасан хүмүүсийг шагнана гээд 50.000 төг-ний хонжвортой сугалаанд татан оролцуулж байлаа.*

*Нэр дэвшигчийн туслахууд айлуудаар архи өвс тарааж байсан. Дорнод аймаг. Хэрлэн сум*

*... МАХН-аас нэр дэвшигч Ж.Жанцан “Дарь-Эх”-ийн гэр хорооллын айлуудад будаа, гурил тарааж бүх гэр хорооллын худагт МАХН-аас үнэгүй ус өгч байсан. Улаанбаатар хот. Баянзүрх дүүрэг*

ХЭҮК –ийн Итгэмжлэгдсэн Төлөөлөгчдийн авсан чанарын судалгаа. 2004 он

Түүнчлэн сүүлийн үед нэр дэвшигч төдийгүй улс төрийн томоохон институтын түвшинд (улс төрийн нам гэх мэт) хувьд зохион байгуулалттайгаар сонгогчийн эрхийг зөрчих явдал түгээмэл болж байгаа нь харамсалтай. 2004 онд болж өнгөрсөн УИХ-ын сонгуулиар Ардчилсан намаас сонгуулийг зориуд зохион байгуулалттайгаар булхайтай явуулахаар зэхэж байсан тухай сонин хэвлэлээр шуугиж байгаа нь бас л бодууштай зүйл.

Саяхан болсон орон нутгийн сонгуулиар судалгаа хийсэн хүний эрхийн ажиглагч “МАХН-аас орон нутгийн штабт өгсөн зөвлөмж” нэртэй баримт бичгийг өөрийн судалгаандаа хавсаргажээ. Түүнд Сонгуулийн сүүлийн хоногийн зарим тактикийн тухай нэрийн доор...*намын гишүүдийг ашиглан, намын нэг гишүүн дор хаяж хоёр хүнийг санал өгүүлэхээр ажиллах, үр хүүхэд, хамаатан садан, найз нөхөддөө нөлөөлөх, дэмжлэг үзүүлэх, урамшуулах... сонгогчдоос нэр дэвшигчдийн хэнд нь саналаа өгөхөө шийдээгүй байгаа буюу ямар нэг тусламж өгсөн хүнд нь саналаа өгнө гэсэн байр суурьтай хүмүүстэй тулж ажиллах... өрсөлдөгчийн үйл ажиллагааны цагийн хуваарийг мэдэж, арга хэмжээнд нь аль болохоор өөрийн хүнийг оруулж, эсрэг арга хэмжээ авч байх гэх мэтээр дурджээ.*

Энэ нь улс төрийн сонгуульд хүний сонгох эрхийг зөрчих нь нийгмийн институтуудыг хамарч, зохион байгуулалттай шинжтэй болж байгааг илчилж байна.

Ийм нөхцөл байдал нь сонгуулийн хуулийн 6. 23 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг зөрчсөн бөгөөд дээрх үйлдлийг гаргасан этгээдийг 40.000-50.000,

нам, эвсэл, талархан дэмжигч этгээдийг 200.000-250.000 төгрөгөөр торгохоор хуулинд тусгасан байдаг. Аливаа хуулинд хийхээр завдсан үйлдэл ба эс үйлдэлд хариуцлага хүлээлгэх үндэслэл бий.

Гэтэл өнгөрсөн сонгуулийн хугацаанд дээрх зүйл заалтын дагуу хуулийн хариуцлага хүлээсэн нэг ч нэр дэвшигч, улс төрийн нам байхгүй.

УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн үеэр нам эвсэл, нэр дэвшигчдийн ухуулга сурталчилгааны үеийн зөрчлүүд ихээхэн тохиолдож байгаа нь сонгуулийн хуулийн дээрх зүйл заалтуудыг өнөөгийн бодит хэрэгцээнд нийцүүлэн өөрчлөх шаардлагатайг илтгэнэ.

### **Сонгуулийн санал өгөх байранд гардаг сонгох, сонгогдох эрхийн зөрчлийн тухай**

Сонгуулийн санал өгөх байранд иргэдэд чухам ямар бэрхшээл, сонгох эрхийг нь зөрчсөн ямар үйлдлүүд тохиолдож байсныг дараах хэд хэдэн зүйлээр задлан авч үзвэл,

- нэрсийн жагсаалтад нэр байхгүй
- санал өгөөгүй боловч өгсөн гэсэн тэмдэглэгээ хийгдсэн үндэслэлгүйгээр саналын хуудас өгөхөөс татгалзсан
- сонгуулийн хэсгийн хорооны ажилтны зүгээс таны саналд нөлөөлөх тодорхой оролдлого гаргасан
- ажиглагчдын зүгээс нөлөөлөхийг оролдсон
- орон нутгийн эрх мэдэлтнүүд сонгогчдын санал өгөхөд нөлөөлөхийг оролдсон
- санал өгч буй бусад хүн сонгогчид хэн нэгнийг сонгохыг зөвлөх буюу албадсан
- тамга тэмдэггүй, гарын үсэггүй саналын хуудсаар санал өгүүлсэн

### **Сонгуулийн санал өгөх байранд санал өгөх үед гарч байсан хууль бус тохиолдлууд**

	Тохиолдож байсан		Тохиолдож байгаагүй		Хариулаагүй		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Нэрсийн жагсаалтад нэр тань байхгүй	65	6.5	822	82.2	113	11.3	1000	100%
Санал өгөөгүй боловч өгсөн гэсэн тэмдэглэгээ хийгдсэн	22	2.2	865	86.5	113	11.3	1000	100%
Үндэслэлгүйгээр саналын хуудас өгөхөөс татгалзсан	17	1.7	870	87.0	113	11.3	1000	100%
Сонгуулийн хэсгийн хорооны ажилтны зүгээс таны саналд нөлөөлөх тодорхой оролдлого гаргасан	50	5.0	844	84.4	106	10.6	1000	100%
Ажиглагчдын зүгээс нөлөөлөхийг оролдсон	38	3.8	854	85.4	108	10.8	1000	100%
Орон нутгийн ТАХ-аас санал өгөхөд нөлөөлөхийг оролдсон	50	5.0	838	83.8	112	11.2	1000	100%
Санал өгч буй бусад хүн танд хэн нэгнийг сонгохыг зөвлөх буюу албадсан	118	11.8	771	77.1	111	11.1	1000	100%
Тамга тэмдэггүй, гарын үсэггүй саналын хуудсаар санал өгүүлсэн	11	1.1	879	87.9	110	11.0	1000	100%
Хууль бус сонгогчоор санал өгүүлэхийг оролдсон	44	4.4	840	84.0	116	11.6	1000	100%

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. Хүснэгт 6

УИХ-ын сонгуулийн үеэр санал өгч буй бусад хүн хэн нэгнийг сонгохыг зөвлөх буюу албадах явдал нэлээдгүй гардаг(11.8) байна. Түүнчлэн нэрсийн жагсаалтанд нэр нь байхгүй байх\*(6.5), сонгуулийн хэсгийн хорооны ажилтны зүгээс саналд нөлөөлөх тодорхой оролдлого гаргах, орон нутгийн ТАХ-аас санал өгөхөд нөлөөлөхийг оролдох (5.0) явдлууд хааяагүй гардаг гэж болно.

Сонгуулийн ажилтны (ялангуяа ажиглагч) зүгээс иргэдийн саналд нөлөөлөх оролдлогууд УИХ-ын сонгуулийн үеэр ихээхэн гарч байсан бөгөөд иргэдийг саналаа өгөхөөр ирэх үед гадна нь угтаж авах, аман ухуулга хийх явдал түгээмэл тохиолдож байсан нь баримтаар батлагддаг.

Орон нутгийн сонгуулийн үеэр дээрх нөхцөл ерөнхийдөө ойролцоо бөгөөд санал өгч буй бусад хүн хэн нэгнийг сонгохыг зөвлөх буюу албадах тохиолдол гарч байсан (7.4) ба нэрсийн жагсаалтанд нэр нь байхгүй тохиолдол УИХ-ын сонгуулиас 0.5 пунктээр илүү буюу 7.0 хувьтай байгаа нь нэлээд өндөр үзүүлэлт юм.

Хүний эрхийн ажиглагч нарын сонгуулийн үйл явцад мониторинг хийх нэгэн чиглэл бол сонгуулийн нэрсийн жагсаалтыг хаягаар тулган шалгаж, нэрсийн жагсаалтын зөрчил, гомдол хэр зэрэг гарах талаар судлах явдал байв. Судалгааны дүнг харвал бараг бүх аймагт сонгогчийн нэрсийн жагсаалтыг үнэн зөв гаргахтай холбоотой зөрчлүүд гарчээ.

Эдгээрийг нийтэд нь авч үзвэл: Нэрсийн жагсаалтаас нас барсан, шилжин явагчдыг хасаагүй, байнгын оршин суугчдыг бүртгэхгүй байх, нэрсийн жагсаалтын хаяг оршин суугаа газрын хаяг хоёр зөрөх, тэр ч байтугай нэг гэр бүлийн хүмүүсийг өөр өөр хаягаар бүртгэх зэрэг нь сонгуулийг будлиантуулах, улмаар сонгогчийн эрхийг бүдүүлгээр зөрчих үндэс болж байна. Түүнчлэн орон нутгийн сонгуулийн үеэр шилжилт хөдөлгөөн хийгдээгүй олон хүн саналаа өгч чадаагүй байна.

*...Нэрсийн жагсаалтыг бэлэн болгосныг хүлээн авч түүврээ хийсний дараа 38 хүнтэй уулзахад 3 нь иргэний үнэмлэхгүй, огт байхгүй 5 хүний нэрийг/ нас барсан болон шилжсэн/ бүртгээд өнгөрсөн байлаа.  
Говь-Алтай. ХЭК-ийн ажиглагч.*

*...Тухайн аймагт нэрсийн жагсаалтаас 100 иргэнийг сонгон авч нэрсийн жагсаалттай тулган үзэхэд өөр газар шилжсэн 8 хаяг буруу буюу хаа байгаа нь мэдэгдэхгүй 16 хөдөө байгаа 3 үнэмлэхээ үрэгдүүлсэн 1 оюутан 6 нийт зөрчил бүхий 34 хүн зөрчилтэй байна.  
Говьсүмбэр. ХЭК-ийн ажиглагч*

*...Тус аймгийн 7-р тойргийн 178-р хэсгийн сонгогчдын/100/ нэрсийн жагсаалтыг түүвэрлэн шалгахад 22 иргэн зөрчилтэй гарсан бөгөөд байхгүй өөр газар ажиллахаар явсан оюутан шилжсэн зэрэг шалтгаануудыг дурдаж байв.  
Нэрсийн жагсаалтаа 178-р хэсэг шинэчлээгүйн улмаас хаягийн бүртгэлгүй байсан 2 иргэн өөр хэсэгт очин саналаа өгсөн байна.  
Баянхонгор. ХЭК-ийн ажиглагч*

*...Сонгуулийн 48-р хэсгийн нэрсийн жагсаалтыг шалгахад байнгын оршин суугч нэрсийн жагсаалтанд байхгүй шилжин явсан 22 нас бараад 1 жил болсон хүн нэрсийн жагсаалтанд байгаагүй зэрэг зөрчлүүд илэрсэн.  
Дундговь. ХЭК-ийн ажиглагч*

ХЭҮК –ийн Итгэмжлэгдсэн Төлөөлөгчдийн авсан чанарын судалгаа. 2004 он

Эдгээр зөрчлүүд нь нэг бол сонгогчийн буруугаас, эсвэл нэр дэвшигчийн хууль бус санал худалдаж авахаар зориуд бэлтгэсэн бусармаг үйл ажиллагаанаас, мөн сонгуулийн хэсгийн хорооны ажилтнуудын мэдлэг,

боловсрол дорой буюу зориудын хариуцлагагүй үйл ажиллагаанаас болж ихэвчлэн гарсан байна.

Ялангуяа сонгуулийн ерөнхий хороонд ирсэн зөрчил гомдлын материалаас харахад сонгуулийн хэсгийн хорооны ажилтанд өгч байгаа цалин урамшуулал ихээхэн бага байдаг нь тэднийг ажилдаа идэвхгүй хойрго хандах, ажлын ээлж өнгөрөөх, улмаар авилгал, хээл хахууль авах сонирхлыг өдөөх нэг хүчин зүйл болдог байна.

Орон нутгийн сонгуульд санал өгөх үед иргэдэд тухайн орон нутгийн ТАХ-аас нөлөөлөх зарим оролдлого хийгдэж байсан(4.2%) талаар иргэд нуугаагүй юм. Гэхдээ нөлөөлөх дээрх оролдлого нь тэр бүр ил биш, далд хэлбэрээр хийгдэж байдаг нь судалгаанаас харагдсан.

*...Багийн засаг дарга нарыг сонгуулийн хэсгийн хорооны бүрэлдэхүүнд оруулж байгаа нь орлого багатай ядуу амьдралтай сонгогчид багийн даргаар дамжин олгогддог аливаа тусламж тэтгэлгээ алдахгүйн тулд тэдний хэлсэнээр сонголт хийж байгаа тул эрх нь зөрчигдөж байна гэж үзэхээс өөр аргагүй юм.  
Баян-өлгий*

*...Хэсгийн хорооны гишүүн нь МАХН-аас нэр дэвшигчийн төрсөн эгч байсан тул санал хураалтын явцад иргэдийн сонгох эрхийг зөрчин нөлөөлж байсан.  
Увс аймаг*

ХЭҮК –ийн Итгэмжлэгдсэн Төлөөлөгчдийн авсан чанарын судалгаа. 2004 он

### Сонгуулийн санал өгөх байранд санал өгөх үед гарч байсан зөрчлүүд.

	Тохиолдож байсан		Тохиолдож байгаагүй		Хариулаагүй		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Нэрсийн жагсаалтад нэр тань байхгүй	70	7.0	804	80.4	126	12.6	1000	100%
Санал өгөөгүй боловч өгсөн гэсэн тэмдэглэгээ хийгдсэн	15	1.5	855	85.5	130	13.0	1000	100%
Үндэслэлгүйгээр саналын хуудас өгөхөөс татгалзсан	20	2.0	849	84.9	131	13.1	1000	100%
Сонгуулийн хэсгийн хорооны ажилтны зүгээс таны саналд нөлөөлөх тодорхой оролдлого гаргасан	35	3.5	837	83.7	128	12.8	1000	100%
Ажиглагчдын зүгээс нөлөөлөхийг оролдсон	26	2.6	841	84.1	133	13.3	1000	100%
Орон нутгийн ТАХ-аас санал өгөхөд нөлөөлөхийг оролдсон	42	4.2	825	82.5	133	13.3	1000	100%
Санал өгч буй бусад хүн танд хэн нэгнийг сонгохыг зөвлөх буюу албадсан	74	7.4	792	79.2	134	13.4	1000	100%
Тамга тэмдэггүй, гарын үсэггүй саналын хуудсаар санал өгүүлсэн	8	0.8	861	86.1	131	13.1	1000	100%
Хууль бус сонгогчоор санал өгүүлэхийг оролдсон	20	2.0	850	85.0	130	13.0	1000	100%

"Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал" судалгаа НСХ 2004 он. Хүснэгт 8

Орон нутгийн сонгуулийн үеэр сумдад сонгогчдын нэрсийн жагсаалт гаргахад багийн дарга нар өөрсөддөө ашигтай сонгогчдын нэрсийг түүж өөр багийн хүнийг өөрийн нэр дэвшиж байгаа багт оруулах явдал ихээр гарч байсныг Говь-алтай аймгийн Хүний эрхийн ажиглагч баримтад түшиглэн

өгүүлсэн бол, сонгуулийн 25-р тойргийн 7, 8-р хэсгийн нэрийн жагсаалтаас 232 хүнийг хассан, сонгуулийн хуулийн 30.3-д заасан саналын хуудсыг тоолох үедээ үндэслэлгүйгээр хүчингүй болгох явдал гарч байсныг Дундговь аймгийн Хүний эрхийн ажиглагч сонгуулийн үйл явцад мониторинг хийх явцдаа тэмдэглэжээ.

Орон нутгийн сонгуулийн үеэр хэсгийн хорооны ажиглагчид зүгээс иргэдийн саналд нөлөөлөх тодорхой оролдлого гаргаж байсныг баримт болгон өгүүлэхэд,

*Сумын ЗДТГ-ын түшмэл /нэр дэвшигчийн эгч/ сумын сонгуулийн хорооны ажилтай нэрээр байн байн ирж сонгогчдод нөлөөлж байсан. Хэсгийн хорооны дарга байнга гадаа гарч сонгогчдыг дуудан уулзах чихэнд нь үг шивнэх зэргээр хууль бус үйлдэл гаргаж байв. Хэсгийн хорооны гишүүн Цэнд кабин дээр үүрэг гүйцэтгэж байхдаа 1-ийг дугуйл гэж байнга хэлж байсан. Өмнөговь аймаг*

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” чанарын судалгаа. НСХ 2004 он

*Сонгуулийн хэсгийн хорооны гишүүн нь сонгогчид саналын хуудас өгөхдөө нэр дэвшигчийн нэрийг гараар заан үүнийг дугуйл гэж хэлж илэрхий зөрчил гаргасныг хажууд нь зогсож байсан сонгогч хүртэл хэлж буруутгаж байсан. Хэсгийн хорооны даргын зүгээс тухайн гишүүнийг буруу үйлдэл хийж байгааг сануулсан байна. Хөвсгөл аймаг*

*11-р тойрогт хэсгийн хорооны дарга Рэгээдмаа зөврийн хайрцаар санал авахдаа намуудын төлөөлөл оролцуулалгүйгээр зөвхөн өөрөө хайрцаг авч яеж маршрут зөрчиж өөр хүмүүс дээр очиж санал авсанаас гадна замдаа өөрөө саналын хуудас дугуйлж хийсэн нь баригдаж түүнийгээ өөрөө хүлээсэн. Төв аймаг*

ХЭҮК –ийн Итгэмжлэгдсэн Төлөөлөгчдийн авсан чанарын судалгаа. 2004 он

Иргэдийн сонгох, сонгогдох эрхийн хэрэгжих явцад гардаг нийтлэг, түгээмэл зөрчилд анализ хийсэн эл бүлгийг дараах байдлаар товч дүгнэж болно.

- Сонгуулийн өмнөх болон санал өгөх үеийн нөхцөл байдлыг тоон болон чанарын судалгааны үндсэн дээр авч үзэхэд хүний сонгох ба сонгогдох эрхтэй холбоотой зөрчлүүдийг багасгах, цаашилбал арилгахын тулд олон зүйлсийг хийх шаардлагатай байна.
- Монгол улсын иргэний сонгох, сонгогдох эрхэд тулгамдаад байгаа асуудлуудыг тогтоож, ялангуяа хүний эрхийг гажуудуулж байгаа зөрчлийн шалтгаан нөхцөлийг тодорхойлох, хүний улс төрийн сонголтын эрхийн асуудалд хандах шинэ хандлагыг төлөвшүүлэх хүрээнд нэн даруй дараах зүйлсэд онцлон анхаарах нь чухал байгаа болно.
- Улс төрийн эрхийн хүрээн дэх хүний эрхийн зөрчил нь нэг талаас иргэдийн мэдээлэлт байдал, эрхээ эдлэх чадвар, нийгмийн идэвхи санаачлагаас, нөгөө талаас улс төрийн сонгуульд сонгогдохоор “улайрсан” нэр дэвшигчдийн хууль бус, бусармаг үйлдлүүдээс шалтгаалан гардаг байна.
- Хүний сонгох, сонгогдох улс төрийн эрхийг хангах нь бусад эрхийн адил төрийн үндсэн зорилт, үндсэн хуулийн чиг үүрэг билээ. Гэтэл амьдралд УИХ ба орон нутгийн сонгуулийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх шатанд бэрхшээл учрах төдийгүй, олон тооны зөрчлүүд гарсаар байна. Тухайлбал хамгийн их гардаг зөрчлүүдийг УИХ ба орон нутгийн сонгуулийн жишээн дээр авч үзэхэд дараах зүйлс орж байна. Үүнд:

**Сонгуулийн сурталчилгааны явцад**

<i>УИХ-ын сонгууль</i>	<i>Орон нутгийн сонгууль</i>
<ul style="list-style-type: none"> <li>Нэр дэвшигчид нэг нэгнээ үндэслэлгүйгээр гүтгэн доромжлох-44.5</li> <li>Сонгогчдын саналыг авахын тулд худал ойлголт амлалт өгөх-34.3</li> <li>Сонгогчдын саналыг худалдан авах-31.5</li> <li>Төрийн өмч хөрөнгө, төсвийн мөнгийг сурталчилгаанд хууль бусаар зарцуулах-24.8</li> <li>Төрийн байгууллагын ажилчдыг сурталчилгаанд дайчлан ажиллуулах-23.7</li> <li>Сонгогчдыг айлган сүрдүүлэх дарамтлах-13.6</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Төрийн байгууллагын ажилчдыг сурталчилгаанд дайчлан ажиллуулах-20.0</li> <li>Сонгогчдын саналыг авахын тулд худал ойлголт амлалт өгөх-18.9</li> <li>Нэр дэвшигчид нэг нэгнээ үндэслэлгүйгээр гүтгэн доромжлох-18.7</li> <li>Төрийн байгууллагын ажилчдыг сурталчилгаанд дайчлан ажиллуулах-17.7</li> <li>Сонгогчдын саналыг худалдан авахыг оролдох-14.9</li> <li>Сонгогчдыг айлган сүрдүүлэх дарамтлах-7.6</li> </ul>

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. Хүснэгт 9

**Сонгуулийн санал өгөх байранд**

<i>УИХ-ын сонгууль</i>	<i>Орон нутгийн сонгууль</i>
<ul style="list-style-type: none"> <li>Санал өгч буй бусад хүн хэн нэгнийг сонгохыг зөвлөх буюу албадсан-11.8</li> <li>Нэрсийн жагсаалтад нэр нь байхгүй-6.5</li> <li>Сонгуулийн хэсгийн хорооны ажилтан нөлөөлөхийг оролдсон-5.0</li> <li>Төрийн албан хаагчдаас санал өгөхөд нөлөөлөхийг оролдсон-5.0</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Санал өгч буй бусад хүн хэн нэгнийг сонгохыг зөвлөх буюу албадсан-7.4</li> <li>Нэрсийн жагсаалтад нэр нь байхгүй-7.0</li> <li>Төрийн албан хаагчдаас санал өгөхөд нөлөөлөхийг оролдсон-4.2</li> <li>Сонгуулийн хэсгийн хорооны ажилтан нөлөөлөхийг оролдсон-3.5</li> </ul>

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаа НСХ 2004 он. Хүснэгт 10

- Орон нутгийн сонгуулийн үеэр иргэд өөрсдийн төлөөллийг сонгож байгаа утгаараа сонгох сонгогдох эрхийн зөрчил харьцангуй бага байгаа нь ололттой боловч УИХ-ын сонгуулийн үеэр гарсан олон зөрчлүүдээс улбаалан өссөөр байгааг дээрх хүснэгтээс харж болох юм.
- УИХ-ын сонгуульд харьцангуй олон нэр дэвшигчид өрсөлддөг ба тэр хэмжээгээр өрсөлдөгчид нэг нэгнээ гүтгэн доромжлох нь түгээмэл тохиолддог бол, орон нутгийн сонгуулийн үед төрийн байгууллагын ажилчдыг сонгуулийн сурталчилгаанд дайчлан ажиллуулах явдал элбэг гэсэн дүн гарчээ.
- Сонгогчдын нэрсийн жагсаалтыг үнэн гаргадаггүйгээс 100-130 гаруй сонгогчийг нэмж бүртгэсэн ба сонгогчдыг машинаар зөөх, зөөврийн хайрцгаар санал авахад зөвхөн нэг ажилтнаа явуулж тэр нь нэр дэвшигчийн ах дүү хамаатан садны хүн байх зэрэг булхай илэрч байгаа болно./Ховд, Төв аймаг/
- Оюутнууд их байгаа тохиолдолд сонгогчийн шилжих хөдөлгөөний асуудал ихээр тавигдаж байна. Ховдод гэхэд 130 гаруй оюутан бүртгэлгүй газраа сонгууль өгсөн гэсэн мэдээ байна.
- Сонгуулийн өмнөх сурталчилгаа, сонгуулийн санал өгөх байранд гардаг хууль тогтоомжийн зөрчлийг харьцуулж үзэхэд сонгуулийн хууль тогтоомжийн зөрчил ихэвчлэн сурталчилгааны үед, нэр дэвшигчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн гарч байна.



## Товч дүгнэхүй

“Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” мониторинг судалгааны хүрээнд

- Сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтэнд нөлөөлөх хүчин зүйлсийн анализ буюу сонгуулийн хороод байгуулах, сонгогчдыг шаардлагатай мэдээллээр хангах, нэрсийн жагсаалт гаргах, сонгуулийн сурталчилгааны явц, сонгогчид нууцаар, чөлөөтэй саналаа өгөх нөхцөл зэргийг шинжлэн
- Иргэдийн сонгох, сонгогдох эрхийг зөрчих, бүрэн утгаараа хэрэгжих явцад учирч буй бэрхшээл, хүндрэлийг тодорхойлох үүднээс иргэд, нэр дэвшигчид, улс төрийн нам эвслээс гаргаж буй өргөдөл, гомдолд шинжилгээ хийх, нийтлэг зөрчлүүдийг тоймчлон судлах
- Сонгуулийн талаарх олон нийтийн санал бодол, тэдний үнэлэмжийг тодруулах зэрэг хүчин зүйлсийг судлах зорилт тавин хэрэгжүүллээ.

Тайлангийн бүтцэд орсон бүлэг бүрийн эцэст тодорхой дүгнэлт, зөвлөмж боловсруулсныг давтан нуршихгүйгээр дараах товч дүгнэлт, зөвлөмжийг толилуулж байна.

### **Сонгуулын хороодыг байгуулах ба тэдгээрийн үйл ажиллагаа:**

- Сонгуулийн хороодыг байгуулахдаа нам эвсэл, нам бусчуудын төлөөллийн тэнцвэртэй байдал алдагдах, хороодыг хуульд заасан хугацаанаас хоцорч байгуулах, нам эвслүүдийн зүгээс нам бусчуудын төлөөллийг оруулахад саад тотгор учруулж, хориг саад тавих нь ердийн зүйл болжээ.
- Иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо бараг үгүй болсны зэрэгцээ сонгуулийн хороонд ажилласан хүмүүс илүү цагаар болон ажлын бус өдрүүдэд ажилласныхаа хөлсийг авч чаддаггүй зэргээр тэдний эдийн засгийн баталгаа алдагдах болсон байна.
- Төрийн зүгээс сонгуулийн хороодод ажиллах эерэг сэдэл төрүүлэх, тэнд ажилласан хүмүүсийн эдийн засгийн болоод эрх зүйн баталгааг орхигдуулж, мэдлэг боловсролтой, чадварлаг, шударга иргэдийг татан оролцуулах механизмыг өнөө хүртэл бий болгоогүйн улмаас сонгуулийн үеэр эдгээр хороодод ажиллах хүн олдохгүй болж, боловсон хүчний хомсдолд орох болсон байна.
- Сонгуулийн аливаа шатны хороодыг байгуулах үйл явцыг ил тод болгож, түүнд байх төлөөллийн асуудлыг зохицуулж чадахуйц эрх зүйн орчин бүрдүүлж, тэдгээрийн бүрэлдхүүнийг нөлөө бүхий улс төрийн нам эвслүүд хоорондоо тохиролцон хувааж авах шударга бус зарчмыг халах, нам бусчууд, болоод бусад хүчнийхний оролцоо, хяналтыг хангаж чадахуйц механизмыг бүрдүүлэх шаардлагатай байна.
- Сонгуулийн хороонд ажиллаж буй хүн шударга, хэн нэгний дарамт шахалтанд орохгүй байх нөхцлийг хангах, тэдний эдийн засгийн болоод бусад баталгааг хуульд маш тодорхой зааж өгөх нь тумгамдсан шинжтэй болж байна.
- Сонгуулийн хороодын зүгээс иргэдэд сонгуулийн санал хураалт явагдах байр, цаг хугацаа, журмыг бүгдэд нь хүртээмжтэй зарлан мэдүүлэх явдал атал дээрх мэдээллийг иргэдэд хангалттай хүргэж

чаддаггүйгээс иргэдээс сонгох эрхээ эдлэхийг тодорхой хэмжээгээр хумиж байна. Сонгуулийн санал хураалт хаана, хэдий хугацаанд явагдах талаар иргэдийн 50-60 гаруйхан хувь нь хангалттай, эргэлзээгүй мэдээлэлтэй байсан нь анхаарал татах асуудлын нэг мөн.

### **Сонгогчдын нэрсийн жагсаалт гаргах тухайд**

- Сонгогчдын нэрсийн жагсаалтыг хуульд заасан журмын дагуу үйлдэх үүргийг хүлээсэн холбогдох шатны засаг дарга нар өөрсдийн албан үүрэгтээ хайхрамжгүй хандаж, нэрсийн жагсаалттай холбогдон үүсэх зөрчлийн суурийг тавьдаг болжээ.
- Нэрсийн жагсаалтыг гаргаж, сонгуулийн хэсгийн хороонд хүргэх хуулийн хугацааг хэтрүүлэх, оршин суугчдын нэр овог, хаяг, иргэний үнэмлэх, регистрын дугаарыг буруу бичих, шилжилт хөдөлгөөнийг цаг тухайд нь бүртгэж байгаагүйн улмаас хий хүнийг жагсаалтанд оруулах, орох ёстой хүнийг орхигдуулах, орох ёсгүй хүнийг зориуд, санаатайгаар бүртгэх зэрэг хууль бус үйлдэл нийтлэг болсон байна.
- Түүнчлэн нэрсийн жагсаалтыг хугацаа хожимдуулан үйлдэх, олон нийтэд ил тавьж танилцуулах журам, хугацааг зөрчих нь аль ч шатны сонгуулийн үед нийтлэг, ердийн үзэгдэл болж хувирсан иргэдийн сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтэнд сөргөөр нөлөөлж байна.
- Сонгогчдын нэрсийн жагсаалт гаргах талаарх хуулийн өнөөгийн заалтууд нь тодорхой бус, дутуу дулимаг боловсруулагдсанаас хүний сонгох, сонгогдох эрхийн зөрчлийг автоматаар төрүүлэх сөрөг механизм болж хувирсан байна.
- Иймд нэрсийн жагсаалт гаргадаг бүх шатны засаг дарга нарын үүрэг хариуцлагын тогтолцоог нарийвчлан тодорхойлж, хуульчлах, сонгуулийн хороодоос сонгогчдын нэрсийн жагсаалтад хяналт тавих үйл ажиллагааны үр дүнтэй, оновчтой, шударга механизмыг бий болгох шаардлагатай байна.
- Нэрсийн жагсаалтад тавих олон нийтийн хяналтыг хүчтэй өрнүүлэх, хүний эрхийн болоод сонирхогч төрийн бус байгууллагуудын үр өгөөжтэй оролцоог нэмэгдүүлэхүйц тогтолцоог бүрдүүлэх, энэ тухай хуульчлан заах хэрэгтэй юм.
- Хаана оршин суух нь хүний эрх мөн авч сонгуультай холбогдон зохиомлоор үүсдэг шилжилт хөдөлгөөн нь эцсийн дүндээ хүний язгуур эрх түүний дотор хүний сонгох, сонгогдох эрхийг бүдүүлгээр зөрчихөд хүргэж байгаа тул түүнийг зохицуулж чадах эрх зүйн тогтолцоог бий болгох замаар нам эвсэл, нэр дэвшигчдийн зүгээс сонгогчдыг өөртөө татаж, хаягийн шилжүүлэг хийлгэдэг бохир технологийг хааж, таслан зогсоож чадах өөрчлөлтийг хуульд оруулах, хууль зөрчсөн үйлдлийнхээ төлөө тэдний хүлээх хариуцлагыг чангатгах шаардлагатай болжээ.

### **УИХ, орон нутгийн сонгуульд нэр дэвшигчийг тодруулах үйл явц**

- Бүх ард түмний хүсэл зоригийн илэрхийлэл байх ёстой сонгууль улс төрийн нам, тэдний лидерүүдийн хүссэн загвараар явагдаж,

УИХ-ын болоод орон нутгийн сонгуульд нэр дэвшигчдыг сонгохдоо цөөн тооны удирдагчдын хүрээнд хувийн үнэнч байдал, хөрөнгө чинээний үзүүлэлт зэрэг тэвчишгүй шинжүүдийг шалгуур болгох явдал даамжирч байна.

- Эрх зүйн зохицуулалт хангалтгүйгээс Монгол улсын иргэн бүр төрийн байгууллагад нэрээ дэвшүүлэх эрхтэй гэсэн хуулийн заалт цаасан дээрх тунхаглалын шинжтэй болж, иргэдийн сонгогдох эрх дан ганц улс төрийн намаас шууд шалтгаалдаг эрүүл бус тогтолцоо бий болжээ.
- Орон нутгийн сонгууль чухамдаа нутгийн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлэх үндсэн арга зам авч, түүнийг үзэл сурталжуулан, намын харьяаллаар нь оршин суугчдыг хагаралдуулан зөрчилдүүлэх явдал гаарсан нь хүний сонгох, сонгогдох эрхийг зөрчих зөрчлийн үндсэн хэсэг болж байна.
- Улс төрийн намуудын дотоод ардчилал хангалтгүй, намын сахилга бат, эрх ашгийн нэр дор ард түмний язгуур ашиг сонирхлыг огоорох байдал түгээмэл байгаа нөхцөлд нэр дэвшигчдыг дэвшүүлэх механизмыг боловсронгуй болгох, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх нь тумгамдсан асуудал болж байна.
- Саналын хуудсанд нэр дэвшигчдээс гадна бүгдийн эсрэг санал өгөх гэсэн сонголтыг оруулж өгөх нь иргэдийн сонгох эрхэд эерэгээр нөлөөлөх, заавал хэн нэгэн нэр дэвшигчын төлөө санал өгөхийг албадсан одоогийн байдлыг халах, нэр дэвшүүлэх субъектын хариуцлагыг дээшлүүлэх нэгэн хөшүүрэг болох юм.

**Сонгуулийн үхүүлга, сурталчилгаа ба сонгох, сонгогдох эрхийн тухайд:**

- Олон нийтийн дунд сонгууль шударга бус болдог гэсэн ойлголт улам бүр нэмэгдэж байна.
- Сонгуульд нам эвсэл, нэр дэвшигчын зүгээс янз бүрийн биелэгдэшгүй амлалт өгөх, энэхүү хоосон амлалтуудаараа өөр хоорондоо өрсөлдөх, уралдах нь газар авч хүний сонгох, сонгогдох эрх зөрчигдөх үндсэн шалтгааны нэг болж байна.
- Нэр дэвшигчдээс сонгогчдын саналыг худалдан авах, ингэхийн тулд мөнгө эд зүйл тараах, үүнийгээ сонгуулийн компанит ажлынхаа салшгүй нэг хэсэг болгож буй нь хүний сонгох, сонгогдох эрхийн нэгэн нийтлэг зөрчил мөн
- Нэр дэвшигчдийн зүгээс өрсөлдөгч рүүгээ дайрч довтлон гүтгэхийг гол баримжааллаа болгохын хамт өөрийн тухай худал магтсан хуурмаг мэдээлэл тархаах нь жирийн зүйл болсон нь иргэний сонгох, сонгогдох эрхэд ноцтой харшилж байна.
- Нам эвсэл, нэр дэвшигчдын ийм хариуцлагагүй үйлдлээс болж олон нийтийн дунд бэлэг сэлт, мөнгө төгрөг хүлээсэн сэтгэлгээ бий болж саналаа худалдах, сонгуульд оролцохгүй байх зэрэг сөрөг хандлага даамжирч байна.

**Санал хураах, тоолох үйл явц ба хүний сонгох, сонгогдох эрх:**

- УИХ болоод орон нутгийн сонгуулийн үед сонгогчдыг зөөвөрлөх, саналын байрны ойролцоо амдан уулзаж янз бүрийн аргаар

санал өгөхөд нь нөлөөлөх явдал түгээмэл болох хандлагатай байна.

- Эдгээр сонгуулиудын үеэр санал өгөх байр дотор сонгогчдын саналд нөлөөлөх гэсэн хууль бус үйлдлүүд гарч байгаа боловч энэ нь нийтлэг бус бөгөөд ерөнхийдөө саналаа нууцаар гаргах эрхийн хэрэгжилт харьцангуй хэвийн, санал өгөх байрны засалт зэрэг нь хуулийн хүрээнд байна гэсэн дүгнэлт хийж болно.
- Санал өгөх байран дахь ажиглагчдын суудлын байршил нь тэдний зүгээс өөрсдийн хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэх боломж олгохгүй /ялангуяа нэрсийн жагсаалтын тулгалт, саналын хуудас олгох гм/ байх явдал ажиглагдаж байна.
- Зөөврийн хайрцгаар санал авах үед унаа тэрэгний хүрэлцээгүй байдал, сонгуулийн хороодын гишүүдийн шударга бус үйлдлээс хамааран хүний сонгох, сонгогдох эрх зөрчигдөх нь цөөнгүй байна.
- Монголчуудын амьдралын онцлог зарим хүчин зүйлсээс болж / гэрт, ам бүл олуулаа амьдрах гм/ зөөврийн хайрцгаар санал авах үед саналаа нууцаар гаргах эрх зөрчигдөхөд хүрч байгаа бөгөөд бага оврын зөөврийн кабин зэрэг нэмэлт хэрэгсэл шаардлагатайг харуулж байна.
- Нэрсийн жагсаалтанд нэр нь байхгүй эсвэл бичиг баримтын зөрчилтэй байх, хуруун дээр тэмдэглэгээ / ялангуяа хөдөөгийнхөн, ахмадуудын хувьд / хийх зэргээс үүдэн гарч буй зөрчил саналын байранд гарч буй зөрчлийн дийлэнх болж байна.
- Саналын хуудас тоолох үйл явц нь хуулийн хүрээнд болж өнгөрдөг нь ажиглалтын судалгаанаас харагдаж байгаа бөгөөд зарим нэгэн зөрчил гардаг хэдий ч төдийлөн түгээмэл, ноцтой бус юм.

Эцэст нь дурдахад Монгол улсад иргэний сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийг хангах анхдагч нөхцлүүдээс хамгийн тулгамдаж буй шийдвэрлэвэл зохих асуудалтай холбогдсон дараах товч зөвлөмжийг хийж болох юм. Үүнд:

1. Сонгуулийн эрх зүйн орчин, тэдгээрийн үйлчлэх механизмыг боловсронгуй болгох, ингэхдээ УИХ, орон нутгийн болоод Ерөнхийлөгчийн сонгуулийн, Сонгуулийн ерөнхий хорооны болоод улс төрийн намын тухай хуулиуд гэх мэт хүний сонгох , эрхтэй холбогдолтой бүхий л хууль тогтоомжид багц байдлаар хандан, шинэчлэх
2. Иргэдээс саналаа худалдах, бэлэг сэлт авах зэргээр өөрийн язгуур эрхээ хөсөрдүүлэх явдлыг таслан зогсоож чадахуйц тогтолцоо буюу тэдний улс төрийн ухамсарт эергээр нөлөөлөх шинэ механизмыг буй болгох үйл ажиллагаанд төр засаг, ТББ – ууд болон бусад сонирхогч бүлгүүдийн идэвхийг өрнүүлэх,
3. Сонгуулийн Ерөнхий Хорооны зүгээс нэр дэвшигчдийн хууль бус үйлдэлтэй тэмцэх явдлыг эрчимжүүлэх, сонгуулийн бэлтгэл үеэс аваад төгсөх хүртэлх үйл явцыг ил тод байлгахад хэвлэл мэдээллийнхний гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх,
4. Нэр дэвшигчдээс сонгогч олны өмнө хүлээх хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгож хүний сонгох, сонгогдох эрхийг зөрчсөн хууль бус үйлдэл бүрдээ тохирсон хариуцлага хүлээдэг механизмыг бүрэлдүүлэх нь чухал байна.